


Диахона



**Ерөнхийлөгч
Лорензо Снөугийн
амьдрал ба сургаалын
сүнслэг нөлөө, х.12, 18**

Мэргэн Ухааны эрэлд, х.20

**Таны хичээл сурлага ба амьдралын
зорилго, х.54**

Бид үүрдийн анд найзууд байж чадах уу? х.58



*“Бурхантай
харьцуула-
хад хүн юу
ч биш. Гэвч
бид Бурханд
маш чухал.”*

Тэргүүн Зөвлөлийн
Хоёрдугаар зөвлөх,
Ерөнхийлөгч Диетер
Ф.Угдорф, “You
Matter to Him,”
Лиахона, 2011 оны
11-р сар, 20.



ЗАХИАСУУД

- 4** Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Их Эзэний дуу хоолой
Ерөнхийлөгч Хенри Б.Айринг
- 7** Айлчлагч багшийн захиас бичиг: Номлолын ажил

ОНЦЛОГ ӨГҮҮЛЛҮҮД

- 12** Даршилсан өргөст хэмх, манжин ба гэрчлэл: Лорензо Снеүгийн амьдрал ба сургаалын сүнслэг нөлөө
Аарон Л.Вест
Мелкизедек санваартнууд болон Нийгмийн Халамжийн Бүлгийн энэ жилийн судлах цуврал хичээлийн танилцуулга.
- 20** Бурханыг дээдлэн хүндлэх нь Мэргэн Ухааны эхлэл мөн
Ахлагч Нийл Л.Андерсен

- 28** Гэр бүлдээ үр өгөөжтэй заах нь
Даррен Э.Шмидт
- 32** Залуу эмэгтэйчүүд ба номлолд явах шийдвэр
Эдгээр насанд хүрсэн залуу эмэгтэйчүүд нь бүрэн цагийн номлолын үйлчлэлийн талаар өгөгдсөн бошиглогчийн зөвлөгөөг хэрэгжүүлсэн нь.

- 36** Ямар номлол хамгийн сайн байх вэ?
Таны нөхцөл байдлаас үл хамааран ахмад номлогчоор үйлчлэх боломж та бүхэнд бий.

ХЭСГҮҮД

- 8** 10-р сарын Чуулганы тэмдэглэлийн дэвтэр
- 10** Бид Христийн тухай ярьж байна: Цоо эрүүл
Мишель Рейес

- 31** Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимлоос заах нь: Боловсролын үнэ цэнэ

- 38** Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дуу хоолой


- 74** Сүмийн мэдээ

- 79** Гэр бүлийн үдшийн санаанууд

- 80** Биднийг дахин уулзтал: Таван минутын сургамж
Кристофер Ж.Смит

ХАВТСАН ДЭЭР

Нүүр хуудас: К.Р. Сейвижийн авсан Ерөнхийлөгч Лорензо Снеүгийн гэрэл зураг, А.Том Перрийн Тусгай Цуглуулгаас зөвшөөрлийг авч нийтлэв, Харольд Б.Лийгийн Номын сан, Бригам Янгийн Их Сургууль, Конгрессын Номын Сангийн зөвшөөрлөөр нийтлэв, Колумб дүүргийн Вашингтон, Ар талд: Жон Виллард Класонгийн уран зураг © IRI. Нүүрэн талын хавтасны дотор талд: Андрей Шумилингийн авсан гэрэл зураг



42

42 Итгэл, найдвар ба харилцаа

Ахлагч Майкл Т.Рингвуд

Итгэлийн гурван бүрэлдэхүүн хэсэг үүрдийн ханиа сонгож, гэрлэхэд танд хэрхэн тусалж чадах вэ?



54

18 Лорензо Снөугийн тухай илүү ихийг мэдэцгээ

Кристофер Д.Фосс

Ерөнхийлөгч Снөугийн тухай сүнслэг нөлөө бүхий дараах түүхүүдийг та нар мэдэхгүй байж болох юм.

46 Мормоны Номноос хуваалц

Ахлагч Хуан А.Юседа

Мормоны Номноос найзуудтайгаа хуваалцах нь таныг хөрвөлтийн гайхамшигтай аялал руу хөтөлнө.

49 Шат шатаар: Сургаал ба Гэрээ 87:8

Энэ жилийн Мючелийн сэдэв та нарт хаана байх нь аюулгүй болохыг заах болно.

50 2013 оны Мючелийн сэдэв

Залуу Эрэгтэйчүүд, Залуу Эмэгтэйчүүдийн Ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл

Та нар хэрхэн ариун газруудад зогсож болох тухай санаанууд.

52 Агюнга агаарын тенниснээс юу сурсан бэ?

Адам К.Өүлсон

Итгэл найдвартай байх нь бидний амьдралыг хэрхэн адислах вэ?

54 Залуучуудын бат бөх байдлын төлөө: Боловсрол

Ахлагч Крейг А.Кардон

56 Байнга дадлага хий

Виллис Женсен

Төгөлдөр хуурын хичээл авах нь Сүнсийг мэдрэхэд надад туслах юм гэж санасангүй.

57 Үзүүлэн: Ариун газруудад зогсогтун

58 Кайлигын сайн талыг олж харсан минь

Каринн Стейси

Сургуулийн дээрэлхүү хөвгүүнд найз хэрэгтэй байж болох юм гэж ээж минь хэлэв.



66

59 Онцгой гэрч: Би яаж гэрчлэлтэй болж чадах вэ?"

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Роберт Д.Хейлс

60 Манай гэр бүлд зориулсан Бурханы төлөвлөгөө

Марисса Виддисон

Ливайн дүү охин хугацаанаасаа өмнө мэндэлсэн тул түүнд залбирал болон санваарын адислалууд хэрэгтэй байв.

62 Бошиглогчийн мөрөөр: Иосеф Смитийн амьдарч байсан хоёр байшин

Жан Пинбороу

64 Есүсийн тухай түүхүүд: Есүс Христ ба Анхны Үзэгдэл

65 Бидний хуудас

66 Уншихад бэлэн

Мерилли Бурен

68 Хүүхдийн Хэсгийг гэртээ авчрах нь: Тэнгэрлэг Эцэг надад хайртай, надад зориулсан төлөвлөгөө Түүнд бий

70 Бага насны хүүхдүүдэд зориулав

81 Бошиглогчийн хөрөг: Иосеф Смит



Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Түлхүүр үг: "Би Лиахонаг хэрхэн авч болох вэ?"

**2013 ОНЫ НЭГДҮГЭЭР САРЫН ДУГААР 14 NO. 1
ЛИАХОНА 10781 363**

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хенри Б.Айринг,
Диетер Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга: Боид К.Пакер,
Л.Том Перри, Рассел М.Нелсон, Даллин Х.Фукс,
М.Рассел Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хейлс,
Жеффри Р.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л.Кук,
Д.Тодд Кристоферсон, Нийл Л.Андерсен

Эрхлэгч: Крейг А.Кардон
Зөвлөхүүд: Шэйн М.Боуэн, Брэдли Д.Фостер,
Бага Кристоффел Гоулдэн, Энтони Д.Пэркинс

Удирдах захирал: Дэвид Т.Варнэр
Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал:
Винсент А.Ваун

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг
Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон
Гүйцэтгэх туслах редактор: ЛаРене Портер Гаунт
Хэвлэлийн туслах: Мэлисса Зентено

Редакцийн баг: Сюзан Баррет, Раян Карр,
Дэвид Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон,
Минди Эви Фридман, Хикари Лофтус, Лиа МкКланихан,
Майкл Р.Моррис, Ричард М.Ромни, Паул ВанденБерг,
Жулиа Вүүдбери

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:
Ж.Скотт Кнудсен

Зураглал чимэглэлийн удирдагч: Тэдд Р.Петрсон
Уран бүтээлийн ажилтнууд: Жанетт Эндрыус,
Фэй П.Андрус, С.Кимбол Ботт, Томас Чаилд, Керри
Линн С.Херрин, Коллийн Хинкли, Эрик П.Жонсен,
Скотт М.Моои, Брэд Тиаре

Оюуны өмчийн зохицуулагч: Жэйн Анн Петрс
Хэвлэлийн захирал: Жэйн Анн Петерс

Хэвлэх баг: Конни Бөүторп Бриж, Ховард Г.Браун,
Жүүли Бурдетт, Браян У.Гиги, Катлийн Ховард,
Дэнис Көрби, Жинни Ж.Нилсон, Таи Пилчер,
Гэйл Тэйт Рафферти

Хэвлэлийн захирал: Крейг К.Седвик

Хуваарилалт хариусан захирал: Эван Ларсен,
Нэгдсэн Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга
болон үнийн талаар орон нутгийн Сүмийн хангамжийн
төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо
барина уу.

**Гар бичмэл болон асуултаа интернет веб сайт
liahona.lds.org руу; шуудангаар Liahona, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024,
USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch
.org хаягаар ирүүлнэ үү.**

Лиэхона нь (Мормоны Номон дахь утгаараа бол
"луужин" буюу "залагч") албани, англи, армен, бислам,
болгар, вьетнам, гаити, герман, грек, дани, индонез,
ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литва,
малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос,
польш, португали, румын, самоа, себуано, солонгос,
тагалог, тай, тахити, тонга, украин, унгар, урду, фижи,
фин, франц, хорват, хятад, хятад (хялбаршуулсан),
чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд
нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)


© 2013 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх
хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиэхона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувилан
олшруулж болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа
Intellectual Property Office, 50 E. North Temple St., Salt Lake
City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн:
cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:
January 2013 Vol. 14 No. 1. LIAHONA (USPS 311-480)
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year
(January, April, June, July, October, and December) by
The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North
Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price
is \$5.00 per year; Canada, \$6.00 plus applicable taxes.
Periodicals Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days'
notice required for change of address. Include address label
from a recent issue; old and new address *must* be included.
Send USA and Canadian subscriptions to Salt Lake
Distribution Center at address below. Subscription help
line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard,
American Express) may be taken by phone. (Canada Post
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send address changes to Salt Lake
Distribution Center, Church Magazines, PO Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368.

Дэлгэрэнгүй мэдээллийг онлайнаас үзэж болно Liahona.lds.org



НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОРИУЛАВ

12-р хуудсан дээрх өгүүлэлд Мелкизедек санваартнууд болон Нийгмийн Халамжийн Бүлгийн энэ жилийн судлах хичээлийг танилцуулжээ. Хэрэв та гарын авлагыг онлайнаас уншихыг хүсвэл үүнийг **LDS.org**-т орж "Resources"-оос үзнэ үү.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

50-р хуудсан дээр Далын Ахлагч Крейг А.Кардон, боловсрол амьдралын зорилгонд тань хэрхэн нөлөөлөх тухай заажээ. Та боловсролын талаар *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол болон **youth.lds.org**-аас илүү ихийг мэдэж болно.

ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиэхона болон Сүмийн бусад материалуудыг олон хэлээр **www.languages.lds.org**-аас үзэж болно.

ЭНЭ ДУГААР ДАХЬ СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа.

- 2013 оны Мючелийн сэдэв,** 49, 50
- Айлчлагч багшлалт,** 7
- Анхны Үзэгдэл,** 39, 62, 64
- Ариун Сүнс,** 4
- Ариун сүм,** 65, 70
- Боловсрол,** 31, 54, 56
- Бурханлаг шинж чанар,** 68
- Бэрхшээл,** 10
- Гэр бүл,** 28, 60
- Гэрлэлт,** 42

- Гэрчлэл,** 39, 46, 59
- Дуу хөгжим,** 56
- Есүс Христ,** 10
- Залбирал,** 4, 39, 60
- Номлолын ажил,** 32, 36
- Итгэл,** 42
- Мэргэн ухаан,** 20
- Найдвар,** 42, 52
- Нинжин сэтгэл,** 58, 66
- Номлолын ажил,** 7, 38, 40, 41, 46
- Нөхөрлөл,** 58

- Санваарын адислалууд,** 40, 60
- Санхүү,** 20
- Смит, Иосеф,** 42, 62, 64, 81
- Снөү Лорензо,** 12, 18
- Сонгох эрх,** 80
- Судраас судлах,** 28
- Сургаал,** 28
- Сүмийн түүх,** 12, 18, 62
- Эдгээлт,** 10
- Эх хүн,** 10
- Эцэг эх болох нь,** 28



**Ерөнхийлөгч
Хенри Б.Айринг**
Тэргүүн Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх



ИХ ЭЗЭНИЙ ДУУ ХООЛОЙ

Сургаал ба Гэрээ газар бүрийн бүх хүмүүсийг Есүс Христийн дуу хоолойг сонсохыг урьдаг (С ба Г 1:2, 4, 11, 34; 25:16-г үзнэ үү). Энэ ном сонгогдсон бошиглогчдод өгөгдсөн Түүний захиас, сэрэмжлүүлэг болон урам хайрласан үгсээр дүүрэн юм. Бурхан бидний итгэлийн залбиралд хэрхэн заавар, сэрэмжлүүлэг, амар амгалангийн мэдрэмжээр хариулдгийг бид эдгээр илчлэлтээс харж болно.

Бид залбирлаараа дамжуулан Бурхан биднээр юу хийлгэхийг хүсч байгааг, энэ амьдрал болон ирэх амьдралд амар амгаланг олохын тулд бид юу хийх ёстойг тэрчлэн ирээдүйд юу биднийг хүлээж байгааг мэдэхийг эрэлхийлдэг билээ. Сургаал ба Гэрээ нь жирийн хүмүүс болон бошиглогчдын даруухан залбирлаар гуйсан асуултуудад өгсөн хариултуудаар дүүрэн юм. Бид материалаг байдал болон мөнхийн авралын тухай асуултуудаа хариу авахад энэ ном бидэнд үнэ цэнэтэй удирдамж болдог.

Даруу зан болон Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл нь гол түлхүүр юм. Оливер Каудери Мормоны Номыг орчуулахад туслах хүслийнхээ талаар Их Эзэнээс дараах хариуг хүлээн авсан юм: “Итгэлгүйгээр чи юу ч хийж чадахгүй гэдгийг санагтун; тиймийн тул итгэлд асуу. Эдгээр зүйлүүдэд бүү хөнгөн хуумгай ханд; гуйх ёсгүй зүйлийг чи бүү гуй.” (С ба Г 8:10).

Их Эзэн Өөрийнх нь тусламжийг хүлээн авахаас өмнө итгэл, даруу байдал зайлшгүй чухал болохыг Сургаал ба Гэрээнд биднээс дахин давтан шаардсан байдаг. Үүний нэг шалтгаан нь Түүний хариу бидний хүсэн хүлээсэн байдлаар ирэхгүй байж болдог явдал мөн. Нөгөөтэйгүүр хариу хүлээн авах нь үргэлж амар хялбар байдаггүй.

Үүнийг бид Сүмийн түүх болон өвөг дээдсийнхээ туршлагаас харж чадна. Миний элэнц эцэг Хенри Айринг 1855 онд сэргээгдсэн сайн мэдээг заалгасан үедээ юу хийх ёстойгоо мэдэхийн тулд шаргуу залбирахад хариу нь зүүдээр нь дамжин ирсэн юм.

Тэрээр Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Эрастус Снөү, Виллям Браун хоёртой хамт нэг ширээнд сууж байна гэж зүүдэлсэн гэдэг. Ахлагч Снөү сайн мэдээний зарчмуудыг нэг цаг орчим заах шиг болсон гэнэ. Ахлагч Снөү, “Би танд баптисм хүртэхийг Есүс Христийн нэрээр зарлиг болгож байна. Энэ хүн [Ахлагч Браун] . . . танд баптисм хүртээнэ” гэжээ.¹ Элэнц эцэг минь АНУ-ын Миссурийн Сейнт Люист борооны усанд тогтсон цөөрөмд өглөөний 7:30-д даруухнаар баптисм хүртэх итгэлтэй байсанд манай гэр бүлийнхэн баярлан талархаж явдаг. Ахлагч Браун түүнд баптисм хүртээсэн юм.

Залбирлынх нь хариу Их Эзэний сонсогдохуйц чанга дуу хоолойгоор ирээгүй юм. Хариу Лихайд ирсэнтэй



Зүүн талд: Хенри Айринг (зүүн талын гэрэл зураг) Ахлагч Парли П.Праттыг алагдсаны дараа болсон үйл явдлуудыг тэмдэглэлдээ бичжээ (доорх гэрэл зургийг Хенри Айринг авчээ). Зүүн талд байгаа тэмдэглэл дээр түүний хэрхэн алагдсан тухай дурджээ. Тэмдэглэлийн доод талд 1890 онд хэвлэгдсэн Сургаал ба Гэрээ байна.

адил зүүдэнд нь шөнө ирсэн ажээ (1 Нифай 8:2-ыг үзнэ үү).

Залбирлын хариу бас тодорхой мэдрэмж болон ирж болдгийг Их Эзэн бидэнд заасан билээ. Тэрбээр Сургаал ба Гэрээнд “Тийм ээ, болгоогтун, чамд ирж мөн зүрх сэтгэлд чинь орших Ариун Сүнсээр оюунд чинь мөн зүрх сэтгэлд чинь би чамд ярих болно” (С ба Г 8:2) хэмээн Оливер Каудерид заасан юм.

Мөн Тэрбээр Оливерт: “Энэ асуудлын талаар чиний оюунд амар амгаланг би яриагүй бил үү? Бурханаас илүү агуу ямар гэрч чамд байж болох билээ?” хэмээн урам хайрлан дэмжжээ. (С ба Г 6:23).

Сургаал ба Гэрээ, Сүмийн түүх болон баптисмынхаа дараахан үйлчилсэн номлолынхоо талаар Хенри Айрингийн хөтөлсөн түүх нь залбирлын хариу сэрэмжлүүлгийн болон амар амгалангийн мэдрэмжээр ирж болдгийг надад заасан юм.

1857 оны 4-р сард Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Парли П.Пратт АНУ-ын Оклахомад нэгэн чуулганд оролцжээ. Ахлагч Праттын “оюун санаа гутрангуй бодлоор дүүрч . . . ирээдүйг угтан харах

буюу хүнд байдлаас хэрхэн мултрах арга замыг мэдэх чадваргүй байсныг” Хенри Айринг тэмдэглэжээ.² Хенри энэ тухай Төлөөлөгчийг алагдсаны дараахан тэмдэглэсэн ажээ. Бошиглогч Иосеф Картейж шорон руу тэргүүнээ мэхийлгэлгүй очсон шиг Ахлагч Пратт аюулыг мэдэрсэн ч аялалдаа зоригтой гарсан юм.

Их Эзэн итгэлийн даруухан залбиралд үргэлж хариулдгийг би гэрчилж байна. Сургаал ба Гэрээ болон бидний хувийн туршлага залбирлын хариуг хэрхэн таних болон энэ нь удирдамж байна уу, үнэний баталгаа буюу сэрэмжлүүлэг байна уу ялгаагүй хэрхэн итгэлээр хүлээн авахыг бидэнд заадаг билээ. Их Эзэний хайрын дуу хоолойг бид үргэлж анхааралтай сонсож, танин мэддэг байхын төлөө би залбирч байна. ■

Эшлэл

1. “The Journal of Henry Eyring: 1835–1902” (зохиогчийн хэвлэгдээгүй гар бичмэл).
2. “The Journal of Henry Eyring: 1835–1902.”

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

1. Энэ захиас дахь залбирлын тухай догол мөрүүдийг хамтдаа уншихаар төлөвлө. Унших явцдаа Бурхан залбиралд хэрхэн хариулдгийг анхааралтай сонсохыг гэр бүлийн гишүүдээс хүс. Залбирлын ач холбогдлыг гэрчил.

2. Сургаал ба Гэрээ нь залбирлаар асуусан хүмүүсийн асуултуудад өгсөн хариугаар дүүрэн юм. Хэрэв тэдний асуултын хариуг (илчлэлтийг) хэзээ ч тэмдэглээгүй бол юу болох вэ? Сүнсний өдөөлтийг таньж, дагаж сурахад гэр бүлийнхнээ дэмж. Тэд залбирлынхаа талаар өдрийн тэмдэглэлдээ тэмдэглэдэг байвал сайн.

ПАРЛИ П.ПРАТТЫН ГЭРЭЛ ЗУРГИЙГ, СҮМИЙН ТҮҮХИЙН НОМЫН САГНИЙН ЗӨВШӨӨРТӨӨР НИЙТЛЭВ. ХЕНРИ АЙРИНГИЙН ТЭМДЭГЛЭЛ БОЛОН ГЭРЭЛ ЗУРГИЙГ, ЮЛАГИЙН ИХ СУРГУУЛИЙН МААРИОТТ НОМЫН САГНИЙН ТУСТАЙ ҮЗЭЖРИЙН ХЭЛТСИЙН ЗӨВШӨӨРТӨӨР НИЙТЛЭВ. ГЭЭЛ ЗУРГИЙГ ДАВИД СТОКЕР

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Сүнсний өдөөлтийг сонсох нь

Мариа Изабел Молина

Нэг үдэш үеэл маань гэрээсээ дайжин зугтсан учир би түүнийг эрэхээр яаран гарлаа. Тэгээд машин дотроо Сүнсний тусламжийг эрэлхийлж залбирав. Бурхан миний залбиралд хариулж, намайг удирдана гэдгийг би мэдэж байсан болохоор Сүнсний өдөөлтийг сонсохыг хичээлээ. Гэвч юу ч сонссонгүй болохоор урам хугарч, Сүнс надад өдөөлт өгөхгүй юм болов уу гэж бодлоо.

Би үеэлээ эрж олохын тулд цаашаа

явахыг хүсч байсан ч, гэрийнх нь ойролцоогоос л түүнийг хайх хэрэгтэй гэсэн бодол төрөв. Тиймээс би гэрийнх нь хавиар дахиад нэг эргэлээ. Би замын уулзвар дээр зогсож байгаад явган алхах нэг охины дүрсийг харлаа. Энэ чинь манай үеэл охин байна шүү дээ!

Би машинаасаа гарч түүнийг чиглэн гүйхдээ Сүнс түүнийг гэрийнх нь ойролцоо хайх хэрэгтэй гэж намайг чиглүүлсэн болохыг ойлгосон юм.

Би намуухан дуу хоолой сонсогдоно гэж хүлээж байгаад Сүнсний өдөөлтийг золтой л ажиглалгүй өнгөрөөчихсөнгүй. Бид олонх тохиолдолд дуу хоолойг сонсохгүй ч зүрх сэтгэлдээ ямар нэгэн зүйлийг мэдэрдгийг би тэгэхэд ойлгосон юм.

Сүнсний тэрхүү удирдамжийн төлөө би их баяртай байлаа. Тэр үнэхээр надад ирсэн шүү! “Ариун Сүнс чиний байнгын хамтрагч мөн” (С ба Г 121:46) хэмээн сударт өгүүлдэг.

Хэрэв бид Сүнсний удирдамжийг хүлээн авахуйц зохистой байж анхаарал тавих юм бол олон хүмүүст сайныг үйлдэх Бурханы мутар дахь зэмсэг байж чадна. Бид Сүнсстэй байнга нөхөрлөнөөр явах ёстой замаа мэдэх болно.

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Залбирлын сонин учрал

Залбирал олон янзын арга замаар хариулагдаж болно гэдгийг Ерөнхийлөгч Айринг заасан. Та судруудаас адал явдал гэмээр ийм сонирхолтой зүйлсийг олж болно.

Та энэ газрын зургийг ашиглан мэдлэгийн аянаа эхэл. Газрын зураг дээрх судар бүрийг хар. Хоосон шугаман дээр залбирлын хариуны талаар судрууд юу гэж өгүүлсэн тухай товчхон бич.

Хувийн туршлагаасаа болон залбирал хэрхэн хариулагддаг талаар сурч мэдсэн зүйлийнхээ талаар та тэмдэглэлдээ бичиж болно.



1 Иохан 14:26

2

Сургаал ба Гэрээ
6:22–23

3

Сургаал ба Гэрээ
8:2.

4

Сургаал ба Гэрээ
9:8–9



Х

Сургаалт Үгс
8:10–11



Энэ материалыг залбирч судлан гэрт нь очиж заадаг эгч нартайгаа аль болох ойлгомжтойгоор ярилиц. Эгч нарыг бэхжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд тань идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу. Нэмэлт мэдээллийг reliefsociety.lds.org-аас үзнэ үү.

Номлолын ажил

Хожмын Үеийн Гэгээнтнүүд “хүмүүний бодгалиудын авралын төлөө [Их Эзэний] талбайд хөдөлмөрлөхийн тулд” (С ба Г 138:56) илгээгдсэн бөгөөд энэхүү хөдөлмөрт номлолын ажил ордог билээ. Сайн мэдээг хуваалцахын тулд бид албан ёсоор номлолд дуудагдах шаардлагагүй. Бид эргэн тойрон дахь хүмүүсийнхээ амьдралыг сайн мэдээгээр адислахын төлөө өөрсдийгөө бэлтгэвэл Их Эзэн биднийг адислах болно. Айлчлагч багш нар сүнслэг байдлынхаа төлөө хүлээх үүрэг хариуцлагаа баяртайгаар хүлээн авч мөн “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрахад” (Мосе 1:39) нь тэдэнд тусалж чадна.

Бошиглогч Иосеф Смит 1842 онд Нийгмийн Халамжийн Бүлгийг зохион байгуулахдаа эмэгтэйчүүд зөвхөн ядуусыг халамжлах төдийгүй бас хүмүүсийг аврах ёстой хэмээн хэлжээ.¹ Энэ нь өнөөдөр ч бидний зорилго хэвээр байгаа билээ.

“Их Эзэн . . . үнэний тухай гэрчлэлийг бусадтай хуваалцдаг хүмүүст итгэмжлэн олгосон юм” хэмээн Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх, Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф хэлжээ. “Түүгээр ч зогсохгүй Их Эзэн [Түүний] сайн мэдээг баяслын дуугаар тунхаглан, [амаа] бүх цаг



үед нээлтэй байлгахыг’ (С ба Г 28:16) Өөрийн Сүмийн гишүүдээс хүсэн хүлээдэг билээ. . . . Зарим үед гэрчлэлийн ганцхан өгүүлбэр хэн нэгний амьдралд үүрд мөнхөд нөлөөлсөн мартагдашгүй үйл явдал болох нь байдаг.²

Судруудаас

Сургаал ба Гэрээ 1:20–23; 18:15; 123:12

ЭШЛЭЛ

1. Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит (2007), 453-ыг үзнэ үү.
2. Диетер Ф.Угдорф, “Waiting on the Road to Damascus,” *Лиакхона*, 2011 оны 5-р сар, 76–77.
3. *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 92–95-ыг үзнэ үү.



Итгэл, Гэр бүл, Халамж

Бидний түүхээс

Хуучин Чехословакийн Ольга Коваровагийн түүх бол Нийгмийн Халамжийн Бүлгийн түүхэн дэх гишүүн номлогчийн ажлын үлгэр жишээ мөн. Ольга 1970-аад оны үед анагаах ухааны сургуулийн оюутан байсан бөгөөд сүнслэг байдлын хувьд үлэмж өлсөж цангаж байжээ. Тэр 75 настай Хожмын Үеийн Гэгээнтэн Отакар Войковкийг ажигладаг байсан гэнэ. “Тэр надтай анх тааралдахдаа далан тавтай байсан ч сэтгэл санаагаараа бол арван наймт шиг л гялалзаж байлаа. Хүмүүсийн сэтгэл санаа гундуухан байсан тэр үед энэ нь Чехословакт ер бусын хэрэг явдал байлаа” гэж Ольга ярилаа.

Ольга Отакараас тэр болон түүний гэр бүл хэрхэн баяр баясгалантай байж чаддагийг асуужээ. Тэд түүнийг Сүмийн гишүүдтэй танилцуулж, Мормоны Номыг түүнд өгсөн гэнэ. Ольга энэ номыг ихэд амтархан уншиж, удалгүй баптисм хүртэн гишүүнээр батлагджээ. Ольга тэр үеэс эхлэн улс төрийн дарангуйлал ноёрхож, шүтлэг бишрэлийг хавчдаг байсан эх орондоо сайн нөлөө үзүүлсээр ирсэн ажээ. Тэр жижигхэн салбартаа Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчөөр үйлчилж, бусад хүмүүсийг Христэд авчран аврахад тусалжээ.³

Би юу хийж чадах вэ?

1. Би гэрээр нь очиж заадаг эгч нартай гэрчлэлээ хуваалцах үеэр Ариун Сүмний өдөөлтийг дагадаг уу?

2. Би дэмжиж тусалдаг эгч нартаа сайн мэдээнээс суралцахад нь хэрхэн тусалдаг вэ?

10-Р САРЫН ЧУУЛГАНЫ ТЭМДЭГЛЭЛ

“Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, . . . харин миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил” (С ба Г 1:38).


2012 оны 10-р сарын ерөнхий чуулганы талаар эргэн санахын тулд амьд бошиглогч, төлөөлөгчдийн сүүлийн үед заасан зүйлсээс сурч, амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд та нар эдгээр хуудсуудыг (мөн дараагийн дугаарууд дахь Чуулганы тэмдэглэлүүдийг) ашиглаж болно.

ЧУУЛГАНЫ ТҮҮХҮҮД

Бидний уулзалт тохиолдлынх байсан гэж үү?

1983-84 оны нэг их хүйтэн бямба гарагийн орой Монсон эгч бид хоёр Ютагийн Мидвэй-ийн уулархаг нутагт очихоор гарсан юм. Бид тэнд нэг байшинтай бөгөөд тэр орой гадаа хасах 31 хэмийн хүйтэн байсан учир байшингаа шалгахаар явцгааж байгаа нь тэр юм. Тэнд очоод бүх юм хэвийн байсан тул тэр оройдоо буцаж Солт Лейк орохоор шийдэж билээ. Хурдны зам дээр гараад удаагүй байтал машин маань унтраад зогсчихлоо. . . . Их хэцүү байсан шүү. . . .

Хажуугаар машинууд сүнгэнэнэ. Дуртай дургүй бид хоёр ойролцоох хот руу алхаж эхлэв. Аз болоход бидний хажууд нэг машин зогсож дотор нь сууж явсан залуу бид хоёрт туслахыг санал болгосон. . . . Сайхан



сэтгэлт нөгөөх залуу бид хоёрыг Мидвэйд дахь байшинд минь хүргэж өгч билээ. Би түүнд төвөг удсан учир хэдэн төгрөг өгөх гэсэн боловч тэр авсангүй. Тэр өөрийгөө скаут байсан учир аливаа сайн зүйл хийх ёстой гэж байв. Тэгэхэд нь би түүнд өөрийгөө танилцуулж, тэр бидэнд үйлчилсэндээ баяртай байгаагаа хэлсэн юм. Миний бодсоноор тэр номлолд явах насных байсан тул би түүнээс ийм төлөвлөгөөтэй байгаа эсэхийг асуулаа. Тэр яг яах ёстойгоо арай шийдэж амжаагүй байна гэж хариулсан юм.

Дараагийн даваа гарагт нь би тэр залууд захиа бичиж, гаргасан сайхан сэтгэлд нь талархаснаа дахин илэрхийлсэн юм. Тэр захиандаа би түүнийг бүрэн цагийн номлогч болохыг урьж урмын хэдэн үг бичиж билээ. . . .

Ойролцоогоор долоо хоног өнгөрсний дараа тэр залуугийн ээж нь над руу залгасан юм. Тэрээр хүүгээ маш сайн хүн болохыг хэлээд хүүгийнх нь амьдрал тохиолдсон хэдэн зүйлээс болоод түүний номлолд үйлчлэх хүсэл нь буурсан талаар ярилаа. Түүний зүрх сэтгэлийг өөрчлөхийг хүсэн нөхөртэйгэ нийлэн мацаг барин залбирснаа ч тэр хэлэв. . . . Тэр нэгэн хүйтэн үдэш тохиолдсон явдал тэдний залбирлынх нь хариу байж гэдгийг

тэр эх надад хэлсэн юм. Би санал нэг байсан.

Хэдэн сарын дараа, бас хэдэн захиа солилцсоны эцэст тэр залууг Канадын Ванкувер Номлолд гаргаж өгөхдөө Монсон эгч бид хоёр туйлын их баяртай байж билээ.

Тэрхүү жавар тачигнасан 12 сарын үдэш бид таарсан нь тохиолдлын хэрэг үү? Үгүй гэж би баттай хэлнэ. Бүр эсрэгээрээ, бид таарсан нь эцэг эх хоёрынх нь хүүгээ гэсэн чин сэтгэлийн залбирлын хариу байсан гэдэгт би итгэдэг.

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Адислалуудын тухай тунгаан бод” *Лиакхона*, 2012 оны 11-р сар, 88.

Бодож тунгаах асуултууд:

- Номлолд үйлчлэх нь танд болон таны заах хүмүүст хэрхэн тусалж чадах вэ?
- Та номлолд үйлчлэхэд бэлтгэхийн тулд юу хийх вэ?

Өөрийн бодол санааг тэмдэглэлийн дэвтэртээ бичиж, энэ талаар бусадтай харилцан ярилц.

Энэ сэдэвтэй холбоотой нэмэлт материалууд:
Миний сайн мэдээг номло: Номлолын үйлчлэлийн талаарх удирдамж (2004); Рассел М.Нелсон, “Номлогчдоос асуу! Тэд танд тусалж чадна!” *Лиакхона*. 2012 оны 11-р сар, 18–21. Тэд танд тусалж чадна!” *Лиакхона*, 2012 оны 11-р сар, 18–21.



Бошиглогдсон амлалт

“Тэнгэрлэг Эцэг маань бидний хэрэгцээг мэддэг бөгөөд тусалцаа хүсэн Түүнд хандах үед Тэр бидэнд тусалдаг. Бидний санааг зовоодог асуудлууд жижиг эсвэл тийм чухал биш байдаггүй гэдэгт би итгэдэг. Бидний амьдралын мөч бүхэнд Их Эзэн бидэнтэй хамт байдаг.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Адислалуудын тухай тунгаан бод,” *Лиахона*, 2012 оны 11-р сар, 88.

НОМЛОГЧДЫН НАСНЫ ХЯЗГААРТ ОРСОН ӨӨРЧЛӨЛТ

2012 оны 10-р сарын Ерөнхий Чуулганаар Ерөнхийлөгч Томас С.Монсон: “Ахлах сургууль эсвэл үүнтэй дүйцэх боловсрол эзэмшсэн бүх зохистой залуу эрэгтэйчүүд . . . номлолын үйлчлэлээ 19 биш 18

настайдаа эхлэх боломжтой боллоо. . . . Зохистой залуу эмэгтэйчүүд хэрэв хүсвэл 21 биш харин 19 наснаасаа номлолд үйлчлэх боломжтой” хэмээн зарласан (“Чуулганд тавтай морилно уу,” *Лиахона*, 2012 оны 11-р сар, 4, 5).

СУРАЛЦАХ БУЛАН

Зэрэгцээ шугам зурах нь: Жинхэнэ хөрвөлт

Зарим маш чухал сэдвүүд ерөнхий чуулган дээр нэг биш удаа давтагдан яригддаг. Дөрвөн үг хэлэгч жинхэнэ хөрвөлтийн тухай ярьсан. Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг судлахдаа бусад төстэй яриануудыг хайхыг хичээгээрэй.

- “Жинхэнэ хөрвөлт нь . . . Христийн шавь болох ухамсарт амлалтыг шаарддаг.”¹ Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Дэвид А.Беднар.
- “Баптисм хийлгэхдээ бид ‘төгсгөл хүртэл түүнд үйлчлэх шийдвэртэйгээр, [Есүс] Христийн нэрийг өөрсдөдөө авна’ хэмээн амладаг. Моронай 6:3; тодотгол нэмсэн] Ийм гэрээ нь зоригтой хичээл зүтгэл, тууштай ба үнэнч шударга

байдлыг шаарддаг.”²—Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Квинтин А.Кук

- “Бид бол Аврагч Есүс Христийн дагалдагчид юм. Тууштай мөн зорилготой хүчин чармайлтын үр дүнд ийм хөрвөлт ба итгэлтэй байдал бий болдог. Энэ бол маш хувийн шинж чанартай бөгөөд мөнхөд үргэлжлэх үйл явц юм.”³ Залуу Эмэгтэйчүүдийн Ерөнхий Ерөнхийлөгчийн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Анн М.Дибб
- “Бидний гэрчлэл оюун бодол, зүрх сэтгэлд маань гүн суусан үед л бидний бусдыг хайрлах, бусдадаа үйлчлэх хүсэл тэмүүлэл Аврагчийнхтай адил болох болно.”⁴ — Арванхоёр

Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Рассел Баллард

ЭШЛЭЛҮҮД

1. Дэвид А.Беднар “Их Эзэнд хөрвөгдсөн нь,” *Лиахона*, 2012 оны 11-р сар, 107.
2. Квинтин А.Кук “Та нар одоо тийн мэдэрч чадаж байна уу?” *Лиахона*, 2012 оны 11-р сар, 9.
3. Анн М.Дибб “Би үүнийг мэднэ. Би үүний дагуу амьдардаг. Би үүнд хайртай.” *Лиахона*, 2012 оны 11-р сар, 10.
4. М.Рассел Баллард “Санаа сэтгэлээ бүрэн зориулсан байх нь,” *Лиахона*, 2012 оны 11-р сар, 30.

Ерөнхий чуулганы үгсийг conference.lds.org-оос уншиж, үзэж, сонсох боломжтой.

ЦОО ЭРҮҮЛ

Мишель Рейес

Би өрөөсөн гартай байж, ширээний бүтээлгээ хэрхэн сольж, хоолоо хэрхэн хийж, хүүхдүүдээ яаж хүмүүжүүлэх билээ?

Би 17 настай байхдаа автомашины босолд орж, өрөөсөн гаргүй болсон юм. Энэ явдал миний амьдралыг үүрд өөрчилсөн. Хүнд цаг үе, хүнд өдрүүд олон тохиолдсон ч цэвэршүүлэгчийн гал надад Цагаатгалын хүчийг ер бусын замаар гэрчлэх боломжийг олгосон билээ.

Одоо би эхнэр бас эх хүн болсон бөгөөд би энэ хоёр үүрэгтээ хоёуланд нь маш дуртай. Хүүхдүүдээ төрөхөөс өмнө би ер нь эх болж чадах болов уу хэмээн эргэлздэг байсан. Би өрөөсөн гартай байж, ширээний бүтээлгээ хэрхэн сольж, хоолоо хэрхэн хийж, хүүхдүүдээ яаж хүмүүжүүлэх билээ? Арван таван жилийн дараа би таван хүүхдийн эх болсон байв. Би нөхцөл байдалдаа сайн дасан зохицсон болохоор хүүхдүүд маань намайг бусад ээжүүдээс ямар ялгаатайг бараг анзаардаггүй байлаа. Өрөөсөн гаргүй болсон нь саад бэрхшээл байхаа больж, хайрын бэлэгдэл болсон юм. Хүүхдүүд уйлах юм уу шөнө унтахад тэднийг тэврэн саатуулахад өрөөсөн гар минь хэрэг болдог байлаа. Өрөөсөн гар минь олон зүйлд түшиг тулгуур болдог байсан болохоор би үүнийг эмгэнэлтэй зүйлийг сайн зүйл болгон хувиргах Аврагчийн чадварын нотолгоо гэж үздэг байлаа.

Миний өрөөсөн гар хүүхдүүдэд

маань ийм их хэрэгтэй байгааг харахад надад хэчнээн сайхан санагддагийг үгээр дүрслэн хэлэх аргагүй юм. Эх болсон нь миний тахир дутуу болсон бие махбодын дутууг гүйцээж, Цагаатгал аль хэдийн намайг эдгээж эхэлснийг мэдэрсэн юм.

Эх хүний өдөр тутмын үүрэг заримдаа хэцүү байдаг л даа. Хүнд хэцүү үе нь Амилуулалтын үнэн бодит байдал хийгээд намайг эдгээх Аврагчийн хүч чадлын талаар тунгаан бодох шалтгааныг надад өгсөн юм. Тийнхүү судруудахь итгэлийг хөхүүлэн дэмжсэн эдгээлтийн жишээнүүд надад гүн

гүнзгий утга агуулгатай болсон юм. Миний дуртай түүхүүдийн нэг бол Аврагч Америк тив дэх хүмүүс дээр айлчлан очиж, тэдний өвчтэй хүмүүсийг эдгээсэн түүх юм. Би өөрийгөө Аврагчийн эдгээсэн эдгээр хүмүүсийн хэн нэгэнтэй адилтган боддог. Энэхүү шастир Түүний хайрын урилгаар ийн эхэлдэг билээ:

“Та нарын дунд өвчтөнүүд байна уу? Тэднийг нааш авчрагтун. Доголон, эсвээс хараагүй, эсвээс хазгар, эсвээс тахир дутуу, . . . эсвээс ямар нэгэн байдалд зовж зүдэрсэн нэгэн байна уу? Тэднийг нааш авчрагтун мөн би тэднийг эдгээх болно, учир



СОРИЛТТОЙГОО АМЬДРАХ ХҮЧ ЧАДАЛ

“Амьдралын зарим сорилт бэрхшээлийг дэлхий дээр шийдвэрлэх боломжгүй байдаг. Паул ‘махан биед шигдсэн өргөсийг’ зайлуулаач хэмээн гурвантаа гуйхад Их Эзэн, ‘Миний нигүүлсэл чамд хангалттай’ (2 Коринт 12:7, 9) гэж энгийнээр хариулсан юм. . . . Тэрбээр амьдралаа хамгийн үр өгөөжтэйгөөр өнгөрүүлэхэд хангалттай хүч чадлыг Паулд өгсөн билээ. Түүний хүслийн дагуу эдгээгдэж сурахыг мөн биднийг өсч хөгжүүлэхийн тулд Түүний илгээсэн сорилтыг даван туулж амьдрах хүч чадалтай байхыг Тэрбээр та биднээс хүсэн хүлээдэг билээ. Энэ хоёр зүйлд хоёуланд нь Гэтэлгэл таныг дэмжин туслах болно.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г. Скотт, *Ensign*, 1994 оны 5-р сар, 7.



нь та нарыг өрөвдөх сэтгэл надад буй, зүрх сэтгэл минь нигүүлслээр дүүрэв. . . .

“ . . . Учир нь та нарыг эдгээхэд итгэл тань хангалттайг би харж байна.

“ . . . Түүнийг тийн ярихад, бүх цугласан олон, нэгэн зэрэг, өвчтэй мөн зовж зүдэрсэн, мөн доголон, хараагүй, хэлгүй, мөн ямар нэгэн байдлаар зовж зүдэрсэн тэд бүгдтэйгээ урагшлав; мөн тэрбээр тэднийг түүнд авчрагдахад нэг бүрчлэн эдгээв” (3 Нифай 17:7–9).

Миний хувьд энэ түүх бол судруудад дүрслэгдсэн хамгийн сэтгэл догдлом үйл явдал мөн. Миний нөхцөл байдал өөрчлөгдөж, би өрөөсөн гартай ч гэсэн эхийн үүрэг хариуцлагаа гүйцэтгэхдээ баяртай байдаг. Амилуулалт хийгээд цоо эрүүл болох үзэл санааг хамгийн ихээр хүсэн хүлээдэг хүмүүсийн нэг нь би мөн хэмээн нэгэн үе боддог байж билээ. Харин одоо бол би өрөөсөн гаргүйдээ зовдоггүй. Цагаатгал миний амьдралд *одоо л үйлчилж байна гэж би улам бүр боддог болсон*. Эдгээлтийн хүч зөвхөн Амилуулалт хэрэгжих үед нь эхэлнэ гэж бодох хэрэггүйг би ойлгосон. Шөнө болгон хүүхдүүдийн минь хэн нэг нь миний эрүүл гарт тэврүүлэн, зүүрмэглэхийг харсан үедээ би эрүүл саруул байгаагаа мэдэрдэг байлаа. Ийм бодол нь миний хувьд чухамдаа эдгээлтийн гайхамшиг болдог байлаа. Ийм үед би хэнээс ч дутахгүй эрүүл хүн шүү дээ гэсэн бодол намайг эзэмдэг байв. ■

Өрөөсөн гаргүй болсон нь саад бэрхшээл байхаа больж, хайрын бэлэгдэл болсон юм. Хүүхдүүд уйлах юм уу шөнө унтахад тэднийг тэврэн саатуулахад өрөөсөн гар минь хэрэг болдог байлаа.

ЯАГААД НАДАД ИЙМ ЯВДАЛ ТОХИОЛДОВ?

Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн Ахлагч Рональд А.Расбанд 2012 оны 4-р сарын ерөнхий чуулган дээр хэлсэн “Онцгой сургамжууд” сэдвээр хэлсэн үгэндээ энэ асуултанд хариулсан юм:

“Энэ амьдрал бол мөнхийн өргөмжлөлийн бэлтгэл үе бөгөөд энэхүү үйл явц нь сорилт, бэрхшээлүүд юм. Хүн бүрт сорилт бэрхшээлүүд тулгардаг бөгөөд үүнээс хэн ч зайлсхийх аргагүй юм.


Бурханы таалалд итгэн найдах нь бидний мөнх бус амьдралын маш чухал хэсэг юм. Бидний өмнө тулгарч байгаа үй олон асуултын хариу нь хуруу дарам цөөхөн байгаа үед бид Түүнд итгэснээр Христийн Цагаатгалын хүчийг олж авдаг билээ. . . .

Бидэнд хүнд сорилт, хөгжлийн бэрхшээл, өвчин зовлон, уй гашуу, бүхий л төрлийн зовлон зүдгүүр тохиолддог ч гэсэн хайр энэрлээр дүүрэн Аврагч үргэлж бидэнтэй хамт бидний төлөө байх болно. Тэрбээр ийн амласан билээ:

“Би та нарыг өнчрүүлж орхихгүй. Би та наруу ирнэ. . . .

Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай’ (Иохан 14:18, 27).”

Та тулгарсан сорилт бэрхшээлдээ Аврагчийн тайтгарал ба амар амгаланг ямар замаар эрж хайж болох вэ?



Даршилсан ногоо, манжин ба гэрчлэл

ЛОРЕНЗО СНӨҮГИЙН АМЬДРАЛ БА СУРГААЛЫН СҮНСЛЭГ НӨЛӨӨ

Та нар Ерөнхийлөгч Лорензо Снөүгийн сургаалуудыг энэ жил судалснаар түүнийг бошиглогч, үзмэрч, илчлэгч болохыг мөн өгсөн зөвлөгөө нь өнөө үетэй гайхалтай холбоотой болохыг мэдэх болно.

Хэрэв та Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн тавдахь Ерөнхийлөгч Снөүгийн хөргийг харсан бол түүний урт цагаан сахал, дөлгөөхөн царайг нь санах биз ээ. Хэрэв та түүний хөргийг ойроос сайтар харахын тулд хэдэн минутыг зориулбал Ерөнхийлөгч Снөүгийн нүд бага зэрэг алжаасан байдалтай ч ядарсан биш, өндөр настай ч эрч хүч, сэтгэлийн тэнхээгээр дүүрэн хүн болохыг ажиглах биз ээ.

Ерөнхийлөгч Снөү аравны нэгийн тухай заахаар сүнсээр өдөөгдсөнийг та нар сонсон байх мөн Солт Лейкийн Ариун сүмд түүнд тохиолдсон ариун туршлагын тухай ямар нэг зүйлийг та нар санах байх.

Харин юу түүнийг ариун сүмийн тэрхүү туршлага руу хөтөлснийг түүнчлэн үүний үр дүнд юу болсон тухай та нар мэдэх үү? Аравны нэгийн хуулийн талаар түүний хүлээн авсан илчлэлтийн тухай түүхийг та нар мэдэхийг хүсч байна уу?

Түүний нүд, нүүр царайнаас илүү их зүйлийг мэдмээр байна уу? Өөр сүмийн нэг үйлчлэгч Ерөнхийлөгч Лорензо Снөүтэй уулзсаны дараа ингэж бичжээ: “Түүний нүүрэнд амар амгалангийн хүч гэрэлтэнэ, дэргэд нь байхад амар амгалан мэдрэгдэнэ. Дөлгөөхөн харцанд нь ‘нам гүмхэн залбирал’ төдийгүй, сүнсний хүч чадал илхэн харагдана. . . . Би үнэхээр ‘ариун газар дээр зогсож байна уу даа’ гэсэн хачирхмаар мэдрэмж надад төрж билээ.¹ Ийм царай төрхөнд сонирхолтой явдал, сорилт бэрхшээл, амжилт ялалт, уйтгар гуниг, баяр баясгалан хийгээд илчлэлт бүгд нэгдэн нийлсэн байдгийг мэдмээр байна уу?”

Энэ жил Мелкизедек санваартнууд болон Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар *Teachings of Presidents of the Church: Lorenzo Snow (Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Лорензо Снөү)-г судлах болно.*



ТҮҮНИЙ НАМТАР

Лорензо Снөү АНУ-ын Огайогийн Мантуад 1814 оны дөрөвдүгээр сарын 3-нд төржээ. Түүний эх Розетта Снөү, эцэг Оливер Снөү хоёр нь долоон хүүхдээ итгэл бишрэл, ажил хөдөлмөр, үйлчлэл, боловсролд бүхнээс илүү анхаарал тавьдаг гэр бүлд өсгөн хүмүүжүүлсэн ажээ. Эцэг эхийнх нь заасан зарчмууд түүнийг сайн мэдээг баяртай хүлээн авахад бэлтгэсэн ажээ. Тэр Ариун Сүнсний өдөөлтүүд мөн Сүмийн гишүүн эгч Элизагийн зүгээс түүнд үзүүлсэн сайн нөлөөний улмаас 1836 оны зургадугаар сард тэрээр Огайогийн Кертландад Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд элсээ. Түүнээс хойш жил гаруйхан хугацаа өнгөрсний дараа тэр бүрэн цагийн номлогчоор үйлчлэхээр дуудагдав.

Тэрээр дараагийн арванхоёр жилийн турш Нэгдсэн Улс дахь нэлээд хэдэн номлолд үйлчилснээс гадна Хожмын Үеийн Гэгээнтэн анхдагчуудын нэг бүлгийг Солт Лейкийн Хөндий рүү удирдан аваачжээ. Тэрээр эрч хүчтэй, бие сэтгэл бүхнээ Их Эзэний ажилд зориулдаг номлогчийн хувиар Итали, Хавайн арлууд, Нэгдсэн Улсын өрнөд хэсэгт ажилласан юм. Тэрбээр 1849 оны хоёрдугаар сарын 12-нд Төлөөлөгчөөр томилогдов. Тэрбээр мөн Сүмийн удирдлагын бусад салбарт түүний дотор Солт Лейкийн Ариун сүмийн анхны ерөнхийлөгчөөр 5 жил гаруй ажиллажээ. Тэр 1898 оны 10-р сарын 10-нд Сүмийн Ерөнхийлөгчөөр адислагдан батлагдав. Тэр 1901 оны 10-р сарын 10-нд Юта мужийн Солт Лейк хотод нас баржээ.



Та нар Ерөнхийлөгч Снөүгийн сургаалуудыг судалж, сүм дээр болон гэр орондоо ярилцсанаар түүний тухай илүү их зүйлийг мэдэх болно. Та нар түүнийг Бурханы хүн, бошиглогч, үзмэрч, илчлэгч гэдгийг бас түүний зөвлөгөө өнөө үетэй гайхалтай холбоотойг мэдэх болно.

Та бүхний сонирхлыг өдөөхийн тулд энэ жил судлах цуврал хичээл ба түүхүүдийн зарим жишээнээс өгүүлье. Дараах догол мөрүүд дэх бүлэг болон хуудасны дугаарууд нь *Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Лорензо Снөү- номынх юм.*

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Давид А.Беднар хөрвөлтийн үйл явцыг өргөст хэмх даршлах үйл явцтай зүйрлүүлж, нэг ерөнхий чуулган дээр сонирхолтой үг хэлснийг та нар санаж байгаа байх.² Ахлагч Беднар бол энэхүү зүйрлэлийг ашигласан анхны Төлөөлөгч биш юм. Ерөнхийлөгч Снөү үүнтэй адил зүйрлэлийг 150 жилийн тэртээ хуваалцаж байжээ:

“Нэг ширхэг өргөст хэмхийг торх дүүрэн цагаан цуунд дарвал 1 цаг болоод ч, бүтэн 12 цаг болоод ч, үр дүн нь бараг харагдахгүй. Үүнийг гарган үзвэл даршлалт зөвхөн хальсанд нөлөөлсөн байх бөгөөд бүрэн даршлалтад их хугацаа шаардагдах нь харагдана. Энэ сүмд баптисм хүртэх нь тухайн хүнд нөлөөлөх боловч үр дүн нь тэр даруй гардаггүй. Энэ нь тухайн хүнийг 12-24 цагийн дотор өөрчилж чадахгүй. Цагаан цуунд өргөст хэмх удаан даршлагад адилаар, уг хүн зөв сүнс түүнийг дүүргэтэл сүмд явах ёстой.”³

Ерөнхийлөгч Снөү хөрвөлтийн тухай өөрийн туршлага дээр үндэслэн ярьсан байдаг. Тэрээр өөрт нь тохиолдсон хоёр үйл явдлын талаар олонтоо хуваалцаж байсан. Эдгээрийн нэг нь өөрийг нь Сүмд элсэхээс өмнө болсон ба харин удаах нь түүнийг баптисм хүртэж, гишүүнээр баталсны дараахан “зөв сүнсээр дүүрэхэд нь” тусалсан нэг үйл явдал байлаа. Та эдгээр түүхийг 1, 3, 59, 61, 62-р хуудаснаас уншиж болно.

“Хүн яагаад хүмүүсийг ерөнхийлөгчөөр ажиллахаар дуудагддаг юм бэ?” гэж Ерөнхийлөгч Снөү нэг удаа асуужээ. “Нэр хүнд нөлөөтэй болж, үүнийгээ хувийн ашиг



Ерөнхийлөгч Снөү аравны нэгийг төлөх нь адислалууд авчирдаг тухай номложээ. Аравны нэгийг энэ зураг дээрхтэй адил офисуудад хүлээн авдаг байв (Солт Лейк хот, 1880-аад оны үед). Зүүн талд: Ерөнхийлөгч Снөү зарим найз нараа хүлээн авч дайлахад бэлтгэх үеэрээ дүнзэн байшингаа гэрэлтүүлэхийн тулд манжингаар лааны тавиур хийжээ.

сонирхлын төлөө ашиглахын тулд ингэдэг үү? Үгүй, харин ч үүний эсрэгээр Бурханы Хүүд санваар өгөгдсөн тэрхүү зарчмаар үйдэж, золиослол хийх ёстой албан тушаалд тэрээр дуудагддаг. Өөрийнхөө төлөө юү? Үгүй ээ, хүмүүсийнхээ ашиг сонирхлын төлөө. . . . Ах дүүсийнхээ дарга нь биш харин тэдний үйлчлэгч болж, тэдний ашиг сонирхол, сайн сайхны төлөө ажиллахын тулд юм.”⁴


Ерөнхийлөгч Снөү Сүмийн удирдагчийн хувьд энэхүү зарчмыг хэрэгжүүлдэг байсан бөгөөд заримдаа үүнийг хэрэгжүүлэх бүтээлч арга замыг олдог байв. Жишээ нь, тэр нэг удаа зовлон зүдгүүрт өртсөн хэсэг Гэгээнтнүүдийн санаа сэтгэлийг өргөхийн тулд манжин, орны дэвсгэр даавуу, сүрлийг ашиглажээ. Энэ түүх 7-р бүлэгт байдаг. Сүмийн удирдлагын тухай зарим сургаалыг 8-р бүлгээс үзнэ үү.

Ерөнхийлөгч Снөү жинхэнэ удирдагч ямар байвал зохихыг мэддэг байсан учраас хүч нөлөө ихтэй, бүтээлч, хүмүүст нөлөөлж чаддаг удирдагч байлаа. “Эдүгээ дэлхийн үндэстнүүдээс хүмүүсийг цуглуулах агуу ажил хийгдэж байна. Энэ ажил нэг буюу нэг хэсэг хүмүүсийн оюун ухаанд үүсэн бий болоогүй юм. Харин энэ нь Бүхнийг Чадагч Их Эзэнээс үүдэлтэй юм” хэмээн тэрбээр сургажээ.⁵ 85 насны ойгоор нь түүнд хүндэтгэл үзүүлэхээр цугласан Сүмийн гишүүдэд тэрээр хариу талархал илэрхийлэхдээ: “Би ямар нэг зүйлийг хийж гүйцэтгэснийхээ дараа үүнийг Лорензо Снөү биш, харин

Сүмийн Ерөнхийлөгчийн энэхүү албан тушаалд намайг авчирсан туршлагын үр дүн мөн Их Эзэн хийснийг би үргэлж мэдэрдэг” гэжээ.⁶

Тэрбээр энэхүү үнэнийг үргэлж заадаг байсан ба түүнийг Сүмийн Ерөнхийлөгч болохын өмнөхөн түүнд үүнтэй холбоотой нэгэн зүйл тохиолджээ. Тэрбээр 1898 оны есдүгээр сарын 2-нд Ерөнхийлөгч Вилфорд Вудраффыг нас барахад насаар хамгийн ахмад Сүмийн Төлөөлөгч болжээ. Тэрбээр энэхүү хүндтэй үүрэг хариуцлагад өөрийгөө тэнцэхгүй гэж үзэн Солт Лейкийн Ариун сүмийн нэг өрөөнд ганцаараа залбирахаар очсон ажээ. Тэр удирдамж хүссэн ч залбиралд нь хариу ирсэнгүйг мэдэрсэн гэнэ. Тиймээс хэсэг хугацааны дараа өрөөнөөс гарч үүдний уужим өрөөнд оржээ. Тэнд байхад нь залбирлынх нь хариу ирэв. Амилсан Аврагч түүний өмнө шалнаас 1 метр орчим өндөрт зогсож байсан бөгөөд Сүмийн удирдлагын талаар цаашид хэрхэн ажиллавал зохихыг түүнд ярьжээ. Энэхүү туршлагын тухай тодорхой мэдэхийн тулд 20-р бүлгийг үзнэ үү.


Ерөнхийлөгч Снөү аравны нэгийн хуулийн талаар илчлэлт хүлээн авсныг бараг хүн бүхэн мэддэг билээ. Сүмийн гишүүдэд зориулсан энэ илчлэлийг 1899 онд шийдэмгийгээр тунхагласан юм: “Ирээдүйд бэлтгэж, бат бөх суурин дээр зогсохыг хүсдэг Хожмын Үеийн Гэгээнтэн бүр Их Эзэний хүслийг биелүүлж, аравны нэгээ бүрэн төлөх цаг иржээ. Энэ бол та нарт хандсан Их Эзэний үг юм.”⁷



Лоренцо Снөү Солт Лейкийн Ариун сүмд амилсан Их Эзэнийг харсан.

Хожмын Үеийн Гэгээнтнүүд бошиглогчийн энэ зөвлөгөөнд итгэлээр хариулсан бөгөөд үүний ачаар Их Эзэн тэднийг хүн нэг бүрээр болон хамтад нь адисалсан юм. Энэхүү илчлэлтийн нөлөө өнөөдрийг хүртэл үргэлжилсээр байгаа бөгөөд бүх дэлхий даяарх гишүүд аравны нэгийн хуулинд дуулгавартай байснаараа сүнсний болон материалаг адислалуудыг хүлээн авсаар байгаа. Энэ илчлэлт рүү хөтөлсөн үйл явдал болон дараа нь ирсэн адислалуудын тухай 12-р бүлгээс уншина уу.

Бусад бошиглогч бүрийн нэгэн адил Ерөнхийлөгч Снөү Есүс Христийн тухай хүчтэй гэрчлэл хэлдэг байв. Тэрбээр ийн заажээ: “Бид бүгдээрээ Есүс Христээс мөн амар амгалан, аз жаргал, өргөмжлөлийг олж болох замыг бидэнд нээн, дэлхийд ирсэн Түүний ирэлтээс хамааралтай билээ. Хэрэв Тэрбээр энэ ажлыг дуусгаагүй бол сайн мэдээгээр баталгаажсан



эдгээр адислалууд болон онцгой боломжууд бидэнд хэзээ ч ирэхгүй байсан биз ээ.”⁸ Тэрбээр Аврагчийн төрөлт, мөнх бус амьдрал дахь Түүний үйлчлэл, Цагаатгал, Түүний сэргээгдсэн Сүм дэх оролцоо, Хоёр дахь Ирэлтийн тухай гэрчилсэн юм. Есүс Христийн тухай түүний гэрчлэлүүдийг 24-р бүлгээс үзнэ үү.

Мэдээж хэрэг энэхүү богинохон өгүүлэл Ерөнхийлөгч Снөүгийн амьдрал, үйлчлэлийн тухай танд зөвхөн товчхон мэдээлэл өгөх болно. *Teachings of Presidents of the Church: Lorenzo Snow* (Сүмийн Ерөнхийлөгчдийн

сургаалаас: Лорензо Снөү) номыг судлах явцад та сүнс-лэг нөлөө бүхий өөр олон түүхийг, түүний дотор номлогч болж сайн мэдээг анх удаа заасан туршлагынх нь тухай, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад дуудагдсандаа ихэд гайхсан тухай, Атлантын далайгаар аялж явахад нь тохиолдсон аймшигт далайн шуурганы үед сэтгэл санаа нь ямар байсан болон санваарын хүчээр хүний амийг (түүний дотор өөрийнхөө амийг) аварсан дөрвөн удаагийн тохиолдлын тухай олж мэдэх болно. Та янз бүрийн сэдвээрх түүний сургаалуудаас, тухайлбал эв нэгдэл, даруу зан, гэрээнүүд, ариун сүмийн ажил, гэр бүлийн харилцаа, төгөлдөржилтийн төлөө хичээн чармайх, санваар, Нийгмийн Халамжийн Бүлэг болон сайн мэдээг хуваалцсанаас ирдэг баяр баясгалангийн тухай маш их зүйлийг мэдэж болно.

Хэрэв та энэ өгүүлэлд дурдсан түүх болон сургаалуудыг уншиж, тунгаан бодоход цаг гаргах юм уу эсвэл эдгээрийг удалгүй уншихаар шийдвэл Ерөнхийлөгч Снөү таны хүч чармайлтанд сэтгэл хангалуун байх болно гэдэгт та итгээрэй. Тэрбээр насан туршдаа суралцагч байсан бөгөөд бид “үнэний зарчмуудыг гүнзгий ойлгож, “тэнгэрлэг мэдлэгээ дээшлүүлэхийн” тулд “өөрсдийгөө дайчлан ажиллах” ёстой хэмээн сургасан билээ.” Тэрээр, “Өнгөрч байгаа өдөр бүр эсвээс өнгөрч байгаа долоо хоног бүр нь бидний хувьд өмнө нь хэзээ ч байгаагүй хамгийн сайхан байсан үе байвал зохино, ингэснээр бид мэдлэг ба мэргэн ухаанаар, сайныг үйлдэх чадвараар өөрсдийгөө өдөр бүр бага багаар урагш ахиулан хөгжүүлж чадна” хэмээн зөвлөжээ.¹⁰

Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Лорензо Снөү номыг судалснаар таны амьдрал энэ жил улам баялаг агуулгатай болох болтугай. Та нар энэ номыг судлах явцад Ерөнхийлөгч Снөүтэй нүүр тулан уулзсан өөр сүмийн өнөөх үйлчлэгчтэй адил мэдрэмжийг мэдрэх боломжтой. Та Лорензо Снөүгийн энэрэл нигүүлсэл гэрэлтсэн нүүр царай, дөлгөөхөн харцыг хараад өөрийгөө ариун газар дээр байгаагаа мэдрэх болно. Энэ нь та Лорензо Снөүг мэддэг учраас тэр биш харин та өөрийгөө түүний гэрчилдэг Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт илүү ойрхон байгаагаа мэдэрснийх юм. ■


ЭШЛЭЛ

1. Реверенд Прентис, *Teachings of Presidents of the Church: Lorenzo Snow* (2012), 30-д эш татжээ.
2. Дэвид А.Беднар, “Ye Must Be Born Again,” *Луахона*, 2007 оны 5-р сар, 19–22.
3. *Teachings: Lorenzo Snow*, 68.
4. *Teachings: Lorenzo Snow*, 219
5. *Teachings: Lorenzo Snow*, 153.
6. *Teachings: Lorenzo Snow*, 148.
7. *Teachings: Lorenzo Snow*, 157.
8. *Teachings: Lorenzo Snow*, 280–81.
9. *Teachings: Lorenzo Snow*, 65.
10. *Teachings: Lorenzo Snow*, 103.


TEACHINGS OF PRESIDENTS OF THE CHURCH: LORENZO SNOW НОМЫН ОНЦЛОГ ТАЛУУД

Энэ ном таны хувийн болон гэр бүлийн номын сандахь Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас цуврал номуудын дараагийнх нь ном боллоо. Сайн мэдээний олон сэдвээр сүнслэг нөлөө бүхий мэдлэг өгдөг энэхүү цувралд нийт 11 ном багтдаг. Энэ номын гол онцлогуудаас өгүүлье:

- Сайн мэдээний 75 гаруй сэдвээрх Ерөнхийлөгч Лорензо Снөүгийн сүнслэг нөлөө бүхий үгс.
- Лорензо Снөүгийн амьдралын тухай урлагийн бүтээлүүд болон гэрэл зургууд.
- Бүлэг бүр дэх заах болон суралцах гурван төрлийн тусламж нь: тунгаан бодоход түлхэц үзүүлэх асуултууд, тухайн бүлгийн сэдэвтэй холбоотой судрууд, ангийн гишүүдийн оролцоо болон ярилцлагын үр нөлөөг дээшлүүлэхэд туслах заах аргууд юм.
- Гурван хуудас заавар нь энэ номыг судалж, үүнийг гэр бүлд болон сүм дээр сүнсний удирдамжаар заахад гишүүдэд туслах зорилготой юм.



Энэ ном онлайнд LDS.org болон Gospel Library app (англи хэлээр)-д mobile.lds.org-т тавигдсан байгаа.



ЛОРЕНЗО СНӨҮГИЙН ТУХАЙ ИЛҮҮ ИХИЙГ МЭДЭЦГЭЭ

Кристофер Д. Фосс

Энэ жил Нийгмийн Халамжийн Бүлэг болон Мелкизедек санваартнуудын хичээл Ерөнхийлөгч Лорензо Снөүгийн (1814–1901) амьдрал, сургаалууд дээр анхаарал төвлөрүүлэх болно. Зарим насны бүлгийнхэн энэ номоос үзэхгүй ч энэ нь та нар түүний тухай зарим зүйлийг мэдэх боломжгүй гэсэн үг биш юм. Ерөнхийлөгч Снөүгийн амьдрал гайхамшигтай бөгөөд бэрхшээл сорилт, ялалт амжилтуудаар дүүрэн.

Сайн мэдээг Хамгаалагч

Лорензо Снөү бүр бага залуу байхдаа Сүмийн тухай анх сонссон ажээ. Эгч Элиза нь (ХҮТ олон дуулал бичиж, Нийгмийн Халамжийн Бүлгийн хоёр дахь ерөнхий ерөнхийлөгчөөр үйлчилж байсан Элиза Р.Снөү) нь сайн мэдээг баяртайгаар хүлээн авч, дуулгавартай дагахаар шийдсэн ч Лорензо Снөү эхлээд

баптисм хүртэх хүсэлгүй байсан гэнэ. Гэвч Сүмийн сургаал түүнд маш сонирхолтой санагддаг байжээ. Лорензо Огайогийн Оберлин дахь коллежид сурч байхдаа манай Сүмийн итгэлийн талаар протестант шашны үйлчлэгчид болохоор суралцаж байсан оюутнуудтай олонтоо хуваалцдаг байв. Тэрбээр хэдийгээр баптисм хүртэхээр шийдээгүй байсан ч, Оберлин дахь оюутнуудад сайн мэдээг амжилттайгаар заан бүр тэднээс олон нь Сүм сэргээгдсэн нь үнэн байх боломжтой хэмээн хүлээн зөвшөөрсөн юм.

Лорензо сайн мэдээг хүлээн авахаасаа өмнө эрч хүчтэй номлогч байсан учраас хожим нь баптисм хүртсэнийхээ дараа Их Эзэний ажилд бие сэтгэл бүхнээ дайчлан ажилласанд гайхах юун. Тэрээр Сүмийн гишүүн болсон анхныхаа жилүүдэд нэлээд хэдэн номлолд бүрэн цагийн номлогчоор үйлчлэхээр

дуудагджээ. Тэр эхлээд Огайод, дараа нь АНУ-ын Миссури, Кентаки, Иллинойд үйлчилжээ. Хожим нь түүнийг Англид Сүмийг зохион байгуулахад тусалцуулахаар илгээжээ. Лорензо тэнд байхдаа Мормоны Номыг Хатан Хаан Викториа, Хун тайж Альберт нарт өгсөн гэдэг. Тэрбээр хожим нь Итали, Швейцарьт, эцэст нь Хавайн арлуудад номлолд үйлчилсэн ажээ.

Далайд болсон гайхамшиг

Ахлагч Снөү Англиас Иллинойн Наувуд эргэж ирэхдээ шинээр баптисм хүртсэн олон гишүүдийг дагуулж ирсэн ажээ. Тэд *Свонтон* гэдэг усан онгоцны тасалбар аваад Хойд Америк руу аян замд гарах бэлтгэлээ хангажээ.

Свонтон онгоцны ахмад Хожмын Уеийн Гэгээнтнүүдэд дургүй байсан тул тэдэнд тийм ч нөхөрсөг бишээр хандсан аж. Тэр



Хавайд номлолд үйлчилжээ.

Нэгдсэн Улсад хэд хэдэн номлолд үйлчлэв.



Өөр сүмийн үйлчлэгч нарт сайн мэдээний зарчмуудыг заадаг байв.



Сүмийн тав дахь Ерөнхийлөгчийн тухай та нарын мэдэхгүй байж болох хэдэн зүйлийн тухай өгүүлье.

ерөнхийдөө тэднээс хол хөндий байдаг байв. Гэвч далайд хоёр долоо хоног аялсны эцэст нэгэн гайхалтай явдал болов. Ахмадын туслах осолд орж хүндээр бэртсэн аж. Түүнийг нэг хоногоос илүү амьд байна гэж хэн ч бодоогүй гэнэ.

Гэвч үхэж байгаа далайчныг асарч байсан итгэл бишрэлтэй эгч нарын нэг нь нэгэн санал гаргав. Тэр эгч Ахлагч Лорензо Снөү түүнд адислал өгвөл амийг нь аварч магадгүй гэж ахмадын туслахад хэлжээ. Германд байдаг эхнэр, хоёр хүүхдээ гэжээхийн тулд энэ усан онгоцон дээр ажилладаг байсан ахмадын туслах адислал авахыг дуртай зөвшөөрсөн гэнэ.

Ахлагч Снөүт шөнө дунд сэрээж, амьсгал хураах гэж байгаа нэг хүний өрөөнд хүрч ирээч гэж хүсчээ. Тэр эхлээд усан онгоцны ахмадтай уулзав. Ахмад түүнийг хүрч ирсэнд талархаад туслахынх нь биеийн

байдал найдваргүй гэж үзэж байгаага хэлсэн гэнэ. Ахлагч Снөү хөлгийн ахмад уйлсан байгааг харав.

Тэр хөлгийн ахмадын туслахын өрөөнд орж, толгой дээр нь гараа тавьж, санваарын адислал өгөв. Ахлагч Снөүг адислалаа дуусгамагц сайхь далайчин орон дээрээ өндийн сууснаа улмаар орноосоо боссон гэнэ. Ахмадын туслах бүрэн эдгэрч маргааш нь ажилдаа оржээ.

Бодгалийн үнэ цэнэ

Ахмадын туслахыг эдгээсэн нь *Свонтон хөлөг дээрх уур амьсгалыг өөрчлөв*. Хөлгийн ахмад чадах л хэрээрээ Гэгээнтнүүдтэй аль болох олон цагийг хамт өнгөрүүлэхийг хичээдэг болсноос гадна сайн мэдээг судалж, Сүмийн цуглаануудад оролцдог болсон гэнэ. Бусад усан цэргүүдэд ч энэ явдал гүнзгий сэтгэгдэл төрүүлжээ. Усан онгоц зорьсон газартаа хүрэхэд хөлгийн

багийнхан Гэгээнтнүүдтэй сайхан сэтгэлээр салах ёс гүйцэтгэсэн ажээ. Санваарын хүчээр зөвхөн нэг хүний амь аврагдаад зогссонгүй өөр нэлээд олон хүн Бурханы хүч хийгээд хайрыг өөрийн нүдээр гэрчилжээ. Ахмадын туслах болон усан онгоцны багийн олон гишүүн хожим нь баптисм хүртжээ.

Лорензо Снөүгийн амьдралд өөр олон гайхалтай үйл явдал тохиосон ажээ. Иймээс энэ жил насанд хүрэгчид *Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Лорензо Снөү* номыг судлах үеэр та нар ч гэсэн тэдэнтэй хамт үзэж яагаад болохгүй байх билээ? Та нар ням гарагт эсвэл чөлөөт цагаараа Ерөнхийлөгч Снөүгийн сургаалуудаас уншиж болно шүү дээ. Бас та нар гэр бүлээрээ сайн мэдээний тухай ярилцах үедээ Бурханы бошиглогч болсон энэхүү гайхалтай хүний тухай ихийг мэдэх болно. ■

Хойд Америк руу далайн аялал хийх үед усан онгоцны ахмадын туслахыг эдгээв.



Мормоны Номыг Хатан Хаан Викториа, Хун тайж Альберт нарт өгөв.





Ахлагч Нийл
Л.Андерсен

Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын

БУРХАНЫГ ДЭЭДЛЭН ХҮНДЛЭХ НЬ Мэргэн Ухааныг ЭХЛЭЛ МӨН

Дэлхийн мэргэн ухаан Бурханы мэргэн ухаанаар нөлөөлөгдөж, түүнийг дагасан үед хамгийн үнэ цэнэтэй байдаг.

Бид мэдээллийн эрин үед аж төрж байна. Википедия хэмээх дэлхийн хамгийн том онлайн нэвтэрхий толь бичиг нь чухамдаа энэ дэлхийн бэлэгдэл болж байна. 2012 оны байдлаар энэ нэвтэрхий толь бичиг зөвхөн англи хэлний 2.5 тэрбум үг, 284 хэлээр нийтлэгдсэн 22 сая гаруй өгүүллийг агуулж байсан нь түүний хэмжээ хэр зэрэг их болохыг харуулж байна. Хамгийн багаар бодоход тус бүрдээ 10,000 өгүүлэл агуулсан онлайн Википедия нэвтэрхий толь бичгийг хувилбар 70 гаруй хэлээр гараад байна. Зөвхөн англи хэлээрх хувилбарт гэхэд 4 сая гаруй өгүүлэл оржээ.¹

2004 онд үндэслэгдсэн бөгөөд 2012 онд² дэлхий даяар 1 тэрбум гаруй хэрэглэгчтэй болсон Facebook, 2005 онд үүсэн бий болж, 100 сая гаруй удаа видео гаргасан YouTube мэтийн олон нийтийн сүлжээний вэб сайтуудыг өргөн хүрээгээр ашиглах болсон нь биднийг мэдээллийн эрин зуунд амьдарч байгааг харуулж байна.

Энэхүү мэдээллийн асар том давалгаан дунд мэргэн ухаан буюу сурч мэдсэн зүйлээ тал бүрээс нь цэгнэн, амьдралд хэрхэн хэрэглэхийг мэдэх нь бидэнд агаар ус шиг хэрэгтэй байна. Христэд итгэгч Т.С.Элиот олон жилийн өмнө манай өнөө үеийн дэлхийн талаар ийн бичжээ:

Ай хөөрхий, хавар намар, төрөлт үхэл ээлжилдэг дэлхий минь!

Үзэл санаа, ажил үйлсэд тань эцэс төгсгөл гэж алга,

Үйлс бүтээл, сорилт туршилтад тань эцэс төгсгөл гэж алга,

Үймээн хөдөлгөөнд эцэс төгсгөл гэж алга;

Үргэлжийн амар тайван байдалд зай алга;

Хүмүүний үгээр мэдлэг ирэвч, Бурханы үгэнд зай алга.

Дэлхийн зүйлсийн мэдлэг бурханлаг

зүйлсээс биднийг холдуулна,

Бурханы зүйлсийг мэдэхгүй байх

нь булш руу биднийг хөтөлнө,

Бид сайн мэдээг сонсолгүй хорвоог

орхивол Бурханд эргэн очиж

чадахгүй.

Дэлхийн амьдралд шингэн алга

болсон бидний сүнслэг амьдрал

хаана байна вэ?

Мэдлэгт шингэн алга болсон бидний

мэргэн ухаан хаана байна вэ?

Мэдээлэлд шингэн алга болсон бидний

мэдлэг хаана байна вэ?

Хорьдугаар зууны өнгөрөн одсон

цаг хугацаа

Бурханаас биднийг холдуулж,

Булш руу ойртуулаа.³



Та мэргэн ухааныг хэр зэрэг сайн ойлгодог вэ? Зарим хүмүүс удахгүй болох гэж байгаа хуримандаа сэтгэл догдолсондоо, эцэг эхдээ хандан, “Яасан гоё вэ? Би ингээд гэрлэхээр бүх асуудалдаа цэг тавих болно” хэмээн дуу алдсан залуу бүсгүйтэй үүнийг холбон бодож болно. Тэгэхэд бүсгүйн ээж аавд нь: “Тийм ээ. Энэ бол зөвхөн эхлэл, харин асуудлуудын төгсгөл нь ямар байхыг охин минь мэдэхгүй байгаа шүү дээ” гэж шивнэжээ.

Би Бурханы мэргэн ухаанд хэдийчинээ их суралцана, мэргэн ухааны зөвхөн цагаан толгойг сурч байгаа гэдэгтээ төдийчинээ итгэх болно. Энэ нь намайг ямар их зүйлийг сурах хэрэгтэй вэ? гэдгээ ойлгоход надад тусалдаг. Өнөөдөр би мэргэн ухааныг, тэр тусмаа Бурханы мэргэн ухааныг олж авах хүслээ нэмэгдүүлж чадна гэдэгт итгэлтэй байна.

Мэргэн ухааны адислалууд

Мэргэн ухааны хэд хэдэн зарчмыг би онцгойлон авч үзэхийг хүсч байна. Нэгдүгээрт, бид мэдээлэл, мэдлэгийн энэ эрин зуунд мэргэн ухааныг эрэлхийлэх ёстой. Мэргэн ухаан олон талтай, олон хувилбартай юм. Насны залууд эзэмшсэн мэргэн ухаан үй олон адислалыг авчирна. Аль нэг салбарт эзэмшсэн мэргэн ухаан өөр салбарт ашигтай байдаггүй. Эцэст нь хэлэхэд, дэлхийн мэргэн ухаан олон тохиолдолд их үнэ цэнэтэй ч, энэ нь Бурханы мэргэн ухаанаар нөлөөлөгдөж, түүнийг дагасан үед үнэ цэнэ нь үлэмж ихэсдэг.

Судруудад хоёр төрлийн мэргэн ухаан: Дэлхийн болон Бурханы мэргэн ухааны тухай дүрслэн өгүүлсэн байдаг. Дэлхийн мэргэн ухаан эсрэг, сөрөг хоёр талтай. Сөрөг талаас нь авч үзвэл дэлхийн мэргэн ухааныг аминч үзэл ба хилэнцэт зорилгын улмаас оюунбилэг хийгээд зальжин өнгөлөн далдлалттай холилдсон, хагас үнэн хэмээн дүрсэлж болно.

Үүний нэг жишээ нь Мормоны Номонд гардаг Амлисай гэгч хүн юм. “Амлисай гэж нэрлэгдсэн нэгэн хүн, тэрээр маш зальжин эр байж, тийм ээ, энэ дэлхийн мэргэн ухааныг хувьд ухаалаг хүн байж . . . маш олон хүнийг араасаа [дагуулав]” хэмээн судруудад өгүүлсэн байдаг. Мөн судруудад цааш нь Амлисайг “ёс бус хүмүүн [байснаас], . . . [түүний] санаа нь Бурханы сүмийг устгах [явдал] байв (Алма 2:1–2, 4; онцлон

тэмдэглэлт нэмэгдсэн) хэмээн дүрсэлжээ. Ийм төрлийн мэргэн ухаан бидний сонирхлыг татдаггүй.

Бараг нүгэл хилэнц гэмээргүй, хар бараан биш дэлхийн мэргэн ухааны өөр нэгэн төрөл бий. Хэрэг дээрээ энэхүү мэргэн ухаан сайн талтай юм. Энэхүү мэргэн ухааныг сургалт, тунгаан бодолт, ажиглалт судалгаа болоод шаргуу хөдөлмөрийн үр дүнд ухамсартайгаар олж авдаг. Энэ нь бидний хийдэг зүйлүүдэд маш чухал ашиг тустай юм. Энэхүү мэргэн ухааныг бидний мөнх бус амьдралын үед сайн болон саар хүмүүс аль аль нь эзэмшдэг.

Америкийн зохиолч Марк Твейн: “Би 14-тэй хөвгүүн байхдаа аавтайгаа таарч тохирдоггүй байв. Гэвч 21 хүрсэн үедээ өнгөрсөн долоон жилд аав минь хэчнээн их зүйл сурч мэдсэнийг хараад гайхахын ихээр гайхаж билээ.”⁴ Хэрэв бид бодол суурьтай, хичээл зүтгэлтэй байх юм бол бага цагт их зүйлийг сурч чадна.

Би коллеж төгссөн үеэ санадаг. Би Бригам Янгийн Их

Сургуулиас эмээ Мэри Келлерийн амьдарч байсан АНУ-ын Айдахо дахь Пристон руу очсон юм. Эмээ минь тэр үед 78-тай, өндөр настай болсон байлаа. Тэр хоёр жилийн дараа талийгаач болсон юм. Эмээ минь гайхалтай эмэгтэй байсан. Хэрэв би түүний үгийг анхааралтай сонсож, туршлагаас нь суралцвал амьдралд минь ашиг тусаа өгөх мэргэн ухааныг сурч чадах болно гэдгийг мэддэг байлаа.

Мэргэн ухаанд суралцсанаар бид зарим хүмүүсийн амьдралд ирдэг гунигтай туршлагыг биеэр туулахгүй байж болно. Мэргэн ухааныг эрэлхийлж, дороо суурьтай, дотроо бодолтой бай. Амьдралдаа тохиолддог зүйлсийг эргэцүүлэн бод.

Бид мэргэн ухаанд ажил мэргэжлийн болон хувийн ашиг сонирхлын үүднээс мөн суралцаж болно. Би энд хоёр жишээг дурдъя.

Доктор ДеВон К.Хейл бол Айдахогийн Фоллсод төрж өссөн Солт Лейкийн эмч. Халуун орны өвчнүүдийн талаар хуримтлуулсан түүний мэдлэг, түүний мэргэн ухааныг би гайхан биширсэн. Доктор Хейлсийн мэдлэг төдийгүй бас нэг нь нөгөөтэйгөө харшлах хэдэн өөр мэдээллийг төрөлжүүлэн, амьдралд хэрхэн ашиглах аргыг тэрээр боловсруулсан нь намайг үнэхээр бишрүүлсэн. Анагаах ухааны талаарх энэхүү мэргэн ухаан нь дэлхий даяарх номлогчдоод адислал болж байна.

*Мэргэн ухаанд
суралцсанаар
бид зарим
хүмүүсийн
амьдралд ир-
дэг гунигтай
туршлагыг
биеэр туу-
лахгүй байж
болно.*



Хоёр дахь жишээ: Манай ууган хүү АНУ-ын Флоридагийн Тампа дахь бага сургуульд орох үед бид түүний багш хатагтай Жюдит Грейбеллтэй уулзахыг тэсэн ядан хүлээж байлаа. Тэр бол 50 гаран настай, бага насны хүүхдүүдтэй ажиллах гайхалтай чадвартай эмэгтэй байв. Жюдит хүүхдүүдэд хэрхэн нөлөөлөхийг, хэзээ тэднийг магтахыг бас хэзээ тэдэнтэй хатуухан байхыг мэддэг байлаа. Тэрээр зөвхөн хүүхдүүдэд заах мэдлэгтэй байсан төдийгүй түүнээс ч илүү ихийг мэддэг байсан. Бид бүх хүүхдүүдээ хатагтай Жюдитийн ангид оруулах гэж бөөн ажил боддог байж билээ.

Энэ хоёр бол дэлхийн шилдэг мэргэн ухааны жишээ мөн. Тэдний мэргэн ухаан олон хүмүүст тусалж, ажил мэргэжилдээ амжилт олох боломжийг тэдэнд олгосон юм.

Гэвч бид энэхүү мэргэн ухаан хязгаартайг ойлгох ёстой. Нэг салбар дахь мэргэн ухааныг өөрийн салбар дахь мэргэн ухаан руу шилжүүлэн хэрэглэж боддоггүй. Жишээ нь, би хатагтай Грейбеллийг халуун орны өвчнүүдийг оношлооч гэж гуйж болохгүйтэй адил Доктор Хейлийг манай хүүхдүүдэд заагаач гэж хүсч болохгүй.

Хамгийн чухал нь, дэлхийд амжилт

авчирч байгаа мэргэн ухаан өөрийгөө Бурханы мэргэн ухаанаас илүү гэж бодох биш, харин түүнд захирагдах хүсэлтэй байх ёстой.

Бүх мэргэн ухаан адил тэгшээр бүтээгдээгүйг санагтун.

Дууллыг зохиогч, “ЭЗЭНээс эмээхүй бол мэргэн ухааны эхлэл юм” (Дуулал 111:10) хэмээн хэлжээ. Энэ судар Их Эзэнийг “дээдлэн хүндэлж бишрэх” нь⁵ мэргэн ухааны эхлэл мөн гэсэн утгатай юм. Бидний Тэнгэрлэг Эцэг “тэнгэрт мөн газарт аль алинд нь бүх мэргэн ухааныг, мөн бүх хүч чадлыг эзэмшигч” (Мозая 4:9) учраас бид Түүнийг ийнхүү дээдлэн хүндэлж биширдэг билээ. Түүний мэргэн ухаан төгс бөгөөд цэвэр ариун юм. Энэ нь амин хувиа хичээдэггүй.

Энэхүү мэргэн ухаан зарим үед дэлхийн мэргэн ухааны эсрэг байх болно. Бурханы болон дэлхийн мэргэн ухааны утга учир хоорондоо тохирдоггүй.

Исаиа дахь Их Эзэний дараах үгсийг санаж байна уу?

“Учир нь миний бодол санаанууд бол та нарын бодол санаа биш. Миний зам нь та нарын замаас өөр” гэж Эзэн айлдаж байна.

“Тэнгэр нь газраас өндөр байдаг шиг, Миний зам та нарын замаас, Миний бодол

Дэлхийд амжилт гаргадаг мэргэн ухаан нь Бурханы мэргэн ухааны дараа орох ёстой. Бурханы мэргэн ухааныг дэлхийн мэргэн ухаанаар орлуулж болохгүй.

та нарын бодлоос өндөр билээ.” (Исаиа 55:8–9).

Бурханы мэргэн ухаан бидэнд эрх олголтоор ирэхгүй. Бид түүнийг эрж хайх хүсэлтэй байх ёстой. “Хэрэв та нарын хэн нэгэн нь *мэргэн ухаанаар* дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас *гуйг*. Тэгвэл түүнд өгөгдөх болно” (Иаков 1:5; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Бурханы мэргэн ухаан бол сүнсний бэлэг юм. “*Баялгуудыг бус харин мэргэн ухааныг эрэлхийлэгчдүн*, мөн болгоогчдун, Бурханы нууцууд чамд нээгдэх болно, тэгээд чи баян болгогдох болно” (С ба Г 6:7; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Бурханы мэргэн ухааныг эрэлхийлэх нь зарлигуудыг дуулгавартай дагахтай ямагт холбоотой байдаг.

Ерөнхийдөө, мэргэн ухааны сүнслэг бэлэг нь бид түүнийг шударгаар хичээнгүйлэн эрэлхийлсэн үед алхам алхмаар ирдэг. “Би хүмүүний үрст шат шатаар, дүрэм дүрмээр, энд бяцхан мөн тэнд бяцханыг өгөх болно; мөн миний дүрмүүдийг анхааран сонсох, мөн миний зааварт чих тавих тэд адислагдсан болой, учир нь тэд *мэргэн ухаанд* суралцах болно; өөрөөр хэлбэл хүлээн авах түүнд би илүүт өгөх болно” (2 Нифай 28:30; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Иосеф Смит ийн хэлсэн юм: “Бурханы зүйлс туйлын чухал юм. Эдгээр зүйлсийг гагцхүү цаг хугацаа зарж, туршлагаар болон ажигч гярхай, ул суурьтай хийгээд гүнзгий тунгаан бодолтоор олж болно.”⁶ Бурханы мэргэн ухааныг эрж хайхад түргэн амжилт олно гэж байхгүй.

Эцэст нь Бурханы мэргэн ухааны эх сурвалж дэлхийнхээс өөр юм. Бид Бурханы мэргэн ухаанд судрууд, бошиглогчдын сургаалуудаас (ерөнхий чуулганы үеэр гэхчлэн) мэдээж хэрэг бас залбирлуудаараа дамжуулан суралцдаг (С ба Г 8:1–2-ыг үзнэ үү). Мөн энэхүү сургаал нь бидэнд *үргэлж* Ариун Сүнсний хүчээр өгөгддөг билээ. Төлөөлөгч Паул хэлсэн нь:

“Учир нь хүний дотор буй сүнснээс нь өөр хүний бодол санааг хэн мэддэг вэ? Түүнчлэн Бурханыхыг Бурханы Сүнснээс өөр хэн ч мэддэггүй. . . .

“Бид үүнийг *хүний мэргэн ухааны* сургасан үгсээр бус, харин Ариун Сүнсний сургаснаар ярьдаг” (1 Коринт 2:11, 13; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

“Сүнс . . . тэдгээр зүйлүүдийг байгаагаар нь, мөн тэдгээр зүйлүүдийг үнэхээр байхаар нь ярьдаг” (Иаков

4:13) хэмээн судруудад өгүүлдэг учраас бид Бурханы мэргэн ухаанаар өөрсдийнхөө харж чадахаас илүү ихийг харж чадна.

Бурханы мэргэн ухаан бол биднээс онцгой анхаарал, хүч чармайлт шаарддаг мэргэн ухаан юм.

Мэргэн ухаан ба аравны нэг

Бүх мэргэн ухаан адил тэгшээр бүтээгдсэн байдаггүй. Дэлхийн мэргэн ухаан, Бурханы мэргэн ухаан хоёр хоорондоо зөрчилтэй учраас бид хүсэл бодлоо Бурханы мэргэн ухаанд захируулж сурах ёстой.

Бид бол Бурханы хөвгүүд, охид билээ. Бид бол мөнх бус амьдралд тодорхой үүрэг гүйцэтгэх ёстой сүнслэг хүмүүс юм. Бид дэлхийн мэргэн ухаан, Бурханы мэргэн ухаан хоёрын аль алинд нь суралцах ёстой учраас энэ хоёрын аль нь илүү чухал вэ? гэдэг талаар аливаа эргэлзээ байх ёсгүй.

Бразилын Сан Паулогийн нэгэн сайхан сэтгэлт Хожмын Үеийн Гэгээнтнийг би энд жишээ болгон дурдахыг хүсч байна. Тэр аравны нэгээ төлөх үү эсвэл сургалтын төлбөрөө төлөх үү гэдэг талаар сорилтонд орсон тухайгаа ярьжээ. Тэрээр ийн өгүүлжээ:

“Их сургууль . . . өртэй оюутнуудыг (сургалтын төлбөрөө төлөөгүй) шалгалтанд орохыг зөвшөөрдөггүй байв.

Би санхүүгийн маш хүнд байдалд орсон . . . нэг тохиолдлоо санадаг. Дөрөв дэх өдөр би цалингаа авлаа. Төсөвлөсөн мөнгөө бодож үзтэл аравны нэг, сургалтын төлбөр хоёроо хоёуланг нь төлөх мөнгө хүрэлцэхгүй байсан учраас аль нэгийг нь сонгох хэрэгтэй байв. Хоёр сар тутам өгдөг шалгалт дараагийн долоо хоногт эхлэх байдаг, хэрэв би шалгалтуудаа өгөхгүй бол, энэ хичээлийн жилд цааш суралцах боломжгүй болно. Би сэтгэлээр маш их унаж, . . . гутрав.”

Энэ бол дэлхийн мэргэн ухаан, Бурханы мэргэн ухаан хоёрын зөрчлийг харуулсан маш тод жишээ юм. Чи маш сайн, зөв шударга, хичнээн өөртөө итгэлтэй байлаа ч иймэрхүү зөрчилтэй нөхцөл байдалд сэтгэл санаагаар унаж гутрах явдал тохиолдох болно.

Одоо түүний түүх рүү эргэж оръё. Нэгдүгээрт, тэр аравны нэгээ ням гарагт төлжээ. Дараагийн нэг дэх өдөр юу болсныг тэр эргэн санахдаа:

“Ажлын цаг дуусч байтал миний ажил олгогч хүрч ирээд тэр өдрийн сүүлчийн захиалгуудыг өглөө. . . . Тэр гэнэт түр зогссоноо ‘Сургууль чинь юу болж

Бурханы мэргэн ухааныг судруудаас, бошиглогчдын сургаалаас (ерөнхий чуулганаас), мөн мэдээж залбирлаасаа бид олж болно.

байна?” гэж асуулаа. [Тэр даргаа хахир хатуу хүн гэж боддог байсан учир:] ‘Бүх зүйл сайн байгаа!’ гэж хэлэхэд:

Дарга нь яваад өгчээ. Тэгтэл нарийн бичгийн дарга нь өрөөнд орж ирээд, “Компани өнөөдрөөс эхлээд таны коллежийн болон сурах бичгийн зардлыг бүрэн төлөх боллоо” гэж дарга дөнгөж сая хэллээ. Явахаасаа өмнө над дээр очиж, төлбөрийнхөө тухай мэдээллийг надад өгөөрэй. Би маргааш чамд чек бичиж өгье” гэжээ.⁷

Хэрэв та нар ухаалаг хэрсүү байх юм бол амьдралын туршид иймэрхүү сорилттой олон удаа тулгарах болно гэдгийг ойлгох болно. Та нар итгэл найдвараа хэнд тавих ёстой вэ? Бидэнд шууд хандан сануулсан Их Эзэний сэрэмжлүүлгийг сонсогтун:

“Ай хүмүүний бардам зан, мөн эмзэглэл, мөн мунхаглал! Тэд аливааг [дэлхийн мэргэн ухааныг] сураад өөрсдийгөө ухаантай хэмээн санадаг, мөн тэд Бурханы зөвлөмжийг эс анхаардаг, учир нь тэд үл ойшоож, тэд өөрсдөө мэднэ [дэлхийн мэргэн ухааныг] гэж боддог, иймийн тул, тэдний

мэргэн ухаан нь тэнэглэл байж мөн энэ нь тэдэнд ашгийг эс өгнө. Мөн тэд мөхөх болно.

“Тэвч хэрэв тэд Бурханы зөвлөмжийг анхааран сонсох аваас суралцсан байх нь сайн хэрэг” (2 Нифай 9:28–29; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Одоо Паулаас эш татъя:

“Мэргэн хүн хаана байна? . . . Бурхан энэ ертөнцийн мэргэн ухааныг мунхаг болгоогүй гэж үү?” (1 Коринт 1:20).

“Хэн ч өөрийгөө бүү мэхлэг. Хэрэв та нарын дунд хэн нэг нь энэ үед өөрийгөө мэргэн хэмээн боддог бол тэр хүн мэргэн болохын тулд мунхаг болог.

Учир нь энэ ертөнцийн мэргэн ухаан бол Бурханы өмнөх мунхаглал ажээ” (1 Коринт 3:18–19; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Биднийг удирдах залуур байх ёстой Бурханы мэргэн ухаан дэлхийн мэргэн ухаантай зөрчилдсөн үед бидэнд сорилт олонтоо тулгардаг.

Аммон ийн гашуудсан байдаг, “Учир нь тэд мэргэн ухааныг [Бурханы мэргэн ухааныг], хайх нь үгүй, мөн тэрнийг өөрсдийн

Хувийн төсвөө гаргахдаа Бурханы мэргэн ухаанаар ханд. Бид мөнгөөрөө аравны нэгээ төлөх ба өргөлүүдээ өгөөмрөөр төлөх зэрэг зөв зүйлүүдэд зарцуулах ёстой.



дээр захируулах хүсэл ч үгүй болой!” (Мозая 8:20). Бурханы мэргэн ухаанд өөрийгөө захируулах хүсэлтэй хэн байдаг билээ? гээд бодохоор миний хятад найз Зи Вайнг миний санаанд орж ирдэг юм. Тэр Сүмд элсэхийн тулд агуу золиослол хийж, Нью-Йоркод номлолд үйлчилсэн юм. Манай хоёр охин их боловсролтой бүр магистрын зэрэг хамгаалсан ч, эх хүн болж, хүүхэд төрүүлэн өсгөхийн адислалуудыг хүртэхээр сонгосон тухай би бас бодлоо. Ажлын газар нь татвар төлөхөөс хууль бусаар зайлсхийдгийг мэдээд өндөр цалинтай ажлаа орхисон Өмнөд Америкийн нэг найзынхаа тухай бодлоо. Эдгээр хүмүүс бүгдээрээ Бурханы мэргэн ухааныг дэлхийн мэргэн ухаанаас дээгүүр тавьсан юм.

Харамсалтай нь дэлхийн мэргэн ухаан чадварлаг хүмүүсийг хууран мэхэлж чаддаг. Энэ тухай Иосеф Смит ийн хэлсэн юм: “Тэдэнд заахад дэндүү ухаантай үй олон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд бидний дунд байдаг. Тиймээс тэд энэхүү харалган байдалдаа нас барж, амилуулалтаар алдаагаа мэдэх болно.”⁸

Мэргэн ухаан ба мөнгө

Манай эдийн засагт учирч байгаа хүнд рэлтэй холбогдуулан хувь хүмүүсийн санхүүгийн талаар нэг асуудал хөндөж ярья. Манай эдийн засгийн байдал хүндхэн байгаа өнөө үед бид бүгд даруухан бөгөөд дуулгавартай байж, өнгөрсөн хэдэн жилийн тухай эргэн бодох хэрэгтэй.

Хэрэв бид ямар нэг зүйлийг хүсч байгаа бол түүнийгээ даруй олж авах ёстой, харин хүлээж суух ёсгүй гэж дэлхий сургадаг. Өр зээл биднийг эрхшээлдээ оруулахад хэзээд бэлэн байдаг. Ийм өр зээл нь зээлийн карт эсвэл орон байраа барьцаанд тавин банкнаас зээл авах зэрэг хэлбэрээр та бидэнд эрж болно. Бид байгаа бүхнээ, бүр боловсрол мэдлэгээ хүртэл зээлийн барьцаанд тавьж болно. Зээлээр олж авсан үнэт зүйлс өсч, бид цэцэглэн хөгжих болно. Дэлхийн мэргэн ухаанаар бол сарын цалингийн хэмжээ зээлийн хэмжээнээс илүү чухал юм. Банкны зээлийг эргүүлж төлөх асуудал бидний хяналтанд байдаг ч, хэрэв бүх зүйл буруугаар эргэвэл, дампуурал бидний сүүлийн сонголт болно.

Одоо бошиглогчдын байнга зааж ирсэн хувь хүний санхүүгийн талаарх Бурханы мэргэн ухааныг товчхон авч үзье. Үүний

үндэс суурь нь бие даах чадвар, ажил хөдөлмөр юм. Бид аравны нэгийг шударгаар төлж, бусад өргөлүүдэд өгөөмөр байснаар мөнгийг зохих ёсоор зарцуулж чадна. Бид цалингаасаа багыг зарж, хэрэгцээ, хүсэл хоёртоо зохицуулан амьдардаг. Зайлшгүй чухал хэрэгцээ биш бол бид өр зээл тавихаас зайлхийж, төсөв зохион, түүндээ тохируулан амьдрах ёстой. Бид ирээдүйдээ зориулсан хадгаламжтай байхын хамт хийх ёстой бүх төлбөр тооцоондоо шударга байх ёстой.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) 14 орчим жилийн өмнө: “Бид гэр орондоо дэг журмыг тогтоох цаг болсон гэж би бодож байна. Манай маш олон хүмүүс цалингаараа дөнгөн данган амьдарч байна. Зарим хүмүүс чухамдаа зээлээр амьдарч байна. . . . Эдийн засаг хүндрэх төлөв байдал харагдсаар байгаа тул бид илүү сайн сонсож сурах хэрэгтэй байна.”⁹

Ерөнхийлөгч Томас С.Монсон нэлээд хэдэн жилийн өмнө манай эдийн засгийн хөгжлийн оргил үед:

“Ах, эгч нар аа, очигдрийн тансаг хэрэглээ өнөөдрийн энгийн хэрэгцээ болсон гэдэг үзэл бодлоос зайлсхий. Бид өөрсдөө л тансаг хэрэглээг энгийн хэрэгцээ болгож байгаа хэрэг шүү дээ. Өвдөх буюу хөдөлмөрийн чадваргүй болох, компаниуд дампуурах буюу зардлаа танах, ажилгүй болох, байгалийн гамшиг зэргээс шалтгаалан олон хүмүүс нөхцөл байдлаа өөрчлөхийн тулд урт хугацаатай зээл авч байна. Олон шалтгааны улмаас их хэмжээний өрийг төлөх хойшид боломжгүй болж байна. Бидний өр төлбөр толгой дээр дүүжилсэн илд лүгээ адил биднийг сүйрүүлэхээр байнга заналхийлж байдаг.

Орлогодоо тохируулан ухаалгаар амьдрахыг би та бүхэнд зөвлөж байна. Хүн орлогоосоо илүүг зарцуулдаг бол төлбөрийн чадвартай байж чадахгүй. Шаардлагагүй байхад авсан зээлийнхээ дараагийн төлбөрийг яаж хийх вэ? хэмээн та байнга санаа зовдог бол та аз жаргалтай байж чадахгүй гэдгийг би та бүхэнд анхааруулж байна.¹⁰

Бурханы мэргэн ухаан дэлхийн мэргэн ухаантай хэрхэн зөрчилддөгийг та харж байна уу? Баян чинээлэг харагдахын төлөө сонголт хийх ёсгүй. Сүмийн олон гишүүд бошиглогчдын зөвлөгөөг нэн анхааралтай сонсохыг хүсдэг.

Энэ бол Бурханы мэргэн ухаан юм. Өөртөө тулгарч байгаа асуудлуудыг

Мэргэн ухааны тухай сурах зүйл маш их байна. Таныг мэргэн ухааныг—Бурханы мэргэн ухааныг эрэлхийлэх үед Их Эзэн адислалуудыг өгнө гэдгийг би та нарт амлаж байна.



анхааралтай авч үзэхийг би та бүхэнд санал болгож байна. Цаасны голд босоо шугам зур. Шугамны зүүн талд дэлхийн мэргэн ухааныг баруун талд нь Бурханы мэргэн ухааныг жагсаан бич. Эсрэг тэсрэг асуудлуудыг ялган бич.

Та ямар сонголтууд хийв?

Аврагчийн Хоёр дахь Ирэлт рүү хөтөлж буй үйл явдлуудын тухай өгүүлдэг Сургаал ба Гэрээний 45-р хэсэгт Их Эзэн арван онгон охины тухай түүхийг дахин ярьж, дараах үгсийг бидэнд захин үлдээсэн юм: “Учир нь мэргэн хийгээд үнэнийг хүлээн авсан, мөн Ариун Сүнсийг зам заагчаа болгон авсан, мөн мэхлэгдээгүй тэд—үнэнээр би та нарт хэлнэ, тэд тас цавчигдан мөн галд хаягдахгүй, харин тэр өдрийг тэсэн гарах болно” (С ба Г 45:57).

Бурханы мэргэн ухааныг эрэлхийлцгээе. Бид эдүгээ дэлхий дахиныг хамарсан эдийн засгийн хүндрэл бэрхшээлийн үед аж төрж байна. Үүний улмаас бид ажил мэргэжил, орлого зарлагаа төлөвлөдөг байх шаардлага гарч ирж байна. Гэвч бидний өмнө хөгжил цэцэглэлтийн сайхан ирээдүй байна. Мэргэн ухаанд одооноос суралцахын тулд бидэнд хийх зүйл маш их байна. Хэрэв та нар мэргэн

ухааныг—Бурханы мэргэн ухааныг эрэлхийлбэл Их Эзэний адислалууд та нарт ирэх болно гэдгийг би та нарт амлаж байна. ■

Айдахо дахь Бригам Янгийн Их Сургуулийн үүсэн байгуулагдсны ойгоор 2009 оны дөрөвдүгээр сарын 10-нд хэлсэн үгнээс нь эш татав. Англи хэл дээрх бүрэн текстийг <http://web.byui.edu/DevotionalsAndSpeeches>-ээс үзнэ үү.

ЭШЛЭЛ

1. Андриу Лиа *The Wikipedia Revolution* (2009), xv–xvi-г үзнэ үү; мөн http://en.wikipedia.org/wiki/Wikipedia:Size_comparisons-н үзнэ үү; <http://wikimediafoundation.org/wiki/FAQ/en>; http://en.wikipedia.org/wiki/History_of_Wikipedia.
2. Рамона Эмерсон, “Facebook Users Expected to Pass 1 Billion in August: iCrossing,” *The Huffington Post*, Jan. 14, 2012, www.huffingtonpost.com/2012/01/13/facebook-users-1-billion-icrossing_n_1204948.html-ийг үзнэ үү.
3. “Choruses from ‘The Rock,’” in *T. S. Eliot: The Complete Poems and Plays, 1909–1950* (1980), 96.
4. *Mark Twain Laughing: Humorous Anecdotes by and about Samuel L. Clemens*, ed. P. M. Zall (1985), xxii.
5. Марион Г.Ромни, “Converting Knowledge into Wisdom,” *Ensign*, 1983 оны 7-р сар, 5-ыг үзнэ үү.
6. *Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 267.
7. Гордон Б.Хинкли, “We Walk by Faith,” *Лиахона*, 2002 оны 7-р сар, 81–82.
8. *Teachings: Joseph Smith*, 202.
9. Гордон Б.Хинкли, “To the Boys and to the Men,” *Ensign*, 1998 оны 11-р сар, 53.
10. Томас С.Монсон, “True to the Faith,” *Лиахона*, 2006 оны 5-р сар, 19.

Өөрт чинь тулгарч байгаа асуудлуудаас заримыг нь нэрлэ. Цаасны голд босоо шугам зур. Шугамны зүүн талд дэлхийн мэргэн ухааныг баруун талд нь Бурханы мэргэн ухааныг жагсаан бич. Эсрэг тэсрэг асуудлуудыг ялган бич.

ГЭР БҮЛДЭЭ ҮР ӨГӨӨЖТЭЙ ЗААХ НЬ

Бид амьдралын чухал сургамжуудыг хүүхдүүддээ дөрвөн арга замаар заадаг.

Даррен Э.Шмидт

Найман хүүхдүүддээ заах боломжтой байсан бидний хувьд сорилт бэрхшээл, урамшил шагнал хоёрын алиныг нь авчирсан юм.¹ “Гэр орон бол хүүхдүүдийн хувьд амьдралд суралцах анхны бөгөөд хамгийн үр өгөөжтэй газар гэдгийг мэддэг учраас эхнэр бид хоёр хүүхдүүддээ амьдралд суралцахад нь туслахын тулд чадах бүхнээ хийхийг хичээсээр ирсэн юм. Бидэнд тусалсан хэдэн зарчмын тухай өгүүлэе.

Хамгийн сайн зүйлсийг хий

Хүүхдүүд маань олон янзын үйл ажиллагаанд оролцох тусам хамгийн чухал зүйлийг ялган таних нь улам бүр чухал болж байлаа. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс: “Ямар нэгэн зүйл *сайн* байна гэдэг нь үүнийг хийх хангалттай шалтгаан биш. . . . Иймээс бид зарим онцгой сайн зүйлд хамгийн түрүүнд анхаарал тавих шаардлагатай болдог” гэдгийг бидэнд сануулсан билээ. Тэрбээр цааш нь хэлэхдээ: “Эцэг эхчүүд гэр бүлийн залбирал, гэр бүлээрээ судар судлах, гэр бүлийн үдэш тэрчлэн гэр бүлээрээ бүгдээрээ хамт байх болон хүүхэд бүртэйгээ тусад нь уулзаж ярилцах цаг гаргаж хэвших нь гэр бүлийн холбоог бэхжүүлж, мөнхийн үнэ цэнэтэй зүйлс дээр анхаарал төвлөрүүлэхэд хүүхдүүдэд тусалж чадна. Эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ хамтран хийдэг зүйлсээр дамжуулан сайн мэдээний эрхэм чухал зарчмуудыг тэдэнд заах ёстой.”²

Энэ зөвлөгөө манай гэр бүлд ашиг тусаа өгсөн юм. Гэрээс гадуурх үйл ажиллагаануудын талаар эргэцүүлэн бодож, залбирах боломжийг эхнэр бид хоёр

хүүхдүүддээ олгодог. Энэ явцад чухал гэж бидний бодож байсан зарим зүйлс төдийлөн шаардлагагүй болох нь мэдэгдсэн билээ. Хүүхдүүд маань сагсан бөмбөгийн баг болж, би тэдний дасгалжуулагчаар ажиллавал яасан юм бэ? гэж намайг хүсэхэд тэд юу гэж хариулсан нь намайг гайхахад хүргэж билээ. “Аав аа, тэгэх хэрэггүй байхаа. Манай хашаанд сагсны шийд байгаа шүү дээ. Та бидэнтэй тоглоход бид дуртай байдаг. Бид бас хөршүүдтэйгээ тоглодог. Бид зөндөө олон бөмбөг оруулдаг ш дээ!” гэж тэд хариулсан.

Судруудыг судалж, тэдгээрийн дагуу үйлд

Судруудыг *унших*, тэдгээрийг *судлахын* хооронд ялгаа бий. Бид “түүн дотор *бичигдсэн бүхнийг сахин биелүүлэхээр* өдөр шөнөгүй түүнийг бясалгаж яв” (Иошуа 1:8; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) судар судлахдаа амжилт олно гэдгийг эртний бошиглогч Иошуа сургасан билээ. Бид гэр бүлээрээ судар судлах үед анхаарал татсан чухал асуултуудыг тунгаан бодоход хүүхдүүддээ цаг гаргаж өгсний дараа “түүн дотор бичигдсэн бүхнийг сахин биелүүлэхэд” тэднийг урихад хамгийн их амжилт олж байлаа.

Бид нэг орой гадагшаа явж хоол идээд Мормоны Номоос нифайчуудын уналтын талаар уншив. Нифайчууд яагаад тийм ёс бус болсон гэж бодож байгааг нь би хүүхдүүдээсээ асуулаа. Зургаан настай Селест, нифайчууд, леменчүүд аль аль нь өдөр бүр залбирахаа больсноос болсон гэж бодож байгаагаа хэлэв. Нифайчуудын уналт залбирах болон яльгүй жижиг мэт санагдах бусад зүйлсийг хийхээ мартсанаас эхэлсэн гэдэгт бид бүгд санал нэгтэй байв. Тэр үед хүүхдүүдээ илүү



сайн бодож, үүнээс төрсөн мэдрэмж дээрээ үндэслэн залбирал хэлж байхад урих санаа надад төрж билээ.

Маргааш нь би тэднээс залбирал нь ямар болсныг асуув. Энэ нь тэдэнд туршлагаа хуваалцах боломжийг харин надад залбирлын тухай гэрчлэлээ хүүхдүүдтэйгээ цаашид хуваалцаж байх боломжийг олгосон юм. Гэр бүлээрээ судар судлах туршлага нь үргэлж үүн шиг амжилттай байдаггүй ч бид судар судлах үйл ажиллагааныхаа хэсэг болгон хүүхдүүдтэйгээ судруудын тухай ярилцаж, тэднийг санаа бодлоо хэлэхэд урьдаг нь илүү амжилт олоход үр нөлөөгөө өгдөг.

Хүүхдүүдэд хариуцлагатай болоход нь тусал

Хүүхдүүдэд ажил үүрэг даалгаж, үүнийг биелүүлэх явцад тохиолдох жижиг сажиг асуудлуудыг тэд өөрсдөө зохицуулж сурах

*Бид судраас
суралцахдаа
хүүхдүүддээ
асуултуудын
талаар тунгаан
бодох цаг өгч
мөн эдгээрийг
амьдралдаа
хэрэгжүүлэхийг
уриалах үед
амжилттай
байдаг.*

нь маш чухал болохыг бид мэдсэн. Гэр бүлийн зарим асуудлаар шийдвэр гаргахад хүүхдүүдийг оролцуулах нь тэднийг аливаа зүйлд идэвхтэй оролцогчид болоход нь ашиг тустай юм. Үүний үр дүнд тэд “чөлөөт хүслээрээ олон зүйлийг хийж, туйлын зөв шударга байдлыг тохиолгон авчирч” (С ба Г 58:27) суран, ажил хариуцан хийх үүрэг хариуцлагын мэдрэмжээ хөгжүүлдэг. Манай хүүхдүүдэд илүү хариуцлагатай байхад нь тусалсан хэдэн зүйлийн тухай энд өгүүлье:

- Гэр бүлийн үдэшт зориулж хичээл бэлтгэх, судар унших, эсвэл өөрийнхөө авьяас чадвараар ямар нэг зүйлийг хийхэд нь хүүхдүүддээ тусал.
- Гэр бүлээрээ судар судлах үед бүгдээрээ дуулах дууллыг сонгох буюу дараа залбирал хэлэхэд аль нэг хүүхдийг урих боломжийг тэдэнд олго.

- Гэр бүлийн аяллыг төлөвлөхөд хүүхдүүдийг оролцуулж, зарим үүргийг тэдэнд хариуцуул.
- Мөнгө санхүүгийн асуудлыг шийдэх болон юм худалдаж авах шийдвэр гаргах үед гэр бүлээрээ зөвшилцөн ярилцаж бай.
- Аль нэг ажлыг яаж хийдгийг тэдэнд зааж, долоо хоногийн хугацаанд уг ажлыг тэдэнд хариуцуул.
- Гэр бүлийн сар тутмын үйлчлэлийн төслийг боловсруулж, гэр бүлээрээ хэнд туслахыг шийдэх боломжийг хүүхдүүдэд олго.
- Тодорхой нэг ням гарагт хэн нэгийг ээлжээр эргэж очих боломжийг тэдэнд олго.
- Сард нэг удаа гэр бүлийн үдшийн аль нэг үйл ажиллагааг хариуцан хийх боломжийг тэдэнд өг.



Энэ бол эцэг эхийн хувьд онцгой агшин байлаа. Бид ердийнхөөсөө арай орой унтсан ч миний мэдэрсэн баяр баясгалан нойроо хассан золиос-лолоос хавьгүй үнэтэй байлаа.

Хүүхдүүд биднээс *үргэлж* асуугаад байдаггүйг, бас тэд *үргэлж* дуулгавартай байдаггүйг бас тэд *үргэлж* анхааран сонсдоггүйг санан, хүүхэд чин сэтгэлээсээ асуусан тохиолдолд бидэнд тохиодог онцгой чухал боломжуудын нэг нь хүүхдийн асуултанд хариулах явдал мөн гэж Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Л.Эванс (1906–71) заажээ. “Ингэхдээ бид *тэдний* нөхцөл байдлыг мөн *тэдний* цагийг юуны түрүүнд

харгалзан үзэхээс биш, үргэлж *өөрсдийнхөө* нөхцөл байдлыг мөн *өөрсдийнхөө* цагийг бүхний түрүүнд тавих ёсгүй. . . . Хэрэв хүүхдүүд чухал асуултаа бидэнд итгэн асууж байгаа бол хожим нь бүр илүү чухал асуудлуудаа бидэнд итгэн даатгах болно.”³

Тэднийг удирдан чиглүүл

Заримдаа эхнэр бид хоёр гэр бүлийн залбирал хийх юм уу судар судлахад хүүхдүүдээ албадан цуглуулахаас аргагүй болсон хоньчид шиг санагддаг. Гэвч бусад үед бид бяцхан сүргийнхээ төлөө жинхэнэ хоньчид шиг санаа тавьж байгаага мэдэрэх нь хэчнээн сайхан байдаг гээч. Хэрэв бид анхааралгүй байх юм бол жинхэнэ хоньчны үүрэг биелүүлэх аятайхан боломжийг алдаж болно.

Хүүхдүүдээ унтуулах үеэр надад тийм нэгэн агшин тохиосон юм. Хөвгүүдийн маань нэг нь, “Аав аа, таныг юу уруу татдаг вэ?” гэж асуухад нь би их гайхсан.

Тэгснээ тэр, “Биднийг юу уруу татдаг тухай бид ярилцаж байсан юм л даа. Тэгээд таныг юу уруу татдаг бол гэж бодоод асуусан юм” гэв.

Энэ асуулт тэдэнд заах аятайхан далим гэдгийг би мэдэж байсан ч өдөржингөө ажилласнаас ядарч туйлдсан байлаа. Ийм орой болсон хойно ялангуяа, хүүхдүүдийнхээ хичээл номоо үзэх цагаар хоёр хөвгүүнтэйгээ ул суурьтай ярилцахад би дурамжхан байлаа.

Гэвч Аврагчид худаг дээр тохиолдсон явдал миний санаанд орж ирлээ. Тэр 48 км явган явсны дараа самари эмэгтэйд заах цаг гаргасан шүү дээ (Иохан 4-ийг үзнэ үү). Хөвгүүдтэйгээ ярилцах нь Аврагчид худаг дээр тохиолдсон явдалтай адил санагдсан болохоор би тухлан сууж, уруу татагдах нь нүгэл гэж боддог уу? гэж тэднээс асуулаа. Бид нэлээд удтал дуугүй сууснаа ярилцаж эхлэн бие биенийхээ үгийг анхааралтай сонслоо. Би хөвгүүддээ Аврагч Сатантай (Матай 4-ийг үзнэ үү) хэрхэн тулгарсан тухай зааж, уруу таталтыг эсэргүүцсэнээс ирдэг адислалуудын тухай гэрчлэлээ хуваалцлаа.

Их Эзэнээр сонгогдон Түүгээр туслуулсан нь

Бурханы хүүхдүүдийг халамжлан хүмүүжүүлэх нь хүнд үүрэг хариуцлага юм. Би эцгийн үүргээ тааруухан биелүүлж байна уу даа гэж бодсон үедээ Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Нийл А.Маквеллын (1926–2004) дараах үгсийг санадаг: “Есүсийн төрөлтийг зарлан тунхаглахаар Бетлехемийн дээгүүр гарч ирсэн тэрхүү одыг Бурхан тэр цагаас олон мянган жилийн тэртээ сансар огторгуйд байх ёстой газарт нь байрлуулсан лугаа адил бидний гэрэл буюу ойлголт бусдыг удирдах төдийгүй, тэднийг тайтгаруулан, тэдэнд үйлчлэхийн тулд бидний хүн нэг бүрийг хүмүүний амьдралын адил тэнцүү орчин хийгээд нөхцөлд төрж, өсөн амьдрахаар томилдог билээ.”⁴

Эдгээр үгс намайг урам хугарсан үед өргөн дэмждэг билээ. Эдгээр үгс эцэг эхийн үүргээ биелүүлэхэд эхнэр бид хоёрт урам дэм, эрч хүчийг өгдөг. Тэнгэрлэг Эцэг манай хүүхдүүдийг эхнэр бид хоёрын “хараа хяналтанд” итгэмжлэл хүлээлгэн өгснийг бид мэддэг билээ.

Эцэг эхчүүд та нарыг сайн мэдээнээс хамтран суралцахад тань, хүүхдүүд тань хариуцлагатай болж өсөхөд, мөн үнэ цэнэтэй заах хормуудыг ашиглахад тань Тэрбээр та нарыг адислах болтугай. ■

ЭШЛЭЛ

1. Давид О.МкКей, *Family Home Evening Manual* (1968), iii.
2. Даллин Х.Өүкс, “Good, Better, Best,” *Лиакхона*, 2007 оны 11-р сар, 104, 105.
3. Ричард Л.Эванс, “The Spoken Word,” *Ensign*, 1971 оны 5-р сар, 12.
4. Нийл А.Маквелл, *That My Family Should Partake* (1974), 86.



БОЛОВСРОЛЫН ҮНЭ ЦЭНЭ

Боловсрол бол сайн мэдээний нэн чухал хэсэг бөгөөд нийгмийн амьдралд оролцох, өөрийгөө болон гэр бүлээ тэтгэхэд хувь хүнийг бэлтгэдэг.¹ Далын Ахлагч Крейг А.Кардон энэ дугаарын 54–55-р хуудас дээр боловсролын ач холбогдлын тухай өгүүлсэн байна.

“Улам нарийн, ээдрээ төвөгтэй болж байгаа энэ дэлхийд боловсрол амьдралын чухал шаардлага, шалгууруудын нэг болж байна. Сайн боловсролтой болох нь материаллаг аж байдлын хувьд илүү сайн амьдрах боломжийг бидэнд олгохын хамт өндөр мэдлэг боловсрол нь Их Эзэний зорилгуудыг биелүүлэхэд илүү их нөлөө үзүүлэх боломжоор биднийг хангадаг.”

Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимолд: “Та нарын боловсролд сүнсээр суралцах мөн багтана. Судруудаас мөн хожмын үеийн бошиглогчдын үгсээс суралц. Институт, семинарт хамрагд. Амьдралынхаа турш Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний тухай үргэлж суралц. Энэ сүнслэг сургалт та нарыг амьдралын саад бэрхшээлүүдэд хариултыг олоход тусалж, Ариун Сүнсний нөхөрлөлийг урих болно.”²

Залуучуудад заах хэдэн зөвлөмж

- *Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимлын боловсрол хэсгийг унш.* Хичээл сурлага болон сайн мэдээнээс суралцах талаар өөрийн хуримтлаулсан эерэг туршлагаа хуваалц. Ингэх нь энэхүү жишгийг үе тэнгийнхэнтэйгээ

ярилцаж, тэдний асууж болох асуултуудад хариулах боломжийг чамд олгох болно.

- Үе тэнгийнхээ найзад авьяас чадвар, сонирхдог зүйл дээрээ үндэслэн ажил мэргэжлийн болон боловсролын зорилго тавьж хэрэгжүүлэхэд нь тусал. Тавьсан зорилгоо хэрэгжүүлж эхлэх алхмуудыг төлөвлөхөд түүнд тусал.
- Боловсролын ач холбогдлын талаар гэр бүлийн үдэш зохион байгуулахыг бод (Энэ тухай чухал материал бол ахлагч Даллин Х.Өүкс, Кристен М.Өүкс нарын, “Learning and Latter-day Saints,” өгүүлэл юм *Лиакхона*, 2009 оны 4-р сар, 26–31).
- youth.lds.org-т орж, Залуучуудын цэсийн доорх “For the Strength of Youth” дээр дар. “Education”-ээс та нар боловсролын тухай судрууд, видеонууд (жишээ нь, “Давалгаагаар тэших үү эсвэл семинарт явах уу?”), Mormon Channel радиогийн хөтөлбөрүүд, асуулт хариулууд, өгүүлүүд түүний дотор Ерөнхий эрх мэдэлтнүүдийн хэлсэн үгсийг олж үзэх болно.

Хүүхдүүдэд заах хэдэн зөвлөмж

Шинэ зүйлсийг сурах нь хүүхдүүдэд зугаатай ч, энэ нь хэцүү байж болно. Энэ сарын дугаарт “Уншихад бэлэн” нэртэй өгүүлэл байгаа (хуудас 66). Чанга уншиж сайн чаддаггүй сэтгэцийн сааталтай нэг охины тухай бас Хүүхдийн Хэсгийн хүүхдүүд хэрхэн түүнд урам

СУДАЛЖ ЭЗЭМШИХ СУДРУУД

Сургаалт Үгс 4:7

2 Нифай 9:29

Алма 37:35

Сургаал ба Гэрээ 88:77–80

хайрлан дэмжсэн тухай энэ түүхэнд өгүүлдэг. Энэ түүхийг хүүхдүүдтэй хамт уншиж, дараах асуултуудын тухай хамтдаа ярилц:

- Ямар нэг хэцүү зүйлийг хийх гэж хичээх нь Мэрид ямар санагдсан бэ? Суралцах нь хэцүү ч гэсэн байнга сурч судалж байх нь яагаад чухал вэ?
- Мэрид туслахын тулд бусад хүүхдүүд юу хийсэн бэ? Гэртээ, сүм дээр болон сургууль дээр суралцахад нь бусдад туслахын тулд чи юу хийж болох вэ? ■

ЭШЛЭЛ

1. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (товхимол, 2011), 9-ийг үзнэ үү.
2. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* 10.



Залуу эмэгтэйчүүд ба НОМЛОЛД ЯВАХ ШИЙДВЭР



2012 оны 10-р сарын ерөнхий чуулганаар Ерөнхийлөгч Томас С.Монсон “Зохистой залуу эмэгтэйчүүд хэрэв хүсвэл 21 биш харин 19 наснаасаа номлолд үйлчлэх боломжтой” хэмээн зарласан. Тэрээр хэлэхдээ: “залуу эмэгтэйчүүд залуу эрэгтэйчүүдийн адил номлолд заавал үйлчлэх албагүй ч тэдний оруулдаг хувь нэмэр агуу бөгөөд тэднийг номлолд үйлчлэхийг дэмжин хүлээн авдаг”¹ гэсэн юм.

Эгч нар номлолд үйлчлэх эсэхээ хэрхэн шийддэг вэ? Доор өгүүлсэн түүхүүдэд эгч нар аль нь тэдний хувьд зөв болохыг Сүнсээр удирдуулан хэрхэн шийдсэн тухай өгүүлдэг.

Дутагдаж байсан зүйл

Хүүхэд байхад минь том болоод номлолд үйлчлэх үү гэж хэн нэг нь асуусан бол би үгүй гэж хариулах байсан. Харин том болж, бас ах эгч нараа номлолд үйлчлэхийг хараад энэ тухай бодол маань бага зэрэг нааштай болж байсан ч номлолд явах нь миний хийх зүйл биш юм шиг санагдсан хэвээр байв.

Би 21 нас хүрээд номлолд явах эсэх тухай боддог болсон ч энэ талаар хэзээ ч нухацтайгаар залбирч байсангүй. Цаг хугацаа өнгөрөх тусам надад ямар нэг зүйл дутагдаад байх шиг санагдах болов. Би ээждээ энэ тухай хэлтэл ээж маань намайг номлолын талаар бодож үзэхийг санал болгов. Миний насан дээр түүнд бас тиймэрхүү мэдрэмжүүд төрсөн бөгөөд номлолд үйлчлэх нь түүний хариулт байсан чиний хариулт ч мөн адил байж болно гэж ээж маань хэлэв.

Номлолын тухай залбирахаасаа би үнэхээр их айж байв. Номлолын талаар нухацтайгаар боддоггүй

байсан нэг шалтгаан нь би өөрийгөө үүнийг хийх хангалттай хүчтэй биш гэж боддог байсных юм. Би тав тухтай амьдралаа орхиж, магадгүй бүр шинэ хэл сурах хэрэгтэй болно. Би өөрийгөө сайн мэдээний тухай заах хангалттай мэдлэггүй хэмээн бодож байв. Гэвч би зорилготойгоор залбирсны дараа айдас маань алга болж, Их Эзэн надад хайртай бас намайг номлолд үйлчлэхийг хүсч байгаа гэсэн баттай хариултыг хүлээн авсан юм.

Хариултаа хүлээн авсны дараа өөртөө итгэх итгэлтэй болсондоо би маш их гайхсан. Сэтгэлийн зовнил болон өөртөө итгэлгүй байдал маань алга болсон. Харин ч сайн мэдээг заана гэхээр сэтгэл маань догдолж би номлолын хуудсуудыг бөглөж эхэлсэн. Ингээд удалгүй би Юта мужийн Солт Лейк хотын Ариун Сүмийн талбайн номлолд дуудагдсан юм.

Ребека Кейлер Монсон

*Насанд
хүрсэн залуу
эмэгтэйчүүд
нь бүрэн
цагийн
номлолын
үйлчлэлийн
талаар
өгөгдсөн
бошиглогчийн
зөвлөгөөг
хэрэгжүүлсэн
нь*

Ребека Кейлер Монсон

17 нас хүрмэгц хүмүүс намайг номлолд үйлчлэх үү хэмээн асууж эхэлсэн ч сайн шийдээгүй байсан тул би тэдэнд хариулдаггүй байв.

Гэвч 21 нас хүрэх үеэрээ би энэ тухай их бодож эхэлсэн. Би патриархын адислалаа уншиж, эцэг эхтэйгээ зөвлөж мөн залбирсан.

Надад номлолд үйлчлэх хүсэл төрөхгүй бас номлолд үйлчлэх хэрэгтэй гэж санагдахгүй байв. Би Ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн (1910–2008) хэлсэн “эгч нар номлолд үйлчилж болох ч заавал үйлчлэх албагүй”² хэмээх зөвлөгөөг санасан. Би мөн Сургаал ба Гэрээн дэх



ИЛЧЛЭЛТИЙН АРИУН СҮНС

“Нэг сонголт маань бидний амьдралд маш том өөрчлөлт гаргахад . . . мөн бид Сүнсний дагуу Түүний удирдамжийг эрэлхийлэн амьдрах аваас өөрсдийн зорилгоо биелүүлэхэд шаардагдах удирдамжийг хүлээн авна гэдэгтээ итгэлтэй байж болно. Их Эзэн бидэнд үргэлж туслах болно.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс “Revelation” Бригам Янгийн их сургууль дээр хийсэн Галын дэргэдэх ярилцлага ба Онцгой цугларалт дээр хэлсэн үгс (1982), 26.

“Хэрэв та нар Бурханд үйлчлэх хүсэлтэй аваас та нар уг ажилд дуудагдсан болой” (4:3) гэсэн зөвлөгөөг санасан.

Судрын тэр үгс намайг номлолд явахгүй гэсэн шийдвэрээ гаргахад тусалсан. Их Эзэнд залбиран өөрийн гаргасан шийдвэрээ хэлэх үедээ би амар амгалан ба бүрэн цагийн үйлчлэлээр бус ч би үргэлж номлогч байж чадна гэсэн баталгааг хүлээн авсан юм. Үүнээс хойш би гэрчлэлээ олон арга замаар хуваалцаж болно гэдгийг сурсан. Бид гэрчлэлээ Их Эзэний өгөөмөр сэтгэлийн тухай яриагаар, айлчлагч багшаа хийхдээ эсвэл гэр бүлийн түүх ба ариун сүмийн ажлаар дамжуулан хуваалцаж болдог. Би сайн мэдээний дагуу, Сүнсний удирдамжийг дагахыг хичээн амьдарч өөрийгөө номлолын ажилд бэлтгэж байгаа. Эми Саймон

Зоригтой бай

2010 оны эхээр надад зарим нэг бэрхшээл тулгарсан байлаа. Би толгойгоо сэргээхээр салхинд гарч алхав. Алхаж байх зуураа би өнгөрсөн зүйлст санаа зоволгүй харин ирээдүйнхээ тухай бодох хэрэгтэй хэмээн шивнэх Сүнснийг мэдэрсэн юм. Сургуулиа төгсөх зорилгынхоо тухай бодож эхэлтэл номлолын тухай бодол сүнслэгээр өдөөгдөн толгойд орж ирэв. Урьд нь би хэзээ ч номлолын тухай бодож байсангүй. Гэвч энэ бодол маань толгойноос гарсангүй бүр сэтгэл маань догдолж, үйлчлэх хүсэл төрөв. Гэсэн хэдий ч ийм том шийдвэр гарахын тулд илүү сайн бодох хугацаа хэрэгтэй хэмээн би шийдлээ.

Дараагийн хэдэн сар нь номлолд үйлчлэх сүнслэг өдөөлтүүдээр дүүрэн байлаа. Сүнслэг өдөөлтийг мэдрэхэд номлолд үйлчлэх хүсэл төрж, сэтгэл маань догдолж байсан ч эргэлзээ бас айдас төрдөг байв. Эмэгтэйчүүдийг номлолд үйлчлэхийг дэмждэг ч заавал үйлчлэх шаардлагагүй гэдгийг би мэдэж байсан. Энэ үеэр би намайг юу ч сонгосон Их Эзэн баяртай байх болно гэсэн санваарын адислал хүлээн авсан.

Дараагийн зун нь би номлолд үйлчилсэн охинтой нэг байранд амьдарсан юм.



Тэр номлолд үйлчлэхээр шийдэхийнхээ өмнө бас шийдсэн хойноо ч айж байсан гэж надад хэлсэн. Тэр надад Сүнс айдас ба эргэлзээгээр дамжуулан ярьдаггүй гэдгийг ойлгоход тусалсан юм 2 Тимот 1:7). Түүнтэй ярилцаж байхдаа би Сүнснийг мэдэрсэн. Би өрөөндөө ороод номлолд үйлчилж байгаа нэг найзаасаа ирсэн захиаг уншлаа. Захианд намайг Иошуа 1:9-г уншихыг хүссэн байсан бөгөөд Сүнс намайг уншихыг хүсч байгааг би мэдэрсэн.

“Тууштай бөгөөд зоригтой бай! Хаана явсан газарт чинь чиний Бурхан ЭЗЭН чамтай хамт байх учраас бүү чичирч айгун” гэсэн эдгээр үгс зүрх сэтгэлд маань шууд хүрсэн. Надад яг л Их Эзэнтэй нүүр тулан ярьж байгаа мэт санагдсан билээ. Номлолд үйлчилж чадна гэдгээ би мэдсэн. Надад айх хэрэг байхгүй учир нь үүнийг би ганцаараа хийхгүй Их Эзэн надтай хамт байх болно.

Энэ явдлаас хойш нэг сарын дараа би Иошуа 1:9 -г уриагаа болгосон Филиппины Айлоло Номлолд үйлчлэх дуудлагаа хүлээн авсан.

Кристен Николь Даннер

Өөр номлол

Би насан туршдаа бүрэн цагийн номлолд үйлчлэхээр төлөвлөж байлаа. Харин АНУ-ын Юта мужийн Бригам Янгийн Их Сургуульд орсныхоо дараа би санаа зовж эхэлсэн. Би үнэхээр номлолд үйлчлэх хэрэгтэй эсэхээ яаж мэдэх вэ? 21 нас хүрэхээсээ жилийн өмнөөс би Тэнгэрлэг Эцэгээс номлолд үйлчлэх хэрэгтэй эсэхээ асуун гуйж эхэлсэн. Гэтэл шашны хичээл заадаг нэг профессорын хэлсэн “Их Эзэн зогсоол дээр тавьсан машиныг жолоодож чадахгүй” гэсэн үгс миний

амьдралыг өөрчилсөн юм. Би ямар нэг үйлдэл хийхээр шийдсэн.

Би номлолынхоо хуудсыг бөглөөд дуудлагаа хүлээн авч, номлолд өмсөх хувцсаа худалдан аваад Ютагаас Хойд Каролина дахь гэр рүүгээ явлаа. Энэ үед би чин сэтгэлээсээ залбиран, мацаг барьж номлолдоо бэлтгэдэг байв.

Хойд Каролина дахь гэртээ ирсний дараа сургуульдээр танилцсан нэг залуу надтай уулзахаар Ютагаас онгоцоор нисч ирэв. Бид өөрсдийнхөө харилцааны талаар нухацтайгаар ярилцсан.

Би дахиад л чин сэтгэлээсээ залбирахад Их Эзэн миний гаргах шийдвэрт итгэж байгаа гэсэн мэдрэмж надад дахин төрсөн юм. Би үүрэг хариуцлагаа ухамсарлаж байсан ч итгэлтэйгээр сонголтоо хийвэл Их Эзэн миний гаргасан ямар ч шийдвэрийг дэмжинэ гэдэг баталгааг мэдэрсэн.

Номлолд явахаас арван хоногийн өмнө найз маань надад гэрлэх санал тавьсан. Би сайн бодохын тулд номлолоо хойшлуулсан юм. Тэгээд би сүй тавих шийдвэр гаргахад энэ нь зөв гэдгийг Сүнс надад болон сүйт залууд маань баталсан билээ.

Хэдийгээр би бүрэн цагийн номлолд үйлчлээгүй ч үүнд бэлтгэх нь миний амьдралыг өөрчилсөн. Их Эзэнтэй ойр байсан нь надад эхнэр ба эх хүн байх номлолдоо бэлтгэхэд маань тусалсан юм.

Кэси Рэндалл

Амьдралын туршлагууд

Би хүүхэд байхаасаа л сайн мэдээг хайрлах хайр ба хүчтэй гэрчлэлээр адислагдсан байв. Би номлолд үйлчлэх хэрэгтэй гэж шийдсэн тэр үеэ яг тодорхой санадаггүй ч номлолд явах болно гэдгээ үргэлж мэддэг байлаа. Би номлолд үйлчлэхэд тэнцэхүйц зохистойгоор амьдарна хэмээн аль эртнээс зорилго тавьсан байв.

Номлолын хуудсаа бөглөж байхдаа би мацаг барьж, залбирч мөн ариун сүмд ордог байлаа. Бишоптойгоо хамтран ажиллаж байхдаа би номлолд үйлчлэх талаар урьд нь үргэлж мэдэрдэг байсан тайван мэдрэмжийг хүлээн авсан.

Номлолын хуудсаа бөглөх явцад заримдаа хэцүү, амьдрахад их мөнгө шаардлагатай тул сургуульд явж, ажил хийх хэрэгтэй мэт санагдаж байв. Тэр үед би гэрээсээ хол коллежид сурч байв. Бүх найзууд маань гэрлэж байгаа мэт санагдсан. Мөн намайг номлолд явсан хойгуур хайрладаг хүмүүс маань өөрчлөгдөх болно гэж бодохоор надад аймшигтай санагдаж байв.



Надад номлолд үйлчлэх шийдвэр гаргахад нөлөөлсөн хүчтэй сүнсэлэг тохиолдол байгаагүй тул хэцүү санагдсан үед би амархан эргэлзэж эхлэв. Гэвч Чили Сантьяго Зүүн Номлолд дуудлагаа авсны дараа, номлолоо эхлэхээсээ өмнө үйлчлэх тэдгээр хүмүүсээ хайрлах хайраар Их Эзэн намайг адисалсан юм. Одоо би номлолд үйлчлэхээр шийдсэн маань зөв байсан гэдэг насан туршийн гэрчлэлтэй болсон. ■

Маделин Бэйли

ЭШЛЭЛҮҮД

1. Ерөнхийлөгч Томас С.Монсон “Чуулгандаа тавтай мориано уу” *Лиакхона*, 2012 оны 11-р сар, 4–5.
2. Гордон Б.Хинкли “To the Bishops of the Church,” *Дэлхий дахины удирдагчдын сургалт* 2004 оны 6-р сар, 27.

АСУУЛТУУДАД ХАРИУЛАХ НЬ

Бүх Хожмын Үеийн Гэгээнтнүүд номлолд үйлчлэх Бөстой юу? Үгүй ээ, бүх номлолын ажлууд нь сайн дурынх юм. Залуу эрэгтэйчүүдийг номлолд үйлчлэхийг хүсдэг бол залуу эмэгтэйчүүд номлолд үйлчлэх боломжтой байдаг харин ахимаг насны хүмүүс болон ахмад настай хосуудыг боломжтой бол үйлчлэхийг урамшуулан дэмждэг юм. Залуу эрэгтэйчүүд 18 наснаасаа эхлэн хоёр жил номлолд үйлчилж болдог. Залуу эмэгтэйчүүд 19 наснаасаа эхлэн нэг жил хагас номлолд үйлчилж болно. Тэтгэвэрт гарсан ахимаг насны гишүүд ба хосууд нь 6-23 сарын хугацаагаар олон төрлийн үйлчлэл хийж болдог.

Сүмийн гишүүд “Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтон” (Матай 28:19) хэмээх Их Эзэний зааврыг даган номлолын үйлчлэлийг бусдыг болон Их Эзэнийг хайрлах хайраа харуулах боломж хэмээн үздэг.

Нэмэлт мэдээллийг mormon.org/faq-н номлогч нарын тухай сэдэв гэсэн гарчиг дээр даран орж үзнэ үү.

Ахмад номлогчдын талаарх
нэмэлт мэдээллийг авахын
тулд өөрсдийн санваарын удир-
дагчидтай уулзаж мөн [lds.org/
service/missionary-service](https://www.lds.org/service/missionary-service) вэб сайтад
зочилно уу.

Ямар НОМЛОЛ



ХАМГИЙН САЙН БАЙХ ВЭ?

Таны нөхцөл байдлаас үл хамааран ахмад номлогчоор үйлчлэх боломж та бүхэнд бий.

	Бүрэн цагийн номлол	Сүмийн үйлчлэлийн номлол	Удаан-хугацааны сайн дурын ажилтан
Хэн үйлчилж болох вэ?	Ахмад настай хос болон ахимаг настай эгч нар	Ахмад настай хос болон ахимаг настай ах, эгч нар	Хүн бүр
Ариун сүм орох зохистой гишүүн байх ёстой юу?	Тийм	Тийм	Үгүй
Үйлчлэх цаг	Долоо хоногт 32-оос илүү цаг	Долоо хоногт 8-32 цаг	Долоо хоногт 8-аас бага цаг
Үйлчлэх хугацаа	6–23 сар	6–24 сар (гадасны ерөнхийлөгчийн зөвшөөрөлтэйгөөр илүү удаан үйлчилж болно.)	Хугацаагүй
Ажил эрхлэлтийн байдал	Ер нь бол тэтгэвэрт гарсан байдаг	Тэтгэвэрт гарсан эсвэл ажилладаг байж болно	Тэтгэвэрт гарсан эсвэл ажилладаг байж болно
Хаана	Гэрээсээ хол	Гэртэйгээ ойрхон эсвэл гэрээсээ	Гэрээсээ
Санхүү	Номлолынхоо зардлыг даах боломжтой байх ёстой. Байрны түрээс (хосуудын хувьд сар бүр \$1,400 хүртэл), эрүүл мэнд ба шүдний даатгал, номлолын үеэр зарцуулах тээврийн зардал болон хувийн зардлуудаа төлөх ёстой.	Номлолынхоо зардлыг даах боломжтой байх ёстой. Байрны түрээс, эрүүл мэнд ба шүдний даатгал, номлолын үеэрх тээврийн зардал болон хувийн зардлуудаа төлөх ёстой.	Хувийн зардлаа даах ёстой

ГЭРЛИЙГ ХУВААЛЦАХУЙ

АНУ-ын Өмнөд Калифорнид аянгын цахилгаан цахилж, аадар бороо цутгасан нэгэн ер бусын бүгчим халуун өдөр боллоо. Би сэрүүхэн гэртээ амарч, кино үзэхээр зэхэж байлаа. Би кино үзэхээр суунгуутаа найз Шерилл рүү утасдах хэрэгтэйгээ мэдэрлээ.

Түүн рүү утасдаад тэднийд өглөөнөөс хойш цахилгаан тасарсныг мэдэв. Найз маань хөлдүү хүнс нь гэсч, сүү нь гашлах байх гэж санаа нь зовж байсан учир бид түүний

хоол хүнсийг манай гэрийн хөргөгчинд зөөж хийлээ.

Маргааш орой нь Шерилл бид хоёр түүний гэрийн өмнө зогсож байв. Замын энэ талын бүх байшин харанхуй байхад гудамжны нөгөө талд цахилгаан гэрэлтэй байв. Нэг байшин миний анхаарлыг онцгой татлаа. Гудамжны нөгөө талд хурц гэрэл гялалзсан байшингийн сэрүүн лавринд суугаа хүмүүс хөгжилтэй ярилцан чанга инээлдэж харагдана.

Дараагийн хэдэн өдөр ч энэ дүр зураг миний санаанаас гарсангүй. Тийм эсрэг, тэсрэг байдалд би үнэхээр их гайхсан. Гудамжны нэг талд тас харанхуй байхад нөгөө

талд хурц гэрэл гялалзаж байдаг. Гудамжны нэг талд хүмүүс харанхуйд сууж байхад хөршүүд нь гэрэлтэй байдаг.

Би энэ дүр зургийг гудамжины нэг талд хүмүүс сайн мэдээний гэрлийн ач тусыг амьдралдаа эдэлж байхад нөгөө талд нь бусад хүмүүс харанхуйд сууж байгаатай зүйрлүүлэн олонтоо боддог байж билээ. Би өөрийгөө сүмийн найз нартайгаа сэрүүн лавринд сайн мэдээний гэрэлд баясан түүнийг бусадтай хуваалцахгүй сууж байгаагаар төсөөлөн бодов.

Дэлхийд хүн бүр нэгэн гэрэлтэй өөрөөр хэлбэл Христийн Гэрэлтэй

Би харанхуйд зогсож байхдаа, хөршүүд маань харанхуйд амьдарч байхад би гудамжны нөгөө талд сайн мэдээний гэрэлд баясан байгаа хүмүүстэй хэчнээн адилхан болохыг олонтоо эргэцүүлэн бодож билээ.



төрдөг билээ. Сүмийн гишүүд бид сайн мэдээг хуваалцсанаар энэхүү гэрлээ нэмэгдүүлэх онцгой боломжтой юм. Аврагч ийн заасан байдаг:

Болгоогтун, хүмүүс лаа асаагаад мөн үүнийгээ тогоон дор нуудаг бил үү? Үгүй ээ, харин лааны тавиур дээр тавьж, мөн энэ нь гэрт байгаа бүгдэд гэрэл өгдөг;

Тиймийн тул, тэд та нарын сайн ажлуудыг харж, тэгээд тэнгэр дэх Эцэгийг тань аддаршуулж болохын тулд гэрэл тань энэ хүмүүсийн өмнө тийн туяаран гийг (3 Нифай 12: 15–16).

Сүмийн гишүүд бид Христийн тухай гэрчлэлээрээ бүх хүмүүсийг ялангуяа сүнсний харанхуйд байгаа хүмүүсийг гэрэлтүүлэх үүрэг хариуцлагатай билээ. Би дээрх туршлагын дараа Тэнгэрлэг Эцэгийн нинжин сэтгэлт хүү байж ая тухтай сэрүүн лаврингаасаа босч харанхуйд суугаа хөршүүддээ сайн мэдээний гэрлийг хүргэхээр шийдэж билээ. ■

Долорес Собиески, Калифорни, АНУ

АНХНЫ ҮЗЭГДЛИЙН ТУХАЙ МИНИЙ АНХНЫ ЗАЛБИРАЛ

Намайг номлогчдоос ярилцлага авч байх үед надад тохиолдсон зарим сорилт бэрхшээл шийдэгдсэн учраас би баптисм хүртэхээр шийдсэн юм. Ийнхүү шийдсэн нь Мормоны Ном үнэн үү гэдгийг эсвэл Иосеф Смит Тэнгэрлэг Эцэг, түүний Хүү Есүс Христ хоёрыг харсан нь үнэн үү гэдэг талаар залбирч, гэрчлэлтэй болсных биш юм. Номлогчид намайг эдгээр зүйлсийн талаар залбирахад урьсан ч би залбираагүй юм. Би зөвхөн номлогчдын заасан зүйлд л итгэж байлаа.

Баптисм хийлгэснээс хойш гурван жилийн дараа цуглааны байрын индэр дээрээс нэг эгч Мормоны Ном болон Иосеф Смитийн тухай гэрчлэлээ хуваалцаж байв. Тэр эгч: “Бид Мормоны Ном үнэн үү гэдгийг мөн Иосеф Смитэд тохиолдсон явдлын тухай үнэхээр залбирч үзсэн үү?” гэсэн асуултыг тунгаан бодохыг хүн бүрээс хүслээ. Энэ асуулт надад гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн учраас

“Би эдгээр зүйлсийн талаар огт залбираагүй. Харин одоо залбирах ёстой, залбирах ч болно” гэж дотроо бодлоо.

Тэр үед миний итгэл сулхан, судруудын тухай гэрчлэл нимгэн байсан учраас үйлдэл хийх хүсэл эрмэлзэл надад төрөв. Тэр орой би Тэнгэрлэг Эцэгт хандан Иосеф Смитийн талаар Мормоны Ном үнэн үү гэдгийг мэдэхийн тулд залбирлаа.

Би эхний удаа бас хоёр дахь удаагаа залбираад юу ч мэдэрсэнгүй. Би санаагаар унахгүйн тулд Иосеф ганцаараа залбирахын тулд ойн цоорхой руу хэрхэн очсон тухай дүрсэлсэн Иосеф Смит–Түүх 1:14–17 дээр судраа нээв.

“Өөрийнхөө чанх орой дээр нарнаас илүү хурц гэрэлтэй гэрлэн багана над уруу алгуурхан доош бууж ирэхийг би харлаа.

Миний бие чөлөөлөгдсөн нь удалгүй мэдэгдэв. . . . Мөнөөх гэрэл над дээр тогтоход би хоёр Хүнийг харав.”

Эдгээр үгсийг уншихад бүх биеэр минь цахилгаан гүйдэл гүйх шиг болж би чичирч эхлэв. Би Иосеф Смит Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү Есүс Христ хоёрыг үнэхээр харсныг тэр даруй мэдлээ. Бурхан Мормоны Номыг Өөрийн бошиглогчоор дамжуулан орчуулсан учраас энэ ном бидэнд байгаа гэдгийг би мэдэж байлаа.

Тэнгэрлэг Эцэг Анхны Үзэгдэл үнэнийг ийнхүү надад гэрчилсний төлөө би баярлан талархаж явдаг билээ. Хэрэв сайн мэдээ сэргээгдээгүй бол би Гэтэлгэгчээ мэдэхгүй байх байсан гэдгийг ойлгосон юм. Сайн мэдээний бүрэн байдал үнэн гэдгийг би мэднэ. Хэрэв би эцсийг хүртэл итгэлтэйгээр тэвчвэл Бурханы адислалуудыг хүлээн авах болно гэдгээ би мэдэрсэн. ■
Жинг Жуан Чен, Тайвань

БИ САНВААР АВЧ ЧАДАХ БОЛОВ УУ?

Олон жилийн өмнө би Скааф ахын гэрийн багшийн хамтрагч байхдаа эхнэрт нь санваарын адислал өгөхөөр эмнэлэг дээр очиж билээ. Скааф эгч Анни Леддар гэгч эмэгтэйтэй нэг өрөөнд хэвтэн эмчлүүлж байсан юм. Анни Леддар эмчилгээгүй хавдраар өвчлөн удаан хугацаагаар эмнэлэгт хэвтэж байгаа бөгөөд амьд явах хугацаа нь тун богинохон болсон байлаа.

Би адислал өгөхөөсөө өмнө хоёр орны хооронд татсан хөшгийг хаах гэснээ Анниг адислалыг хараг гэж бодоод нээлттэй орхив. Бид юу хийх гэж байгаагаа тайлбарлан,

адислалыг харах уу гэж түүнээс асуулаа. Тэр адислалыг харахыг хүсч байна гэлээ. Нас барсан түүний нөхөр өөр сүмийн үйлчлэгч байсан гэнэ. Тиймээс тэр бид юунд итгэдгийг сонирхлоо. Скааф ах бид хоёрыг адислал өгөхөд Анни сонсож байв.

Хэд хоногийн дараа Скааф эгчийг эмнэлгээс гэртээ гарах үеэр Анни санваарын адислал авч болох уу гэж хүслээ. Скааф ах бид хоёр түүнд адислал өгөхийн тулд эмнэлэг дээр дуртайяа очив. Аннигийн хавдар эмчлэгдээгүй ч, эрүүл мэндийн байдал нь их сайжирсан.

Тэр эмэгтэй сайн мэдээний тухай тодорхой мэдэхийг сонирхсон болохоор би номлогчдоос эмнэлэг дээр очин, түүнд заахыг хүслээ. Тэр сайн мэдээний захиасыг чин сэтгэлээсээ сонсож, баптисм хүртэхээр сонгосон юм. Баптисмынх нь дараа бид Анниг долоо хоног бүр тэргэнцэрт нь суулгаж, сүм рүү аваачихын тулд эмнэлэг дээр ирдэг байв.

Анни өвчтэй учраас ойр зуур явах нь хүндрэлтэй байсан ч Их Эзэнд үйлчлэх өөрийн гэсэн арга замыг удалгүй олсон юм. Бид түүнд бичгийн машин авчирч өгөхөд тэр өдөр эмнэлэг дээр гэр бүлийн түүхээ бичихэд хэдэн цаг зарцуулдаг болов. Анни эмч нарын бодсоноос гурван жил илүү амьдарч, нас барахаасаа өмнө гэр бүлийнхээ гишүүдийн хэдэн зуун нэрийг ариун сүмийн ёслолуудад зориулан бэлтгэсэн юм.

Аннийг нас барсны дараа Скааф эгч Аннигийн өвөг дээдсээс олон эмэгтэйчүүдийн төлөө ариун сүмийн ёслолуудыг төлөөлөн гүйцэтгэжээ.

Миний мэдэхээр Анни бол гэр бүлээсээ Сүмд элссэн цорын ганц гишүүн байлаа. Түүний гэр бүлийн амьд байгаа гишүүд Сүмд элсээгүй ч, нас барсан өвөг дээдсээс нь олон хүн тэдний өмнөөс гүйцэтгэсэн төлөөлөх ёслолын төлөө баяртай байсан гэдэгт би итгэлтэй байна.

Бидний уулзсан хүмүүс сайн мэдээг хүлээн авахад бэлэн байгаа эсэхийг бид огт мэддэггүй. Санваарын адислалыг гэрчилснийх нь дараа Аннигийн зүрх сэтгэлд бидний суулгасан гэрчлэлийн үр цэцэглэн, Тэнгэрлэг Эцэгийн хэдэн зуун хүүхдийг адисалсных нь төлөө би баярлан талархаж явдаг билээ. ■

Арт Крейтер, Нью-Йорк, АНУ

Би адислал өгөхөөсөө өмнө хоёр орны хооронд татсан хөшгийг хаах гэснээ Анниг адислалыг хараг гэж бодоод нээлттэй орхив.



МИНИЙ ТӨРСӨН ӨДРИЙН ХҮСЭЛ

Би 18-тайдаа сайн мэдээг хүлээн авахдаа бүхнээс илүү амтат тэрхүү жимсийг амталснаа ойлгосон. Би агуу баяр баяслыг мэдэрсэн ч, төөрч, замаа олохгүй тэнүүчилж явсан гэр бүлийнхээ гишүүдийн тухай бодож байлаа. Би гэр бүлээсээ ганцаархнаа Сүмийн гишүүн байсандаа ихэд харамсдаг байсан ч тэдний нүд, чихийг үнэнд хэрхэн нээхийг сайн мэддэггүй байлаа.

Номлогчдын үгийг сонсоход гэрийнхнээ итгүүлэхээр би олон арга замаар оролдож үзсэн. Гэвч намайг хичээх тусам тэд улам эргэлздэг болов.

Миний урам хугарч цаашид сүмд явахаа больё гэж бодож билээ. Гэвч нэг удаа залбиртал: “Үүний дараа намайг үгүйсгэх аваас, намайг мэдэхгүй байсан нь та нарт дээр байх болно” (2 Нифай 31:14) гэсэн судрын үгс санаанд орж ирлээ. Би шаргуу залбирч, судруудыг уншин, Сүмийн цуглаануудад явж, амьдралд минь ирсэн адислалууд дээр анхаарал төвлөрүүлдэг болов. Үүний үр дүнд сэтгэлийн эмзэглэл арилж эхэллээ.

Төрсөн өдрөө ойртох тусам төрсөн өдрийн үдэшлэгээ гэртээ хийж, Сүмийн гишүүн найз нараа бүгдийг нь түүний дотор бүрэн цагийн номлогчдыг урихаар сүнсээр нөлөөлөгдсөнөө би мэдэрлээ. Би гэрийнхнээ Сүмийн гишүүдтэй ойр дотно харилцаатай байхыг хүсдэг байлаа. Миний бодлоор Сүмийн гишүүд бол дэлхий дээрх хамгийн аз жаргалтай хүмүүс юм. Миний хувьд төрсөн өдрийн үдэшлэг нь гэр бүлийн үдэш болох ёстой байлаа.

Тэр өдрөөс хойш байдал өөрчлөгдөв. Номлогчид манайхаар



Төрсөн өдрөө ойртох тусам төрсөн өдрийн үдэшлэгээ гэртээ хийж, Сүмийн гишүүн найз нараа бүгдийг нь түүний дотор бүрэн цагийн номлогчдыг урихаар сүнсээр нөлөөлөгдсөнөө би мэдэрлээ.

үргэлж ирдэг болж, манай гэрийнхний дотны найзууд болов. Нэг өдөр аав маань манай гэрийнхэн бүгдээрээ номлогчдын үгийг сонсож, сүмд явахыг хүсч байгаагаа хэлэв. Би мэл гайхаж хоцров.

Намайг баптисм хүртсэнээс хойш гурван жилийн дараа гэрийнхэн маань бүгдээрээ баптисм хүртлээ. Баптисмын ёслолын үеэр ээж гэрчлэлээ хэлж, аав номлогчдод талархал илэрхийлэв. Тойргийн гишүүд тэднийг хөрвөсөнд маш их баярласан.

Ямар сайхан юм бэ? Миний урсгасан нулимс, тавьсан зорилго

маань үр дүнд хүрсэн юм. Гэвч бүхнээс чухал нь номлогчид болон тойргийн гишүүдийн хайр, нөхөрлөлийн ачаар аавын минь зүрх сэтгэл зөөлөрч уярсан явдал байлаа. Есүс Христийн сайн мэдээгээр амьдардаг үлгэр жишээнийхээ улмаас бүх гишүүд номлогчид байдаг. Гэрийнхэн маань Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг хүлээн авсны төлөө би баярлан талархаж явдаг. Энэ төлөвлөгөө үүрд хамт байх боломжийг гэр бүлүүдэд олгодог билээ. ■

Анжелика Карбонелл Дигал,
Филиппин



Ахлагч Майкл
Т.Рингвуд
Далын

Итгэл, найдвар ба харилцаа

Хүсэл, итгэл хийгээд найдвар биднийг гэрлэлт рүү хөтөлдөг хүмүүс хоорондын харилцааг хөгжүүлэхэд түлхэц үзүүлдэг.

Та эхнэр болох хүнийхээ сайн ба сул талын тухай жагсаалт гаргасан уу? Өсвөр насны хүүгийн минь ихэд сонирхон асуусан энэ асуулт миний тэмдэглэл дэх нэгэн жагсаалтаас үүдэлтэй юм. Энэ бол зүгээр л хэн нэгний сайн ба сул талын тухай жагсаалт биш байлаа. Энэ жагсаалтыг би 30 жилийн өмнө хүүгийнхээ ээжид гэрлэх санал тавихаасаа өмнө хийсэн юм. Хэчнээн эрэгтэйчүүд үүнтэй адил жагсаалт хийдгийг би мэдэхгүй, гэвч би 24 настай, коллежийн оюутан байхдаа гэрлэх тухай тунгаан бодоод, ийм жагсаалт гаргах нь зөв гэж шийдсэн юм.

Хайр сэтгэлтэй хүнээ сонгоход анхаарах зүйлсийн тухай миний хүү тэр өдөр ямар асуултууд асуусныг би санахгүй байна. Хүү маань нөгөөх жагсаалтыг ихэд сонирхон үзсээр байлаа. “Ээжийн талаар Аав жагсаалт хийсэн байна! Нааш ирээд үзээч!” гэж тэр дүү нартаа хандан хашигирсныг би огт мартдаггүй юм. Гэвч одоо эргээд санахад тэр надаас олон асуулт асууж болох байсан гэж би бодож байна. Жишээлбэл:

Та ээжид хайргүй байсан юм уу? гэж тэр эхлээд асуух ёстой байсан. Би энэ асуултанд тийм ээ гэж

хариулах байсан. Чухам тиймээс л би жагсаалт хийсэн хэрэг шүү дээ. Би үнэхээр түүнд хайртай байсан, иймээс би аз жаргалтай байхыг юу юунаас илүү хүсдэг байлаа. Тэр жагсаалтанд би түүнд хайртай байсан уу үгүй юу гэдэг нь гол биш харин би түүнийг яаж аз жаргалтай болгох вэ? гэдэг дээр илүү анхаарсан юм.

Та хоёр хамт байж цагийг хөгжилтэй өнгөрөөдөг байсан уу? Би дахиад л тийм гэж хариулах байсан. Чухам тиймээс л би жагсаалт гаргасан хэрэг шүү дээ. Надтай хамт байснаар тэр аз жаргалтай болох байх гэсэн найдвараа бодит болгон харахад энэ жагсаалт надад тусласан юм.

Ээж тантай суух тэр хүн мөн байсан гэдэгт та итгэж байсан уу? Энэ бол хамгийн ээдрээтэй асуулт байх байлаа. Би энэ асуултанд мөн л тийм ээ гэж хариулах байсан. Ээж чинь “миний гэрлэж болох хамгийн тохиромжтой хүн” байсан гэдэгт би итгэдэг байсан ч, итгэл минь миний үйлдлээр ажил хэрэг болохыг би хүсдэг байсан юм.

Номлолын ерөнхийлөгч маань надад итгэлийн тухай бас хүсэл эрмэлзэл, итгэл найдвараас улбаатай түүний үр дагавруудын тухай олон



зүйл заадаг байлаа. Тэр үед эдгээр сургаалууд мөнхийн ханиа судлахад надад хэрхэн нөлөөлөхийг би бүрэн ойлгоогүй байсан. Цаг хугацаа өнгөрөх тусам би уг асуудлыг илүү сайн ойлгодог болсон гэж боддог. Надад үзүүлсэн нөлөөнийх нь төлөө би Ерөнхийлөгч Ф.Рей Хокинст маш их баярлаж явдаг. Намайг 20 настай номлогч байхад манай номлолын залуу ерөнхийлөгч судар нээж, итгэлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тайлбарласан нь амьдралынхаа талаар чухал шийдвэр гаргахад хожим нь надад нөлөөлсөн юм.

Итгэлийн талаарх Алмагийн сургаалууд

Итгэлийн тухай Ерөнхийлөгч Хокинсийн хуваалцсан зүйлсийн дотор зорамчуудын дундах ядууст заасан Алмагийн сургаалууд байсан юм. Алма хүсэл хэмээн өөрийн дүрсэлсэн итгэлийн өчүүхэн хэсэгтэй байх хэрэгтэйг тогтоосон юм (Алма 32:27-г үзнэ үү). Ямар нэг зүйлийг бий болгох хүсэл бол итгэлээ нэмэгдүүлэхэд шаардлагатай алхам хийхэд бидэнд хүчтэй нөлөө үзүүлдэг.

Итгэлийн хоёр дахь тунхаг бол хүслээс юу ирдэг тухай Алмагийн заасан зүйл: *итгэл юм*. Тэрээр зорамчууд түүний үгсийг зүрх сэтгэлдээ байрлуулж, хүслээ итгэл болгон хувиргахын төлөө ажиллахыг тэдэнд зааварлажээ (27-р шүлэг-г үзнэ үү). Хүсэл итгэл хоёрын энэхүү нэгдэл бидний зүрх сэтгэлд томорсон үед бид түүнийг нэн чухал болохыг ойлгодог. Энэ нь бидний ухаан санааг тэлж, ойлголтыг гэгээрүүлж эхэлдэг юм. Энэ нь нэн хүсүүштэй болж эхэлдэг. (28-р шүлэг -г үзнэ үү.)

Найдвар бол итгэлийн өөр нэг чухал хэсэг юм. Итгэл бол юмсын тухай төгс мэдлэг биш гэдгийг Алма даруухан зорамчуудад заасан ажээ. Энэ бол “үнэн хийгээд үл харагдах

зүйлүүдэд итгэх *итгэл*” (Алма 32:21; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) юм. Найдвар бол итгэлийн чухал хэсэг гэдгийг Мормон бас заасан бөгөөд тэрээр, “Та нар найдваргүйгээр яахан итгэлийг олж чадах билээ?” хэмээн Моронайд хэлсэн юм. (Моронай 7:40). Найдварыг ирээдүйд ямар нэг зүйлийг улам сайн болохыг харах чадвар гэж дүрсэлж болно.¹ Миний жагсаалт бол “[найдварт] агуу аз жаргал, амар амгалан байдаг” (Абрахам 1:2) хэмээн тодорхойлсон Абрахамын нэгэн адил, амьдралын ханиа сонгохын төлөө итгэлийн мэлмийгээр ирээдүйг угтан харах арга зам байсан юм.

Итгэлийн өчүүхэн хэсэг болох хүсэл надад байсан учраас, итгэлээ төгөлдөржүүлэхийн тулд надад *итгэл, найдвар* хэрэгтэй байлаа. Мөн Розалийг надтай гэрлээч гэж гуйснаар итгэлээ үйлдэл болгох нь надад хэрэгтэй байв. Тэр жагсаалт бол миний хүсэл, итгэл, найдварын илрэл байсан бөгөөд итгэлээ төгөлдөржүүлэхийн тулд шаардлагатай үйлдлийг хийх зоригийг надад өгснөөрөө чухал байсан юм. Итгэл хэрэв үйлсгүй бол үхмэл юм гэж Иаков сургасан билээ (Иаков 2:17-г үзнэ үү). Хүсэл, итгэл, найдвар гэсэн эдгээр бүрэлдэхүүн хэсгүүд намайг том асуулт руу хөтлөөгүй бол би гэрлэлтэндээ агуу аз жаргал, амар амгаланг олоход эдгээр зүйлс надад хэмжээлшгүй ихээр тусалсан юм. (Харамсалтай нь, намайг Розалитай гэрлэх саналаа анх тавихад тэр татгалзсан хариу өгсөн ч, энэ бол түүх болж өнгөрсөн юм. Үйл явдал бидний төлөвлөснөөр эсвэл бидний товлосон цагт болоогүй үед ч, итгэл бидний амьдралд гол үүрэг гүйцэтгэсэн хэвээр байдаг.) Розалигийн татгалзсан хариу бид хоёрт хоёуланд тэвчээртэй байж сайн бодох хугацааг олгосон бөгөөд бид хоёр хожим нь 1982 оны арванхоёрдугаар сарын цастай



нэг өдөр хуримласан билээ.

Итгэл бидний хийдэг бүх зүйлд түүний дотор болзох болон ирээдүйн ханиа сонгон судлахад нэн чухал юм. Хүсэл, итгэл, найдвар нь чухамдаа бидний хүсэн хүлээх ёстой агуу аз жаргал, амар амгалан бөгөөд гэрлэлт рүү хөтлөх харилцааг хөгжүүлэхийн тулд үйлдэл хийхийг биднээс шаарддаг билээ. Та аз жаргалын төлөвлөгөөг дагахыг хүсдэг үү? Төлөвлөгөөг дагах нь илүү аз жаргал, амар амгалан руу хөтөлдөг гэдэгт та *итгэдэг* үү? (Төлөвлөгөөг дагаж, ариун сүмд гэрлэх нь илүү агуу аз жаргал, амар амгалан руу хөтөлдөг гэсэн миний үгэнд итгэгтүн.) Та аз жаргалтай гэрлэлтэд найддаг уу? Найдвар ирээдүйд өөрийн чинь байдлыг улам сайжруулна гэдэгт итгэдэг үү? Хэрэв та эдгээр асуултуудад тийм гэж хариулбал итгэлээ үйлдлээр гүйцээх шаардлагатай байгаа гэсэн үг. Хэн нэгнийг болзоонд урь! Болзох саналыг хүлээн ав! Өөртэйгөө адил санаа бодолтой залуу насанд хүрэгчидтэй уулзан танилцах боломжийг



өөртөө олго. Эцэст нь, илүү агуу аз жаргал, амар амгалан руу хөтлөх замыг сонгон дага.

Иосеф Смитийн итгэлийн үлгэр жишээ

Иосеф Смитийн итгэлийг хүсэл, итгэл, найдварын нэгдлийн үлгэр жишээ болгон дагацгаая.

Иосеф Есүс Христийн үнэн Сүмийг олохыг хүссэн билээ. Түүний хүсэл маш их хүчтэй байсан учраас “Та нарын хэн нэгэнд нь мэргэн ухаан дутвал Бурханаас гуйг” (Иаков 1:5) гэсэн судрууд руу түүнийг хөтөлсөн юм. Тэрбээр энэ судрыг тунгаан бодсон юм. Тэрээр мэргэн ухаантай байхыг хүсч, хэрэв Бурханаас гуйвал үүнийг хүлээн авах болно гэдэгт *итгэж* байлаа. Тэрээр учир шалтгааны уялдаа холбоотой зүйлийг хийж, Бурханд хандан залбирч, гуйсан юм. Энэ тухай хормын төдийд бодоод үз. Иосеф үнэнийг мэдэх хүсэлтэй байлаа. Тэр Иаковын үгсэд итгэсэн юм. Тэр хариу авна гэдэгт найдаж байв. Хэрэв Иосеф тэр үед итгэлээ ашиглаагүй

бол бид өнөөдөр энд байхгүй байсан. Тэр итгэлээ ашигласан учраас ойн цоорхойд очиж, залбирсан юм. Иосеф ойн цоорхой руу очиж залбирахаар явахдаа хариу авна хэмээн хүсэн хүлээж байсан гэдэгт би итгэдэг. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр түүн дээр хүрч ирнэ гэдгийг тэр хүсэн хүлээгээгүй байж болох ч хариу хүлээн авна гэдэгт итгэлтэй байсан юм. Итгэлийн ямар агуу үлгэр жишээ вэ! Тэрбээр хүсч, итгэж, найдан тэгээд үйлдсэн юм.

14 настай хөвгүүний итгэл дэлхийг өөрчилсөн. Ариун ойн цоорхой дахь Иосефын залбирлын ачаар тэнгэр нээгдэж, Бурхан бошиглогчоор дамжуулан хүүхдүүдтэйгээ дахин ярьж эхэлсэн билээ.

Итгэлээ харуулах та нарын олон боломжийн нэг

Их Эзэн өнөө үед Бошиглогчоороо дамжуулан ярьсаар байна. Жил хагасын өмнө Ерөнхийлөгч Томас С.Монсон ийн хэлжээ:

“Тэрлэлтийн тухай ул суурьтай бодож, үүрд мөнхийг хамтдаа

туулах ханиа эрж олох цаг та нарт ирээд байна. Хэрэв та нар ухаалгаар сонгож, гал голомтоо бадраахад амжилт олно гэдэгт шийдвэр төгс байх юм бол гэрлэлтээс өөр энэ дэлхийд та нарт агуу аз жаргалыг юу ч авчирч чадахгүй.

“Гэрлэхдээ, . . . зөвхөн Их Эзэний өргөөнд гэрлэх хүсэлтэй бай. Санваартнуудын хувьд өөр сонголт байх ёсгүй. Гэрлэх боломжоо алдахгүйн тулд анхааралтай сэргэг бай. Ирээдүйн хань болох хүнтэйгээ зохистой харилцаа тогтоож цагийг хамтдаа сайхан өнгөрүүлэхийн сацуу ойр дотно үерхэн нөхөрлөх хэрэгтэй.”²

Та хүсэл, итгэл, найдвараа над шиг жагсаалтаар харуулах шаардлагагүй байж болно. Гэвч та нар эдгээр чанарыг харуулбал эдгээр нь түүнтэй хамт агуу аз жаргалыг олох амьдралын ханиа эрж олоход Их Эзэний бошиглогчийн зөвлөгөөг дагаснаар итгэлээ гүйцэлдүүлэхэд тань туслах болно. Таны хүсэл, итгэл, найдвар нь ухаалаг сонголт хийхэд тань бас туслах болно.

Мөнхийн гэрлэлтийн зорилго тавьж, түүндээ хүрэхийн төлөө хичээн чармайхаас ирэх адислалууд нь “хамгийн эрхэм, . . . амтат бүхнээс дээд амтат, . . . цэвэр бүхнээс илүү цэвэр” хэмээн Алмагийн дүрсэлсэн сайн мэдээний үр жимсийг амтлахад та нарыг удирдах болно.” Тэрээр цааш нь хэлэхдээ, “Та нар бүр цадталаа, та нар өлсөхгүй бас цангахгүй болтлоо [эдгээр жимсэн] дээр найрлах болно” (Алма 32:42) гэжээ. Ирээдүйгээс айхын оронд итгэлээ ашигла. Тэгвэл энэ нь Их Эзэний амлалтуудыг олж авах боломжийг та нарт нээж өгөх болно. ■

ЭШЛЭЛ

1. Деннис Ф.Пасмюсен, “What Faith Is,” Larry E. Dahl and Charles D. Tate Jr., eds., *The Lectures on Faith in Historical Perspective* (1990), 164-ийг үзнэ үү.
2. Томас С.Монсон, “Priesthood Power,” *Лианхона*, 2011 оны 5-р сар, 67–68.



Ахлагч
Хуан А.Юседа
Далын

МОРМОНЫ НОМНООС ХУВААЛЦ

Мормоны Номыг уншиж байхдаа мэдэрсэн гурван зүйлийн улмаас би энэ номыг үнэн гэдгийг мэдсэн билээ.

Би 18-тай байхдаа төрж өссөн Перугийн Лимад амьдарч байлаа. Тэр үед манай аав удаан хугацаанд уулзаагүй нэг сайн найзтайгаа гэнэт уулзсан юм.

Найз нь наснаасаа залуу харагдаж, сайхан хувцасласан нь аавд гүнзгий сэтгэгдэл төрүүлжээ. Аав найзад нь яагаад ийм өөрчлөлт гарсныг сонирхон, “Чи хонжворт сугалаа хожоо юу?” гэж асуув. Найз нь “Сугалаа хожихоос илүү зүйл тохиолдсон. Би одоо Мормоны сүмийн гишүүн болсон. Тэгээд сайн мэдээг өөртэй чинь бас гэр бүлтэй чинь хуваалцахыг хүсч байна” гэж тэр хариулжээ.

Ахлагч Юседа
(баруун талаас
хоёр дахь нь)
Перугийн Лимад
Сүмд элссэнийхээ
дараахан гэр
бүлийнхээ хамт



Аав найзыгаа тоглож байна гэж бодоод “За тийм байж. Хэрэв чи номлогчдоо явуулахыг хүсч байгаа бол, тэг л дээ” гэв. Найз нь үүнийг үнэнээсээ ярьж байсан болохоор хоёр гурав хоногийн дараа номлогчид ирж, манай хаалгыг тогшив. Энэ явдал гайхамшигтай туршлагын эхлэл болсон юм.

Номлогчид бидэнд Мормоны Номын тухай зааж, нэг номыг унш гэж өгөв. Энэ явдал зун болсон бөгөөд би их сургуулийн нэгдүгээр курсийг төгсөөд амралтаараа хоёр

сар гэртээ байсан юм. Тиймээс би тэр номыг үдээс хойш ярилцлага дууссаны дараа уншиж эхэллээ.

Тэгээд би тэр номыг нэг ч хуудас алгасалгүй, зогсолтгүй уншлаа. Ном үнэхээр гайхамшигтай байлаа. Би ном унших дуртай хүн, тиймээс олон ном уншсан. Гэвч энэ ном огт өөр байлаа. Би энэ номыг тавилгүй хэдэн цаг уншсаны дараа ээж “Хуан, гэрлээ унтраагаач! Дүү нар чинь унтаг л дээ!” гэж билээ. Тэгэхэд нь би, “За ганцхан минут, ердөө ганцхан минут уншаадахъя


л даа” гэсээр цааш нь уншсаар байв. Бүр олон цаг уншсаны дараа би өлссөнгүй, цангасангүй, нойр ч хүрсэнгүй.

Тэгээд номыг уншиж дуусахаасаа өмнө үүнд ямар нэг онцгой зүйл байгааг мэдрэв. Би Мормоны Номыг анх удаа уншихдаа мэдэрсэн гурван зүйлийн талаар гэрчлэлтэй болж билээ.

Нэг дэх зүйл бол надад өмнө нь тохиолдсон ямар ч зүйлтэй зүйрлэх аргагүй амар амгаланг уг номыг унших үеэр би мэдэрсэн явдал мөн. Энэхүү амар амгалангийн мэдрэмж надад хэдэн цагийн турш байсан юм.

Миний мэдэрсэн хоёр дахь зүйл бол уг номыг унших үеэр би баяр баясгаланг мэдэрч байсан явдал юм. Би өмнө нь найз нартайгаа хамт байхад эсвээс үнэхээр дуртай ямар нэг зүйлээ худалдаж авахад би ингэтлээ баярлаж байсангүй. Эдгээр нь аз жаргалын мэдрэмж байсангүй, харин баяр баясгалангийн мэдрэмж байлаа. Үүнийг уншиж байхдаа би уйлж эхэлсэн ба энэ ном үнэхээр гайхалтай ном гэдгийг ухаарсан.

Миний мэдэрсэн гурав дахь зүйл бол гэгээрэл байв. Энэ номыг анх уншихад *Нисфай*, *Цагаатгал* гэхчлэнгийн огт мэдэхгүй олон үг хэллэгийн улмаас ойлгоход их хэцүү байлаа. Гэвч хэдэн цаг уншсаны дараа миний оюун ухаан нээгдэж, сэтгэл зүрхэнд гэрэл асах шиг болж,



номыг цааш нь унших тусам улам сайн ойлгож эхэллээ.

Дээрх гурван туршлага бол Сүнс бидэнд ирдэг арга замуудын зарим нь юм гэдгийг би хожим нь ухаарсан. Би Сүнсийг хүлээн авсан болохоор баптисм хүртэхэд бэлэн байсан ч гэр бүлийнхээ бусад гишүүдийг гэрчлэлтэй болтол нь хүлээх хэрэгтэй байлаа. 1972 оны дөрөвдүгээр сарын 6-нд би ээж, эгч нарынхаа хамт баптисм хүртлээ. Манай аав, хоёр дүүгийн маань хамт бидний баптисм дээр байсан бөгөөд хэдэн сарын дараа тэд бас баптисм хүртэв.

Сүм болон сайн мэдээ миний амьдралд зөв цагт ирсэн юм. Би их сургуульд сурсныхаа анхны жил хүмүүний олон философи болон амьдрах арга замуудын тухай үзэл баримтлалтай танилцсан бөгөөд эдгээр нь өмнө нь миний мэддэгээс өөр байв. Хүүхэд ахуй үедээ бусад

сүмүүдээс сурч мэдсэн зүйлсийг маань шинэ үзэл баримтлал эргэлзээтэй болголоо.

Үүний учрыг олоход надад хэцүү байлаа. Бусад хүмүүсийн хувьд ердийн зүйл мэт санагддаг олон зүйл зөв биш байсныг би ухаарч эхэлсэн. Гэвч шинээр ухаарч ойлгосон зүйлсээ хамгаалахад миний мэдлэг хангалтгүй байв.

Баптисм хүртсэний дараа их сургуульдаа буцаж ороход маш өөр санагдлаа. Бусад эрхэмлэн ярих ямар нэг зүйл эдүгээ надад байлаа. “Үгүй ээ, баярлалаа. Би үүнийг хийхгүй ээ” хэмээн би эдүгээ итгэлтэйгээр хэлж чадна. Мөн яагаад ингэж хэлэх ёстойгоо би мэдэж байлаа. Сүм, Мормоны Ном хоёр миний амьдралд зөв цагт ирсэн юм. Энэ хоёр зүйл миний амьдралыг өөрчилсөн учир би үнэхээр баяртай байдаг.

Би Сүмд элсэх шийдвэр гаргасныхаа төлөө адислагдсан юм. Сүмд би хамгийн сайн найз нараа олсон. Би өмнө нь их ичимхий байсан бөгөөд ганцаараа байж, ном уншиж, судлан, ганцаараа байх дуртай байлаа. Харин Сүмийн ачаар

би жинхэнэ найз гэж юу болохыг мэдсэн. Би Сүмд нэгэн гайхалтай залуу эмэгтэйтэй танилцаж, гэрлэсэн. Надад анхаарал халамж тавьдаг санваартны удирдагчид, бусад хүмүүс Сүмд бий. Би Их Эзэний Сүмээс хэрэгтэй зүйлээ олсон.

Олон хүмүүс өөрт хэрэгтэй зүйлсээ сүмээс олж чадна. Найз нартаа “Би үүнд итгэдэг. Үүнийг би чамтай хуваалцахыг хүсч байна” гэж хэлэхээс бүү ай. Зарим үед насанд хүрэгчид юу зөв, юу буруу болох тухай ярилцдаг. Үе тэнгийн найз нар чинь бас энэ тухай ярьдаг бол чи тэднийг дага. Найз нарын чинь дуу хоолой өөрт чинь насанд хүрэгчдийнхээс илүү хүчтэй нөлөөлж болно. Хуан Юседа шиг хэн нэгэн чамайг хүлээж байгаа чи бусдад сайн үлгэр дууриал үзүүл. Хэрэв чи амаа нээж, “Хуан, би чамайг манай сүмд очихыг урьж байна. Чамайг энэ номыг уншаасай гэж би хүсч байна” гэж хэлэхгүй бол чи хэзээ ч мэдэхгүй. Хэрэв чи энэхүү энгийн зүйлийг хийвэл амьдралаа өөрчилж чадна. ■

Ахлагч Юседа Перуд бүрэн цагийн номлолд үйлчлэх үеэрээ Мормоны Номын тухай гэрчлэлээ олон удаа хуваалцжээ. Зүүн талд, дээрээс: Ахлагч Юседа (баруун талд) өөрийн заасан, хөрвөгч гэр бүлийн хамт. Зүүн доод талд: Ахлагч Юседа (ар талын эгнээнд баруун талаас) сүмийн барилгын гадна талд бусад номлогчидтой хамт.



Сургаал ба Гэрээ 87:8

Энэ жилийн Мючелийн сэдэв хаана байвал аюулгүй болохыг бидэнд зааж байна.



Ариун газруудад зогсогтун та нар

“Надад ойр байгтун, мөн би та нарт ойр байх болно; намайг хичээнгүйлэн эрэлхийлэгтүн, мөн та нар намайг олох

болно;” (С ба Г 88:63) хэмээн Их Эзэн биднийг урьдаг. Бид ингэснээр амьдралдаа Түүний Сүнснийг мэдэрч, хүч чадалтай, тууштай зөв шударга байж, “ариун газруудад зогсон . . . тэндээсээ хөдлөхгүй байх” хүсэл эрмэлзэл, зоригтой байх болно.

Ерөнхийлөгч Томас С.Монсон “Ариун газруудад байгтун” *Лиахона*, 2011 оны 11-р сар, 84.

Их Эзэний өдөр

Их Эзэний өдөр—Есүс Христийн Хоёр дахь Ирэлт

8 Иймийн тул, ариун газруудад “zogсогтун та нар, мөн Их Эзэний өдөр ирэх хүртэл бүү шилжин нүүлгэгд; учрыг болгоогтун, энэ нь ^бгэнэт ирэх болой хэмээн Их Эзэн хэлэв. Амен.

Ариун газраасаа бүү хөдөл

Ямар нэг зүйлийг хөдөлгөхгүй байх зарим арга замын тухай доор өгүүлэв:

- *Зангуу*—“Найдвар нь . . . хүмүүсийн бодгальд зангуу болдог” (Ифер 12:4).
- *Бат бөх суурь*—“Бурханы Хүү, Христ болох бидний Гэтэлгэчийн хадан дээр . . . та нар сууриа тавих ёстой” (Хиламан 5:12).
- *Бат бөх байрлал*—Та нэг хөлөөрөө Сион дээр нөгөө хөлөөрөө дэлхий дээр гишгэн зогсож чадахгүй. Учир нь “хоёр санаа өвөрлөгч бөгөөд бүх үйлдээ тогтворгүй байдаг юм” (Иаков 1:8).
- *Майхны гадсууд*—Сионы майхны гадсууд нь: “Сионы газар нутагт, мөн түүний гадаснуудад хамтдаа цуглах нь батлан хамгаалалтын тулд, мөн шуурганаас, мөн энэ нь хольцгүйгээр бүхэл дэлхий дээр юүлэгдэх үед хилэглэлээс хоргодох газар байж болохын тулд буюу.” (С ба Г 115:6).

Энэ өдөр гэнэт ирнэ

“Бид [Хоёр дахь Ирэлтийн] тэмдгүүдийг ажиглан, итгэлтэй амьдрах ёстой. . . Гэвч энэ үйл явдал болон үүнийг тойрсон бусад үйл явдууд нэгэн цагт ирээдүйд тохиох учир бид сандарч үймэлдэх ёсгүй. Бид амьдралыг зогсоож чадахгүй. Харин ч бид урьд өмнөхөөсөө илүү сайн сайхан амьдрах ёстой.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жеффри Р.Холланд, “This, the Greatest of All Dispensations,” *Лиахона*, 2007 оны 7-р сар, 19–20.

Ариун газруудад

“‘Ариун газрууд’ гэж юу вэ? Ариун газруудад мэдээж хэрэг *ариун сүм* болон бид тэнд байгуулсан гэрээнүүдээ итгэлтэй сахих нь орно. Ариун газруудад мэдээж хэрэг хүүхдүүдийг эрхэмлэн дээдэлж, эцэг эхчүүдийг хүндэлдэг *гэр бүл* орно. Ариун газруудад мэдээж санваартны удирдагчдаас өгсөн *үүргээ* түүний дотор салбар, тойрог, гадсууд дахь номлолын үүрэг болон дуудлагаа итгэлтэйгээр биелүүлэх нь орно.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс, “Preparation for the Second Coming,” *Лиахона*, 2004 оны 5-р сар, 10; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.

Редакторын тэмдэглэл: Энэ хуудас бол сонгосон судрын шүлгийн бүх талыг хамарсан тайлбар биш, зөвхөн өөрийн тань судалгааны эхлэх цэг юм.

2013 оны МЮЧЕЛИЙН СЭДЭВ



ӨНДӨР ЖИШГҮҮД БОЛОН ЗАРЧМУУДАД ҮНЭНЧ БАЙХ НЬ

Дэвид Л.Бек

Залуу Эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч

2013 оны Мючелийн сэдвийг Сургаал ба Гэрээ 87:8-аас авсан юм. Энэ шүлэгт “Иймийн тул, ариун газруудад зогсогтон та нар, мөн Их Эзэний өдөр ирэх хүртэл бүү шилжин нүүлгэгд;” гэсэн байдаг. Ирж байгаа энэ жилд залуу эрэгтэй бүр, *Би ариун газруудад байдаг уу?* гэсэн асуултыг тунгаан бодох болно гэдэгт би итгэлтэй байна.

Би дэлхий даяар зоригт залуу эрэгтэйчүүдтэй уулзахдаа мянга мянган залуу эрэгтэйчүүд үүнийг олон арга замаар хийж байгааг би харсан. Та нар нас барагсдын өмнөөс баптисм хийлгэхээр ариун сүмд орох бүрдээ хамгийн ариун газарт зогсож байна гэсэн үг. Ариун сүмд орох боломж бүрийг ашиглаж байхыг бас ариун сүмд орохоор үргэлж зохистой байхад би та нарыг урамшуулан дэмжиж байна. Та нар Бурханы өмнө хүлээсэн үүргээ өдөр бүр биелүүлснээр ариун газруудад байж, бусдыг дэмжиж байгаа нь тэр. Та нар ням гараг бүр ариун ёслолыг бэлтгэж, адислан, түгээснээр ариун газруудад байгаа гэсэн үг. Та нар сайн мэдээг хуваалцаж, бусдад үйлчилж, тэднийг хүчирхэгжүүлэх чадвартай, ийм хүсэлтэй бөгөөд зохистой үйлчлэгч болж үйлдсэнээрээ ариун газруудад зогсож байгаа гэсэн үг.

Сануулж, тайлбарлан, ухуулж, заахын хамт бүхнийг Христэд урих үүрэг Аароны санваартан та нарынх билээ (С ба Г 20:59-ийг үзнэ үү). Ерөнхийлөгч Харольд Б.Лий (1899–1973) хэлсэн нь: Хэрэв та нар хэн нэгнээс илүүгээр өндөр жишгүүд болон зарчмуудад үнэнч байхгүй юм бол түүнийг өргөн дэмжиж чадахгүй. . . . Та нар өөрийнхөө зүрх сэтгэлд гэрлийг бий болгож чадахгүй бол бусдын зүрх сэтгэлд гал асааж чадахгүй.¹

Залуу эрэгтэйчүүд ээ, энэ бол та бүхэн гэрчлэлээ бэхжүүлэхийн тулд байнга ажиллах ёстой мөн гэрчлэлээ хуваалцахад үргэлж бэлэн бай гэсэн үг юм.

Та нар бол Их Эзэний мутарт зэмсэг байх ариун үүрэг хариуцлагатай хүмүүс. Та нар залбиран, судруудыг судалж, зарлигуудыг сахихыг хичээн, Сүнсний едөөлтүүдийг анхааралтай сонсвол өндөр жишгүүд болон зарчмуудад үнэнч байж чадна. Үүний үр дүнд та нар хаана ч байлаа гэсэн тэр газар ариун газар байх болно. Тэгвэл зохих нөхцөл бүрдсэн үед бусдыг дэмжин, тэдэнд туслах хүч чадал, зориг, чадвар та нарт байх болно. Ариун газруудад байдаг хүмүүст Их Эзэний амласан хүч хийгээд хамгаалалт байх болно.

Бид Их Эзэнд хэчнээн ойр байх тусам “амьдралдаа Түүний Сүнснийг мэдэрч, хүч чадалтай, тууштай зөв шударга байж, ‘арин газруудад зогсон . . . бүү шилжин нүүлгэгд;’ байх хүсэл эрмэлзэл, зоригтой байх болно хэмээх амлалтыг бидэнд өгснийх нь төлөө би Ерөнхийлөгч Томас С.Монсонг хайрладаг” (С ба Г 87:8).

Бидний эргэн тойрон дахь нөхцөл байдал болон нийгмийн ёс суртахууны жишгүүд бидний нүдний өмнө задран доройтож байгаа үед бид Түүнд итгэдэг хүмүүст Их Эзэний өгсөн дараах үнэ цэнэтэй амлалтыг санаж болно: ‘Би чамтай хамт байгаа тул бүү ай! Өөрийнхөө талаар бүү санаа зов. Учир нь Би чиний Бурхан. Би чамайг тэнхрүүлж, үнэхээр чамд тусална’ (Исаиа 41:10).”² ■

ЭШЛЭЛ

1. Харольд Б.Лий, “Stand Ye in Holy Places,” *Ensign*, 1973 оны 7-р сар, 123.
2. Ерөнхийлөгч Томас С.Монсон “Ариун газруудад зогсогтон” *Лиакхона*, 2011 оны 11-р сар, 84.



“АРИУН ГАЗРУУ-
ДАД ЗОГСОГТУН
ТА НАР, БҮҮ ШИЛ-
ЖИН НҮҮЛГЭГД;...”
(С БА Г 87:8-ЫГ ҮЗНЭ ҮҮ).



ТАНЫ АМЬДРАЛ ДАХЬ АРИУН ГАЗРУУД

Элайн С.Далтон

Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч

Энэ жилийн Мючелийн сэдэв таныг дэлхийгээс Бурханы хаант улс руу алхан орохыг урьж байна. Арванхоёр Төлөөлөөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Бонд К.Пакер, бид дайсны нутагт амьдардаг хэмээн сургажээ.¹ “Та нар ариун газруудад зогсогтун” гэсэн урилга дайсны нутгаас эсэн мэнд гарах түлхүүр үгс мөн.

Энэ сэдэв: Ариун газар гэж юу вэ? Ариун газар хаана байдаг вэ? Бид хэрхэн ариун газруудад байж чадах вэ? Бид тогтмол очдог газруудаа хэрхэн ариун болгодог вэ? гэсэн чухал асуултуудыг тунгаан бодохыг урьж байна. Та нар эдгээр асуултын хариуг эрж олохыг хичээсэн үед хариултауд чинь та нарыг найз нөхөд рүү тань, үйл ажиллагаануудыг сонгох болон хувцаслалт, үг яриа, үйлдлүүд рүү хөтлөх болно.

Та нар гэр бүлээ бэхжүүлэхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэх ёстой. Гэр орноо Их Эзэний Сүнсээр дүүрсэн ариун газар болгохыг хичээгтүн. Та нар гэр бүлийн залбирал, гэр бүлээрээ судар судлахад чухал хувь нэмэр оруулж чадна.

Өөрийн чинь өрөө Сүнсийг урьдаг ариун байж болно. Хэрэв бошиглогч өөрийн чинь өрөөг үзэхээр орж ирвэл үүнийг ариун газар байна гэж үзэх болов уу? Чи өөрөө ингэж үздэг үү?

Бид сүмд явснаар ариун газруудад байж чадна. Сионы тойрог, гадаснууд бол “хамгаалалтын тулд, мөн шуурганаас, хоргодох газар” (С ба Г 115:6) болох ариун газрууд мөн гэдгийг судрууд заадаг билээ.

Дэлхий дээрх хамгийн ариун газар бол ариун сүм мөн. Ерөнхийлөгч Томас С.Монсон ийн хэлжээ: “Өсвөр үеийнхэн болох миний залуу найз нар аа, ариун

сүмийг үргэлж бодол санаандаа байлга. Ариун сүмийн үүдээр орж, үүний ариун бөгөөд мөнхийн адислалуудыг хүлээн авахад тань саад болох юуг ч битгий хий. Ариун сүмд аль хэдийн очсон залууст нас барагсдын өмнөөс баптисм хийлгэхээр тийшээ тогтмол очиж бай хэмээн би зарлиг болгож байна.² Ариун сүм хол байлаа ч, ариун сүмийн хүчинтэй зөвшөөрлийн бичиг эзэмшихээр үргэлж зохистой бай.

Сүнс байгаа ямар ч газар та нарын хувьд ариун газар байж чадна. Ариун газрууд нь хүн хэрхэн, хаана амьдардаг вэ гэдэгтэй илүү их холбоотой байдаг хэмээн Ерөнхийлөгч Харольд Б.Лий (1899–1973) сургажээ.³ Хэрэв чи Ариун Сүнсний байнгын нөхөрлөлд тэнцэхээр зохистой амьдардаг бол, ариун газарт байгаа нь тэр.

Ариун сүм бүрийн ханан дээр “Их Эзэнд ариуныг” гэсэн бичиг байдаг. Ариун газруудад байхыг үргэлж хичээ. Хэрэв чи Сүмийн жишгүүдээр амьдарч, өдөр бүр залбирдаг бол, судруудыг ялангуяа Мормоны Номыг уншдаг бол Ариун Сүнсний нөхөрлөлийг мэдрэх болно. Их Эзэн Өөрөө та нарт “Учир нь агуу зүйлүүд та нарыг хүлээж байгаа гэдгийг үнэнээр би та нарт хэлнэ;” (С ба Г 45:62) гэж амласан билээ. Би үүнтэй санал нэг бөгөөд үүнийг үнэн гэдгийг гэрчилж байна! ■

ЭШЛЭЛ

1. Бонд К.Пакер, “How to Survive in Enemy Territory,” *Лиакхона*, 2012 оны 10-р сар, 34–37.
2. Томас С.Монсон, “The Holy Temple—a Beacon to the World,” *Лиакхона*, 2011 оны 5-р сар, 92.
3. *Doctrine and Covenants Student Manual: Religion 324 and 325*, 2nd ed. (Сүмийн Боловсролын Системийн гарын авлага, 2001), 196-г үзнэ үү.



Адам К.Өүлсон

Сүмийн сэтгүүлүүд

АГЮНГ АГААРЫН ТЕННИСНЭЭС ЮУ СУРСАН БЭ?

*Индонезийн нэгэн өсвөр насны хөвгүүн
найдварын ачаар бэрхшээлд бууж өгөхгүй
байхад сурсан ажээ.*

Индонезийн Жакарта дахь ердийн нэгэн чийглэг халуун өдөр Агюнг өрсөлдөгчийнхөө цохих бөмбөгийг хүлээх зуур түүний духнаас хөлс дусална. Агаарын теннисний тэмцээн ойртож байсан болохоор 15 настай хөвгүүн ялах хүслээр жигүүрлэн сэтгэл догдолно.

Өрсөлдөгч нь огцом хөдөлгөөн хийснээ Агюнгийн гар хүрэхгүй газар руу бөмбөгийг цохилоо. Тэмцээний оноо их ойрхон байсан тул Агюнг хожигдохыг хүсэлгүй бадминтоны бөмбөгний хойноос ухасхийсэн боловч нэг их хол очилгүй цементэн талбай дээр халтирч унан хамраас нь цус гоожиж эхэлжээ.

Тэр ширүүн өрсөлдөөнтэй тэмцэнд дуртай ч, мэргэжлийн агаарын теннисчин болохыг мөрөөддөггүй ажээ. Агюнг Олимпын тоглолтод оролцох, номлолд үйлчлэх хоёрын аль нэгийг сонгох шаардлага байхгүй. Тэр өөрийгөө спортод төдийлөн амжилт гаргаж чадахгүйгээ мэдсэн ажээ.

Тийм байтал энэ давжаахан биетэй, сайхан инээмсэглэсэн хөвгүүн яагаад бадминтонд

ийнхүү асар их хүч чармайлт гаргадаг юм бэ?

“Би сайн тоглогч болж чадна гэдэгтээ итгэлтэй байдаг” гэж тэр хэллээ.



Итгэл найдвартай байх нэг шалтгаан

Итгэл найдвар бол бидэнд олон юмсыг хийх хөшүүрэг болдог. Бид илүү их хүч чадалтай, илүү эрүүл болоход итгэдэг учраас биеийн тамирын дасгал хийдэг шүү дээ. Бид хөгжмийн зэмсгээр сайн тоглож сурна гэдэгт итгэдэг учраас хөгжим тоглох дадлага хийдэг. Агюнг өөрийгөө сайн тоглодог болно гэдэгт найддаг учраас агаарын теннисээр хичээллэдэг ажээ.

“Хэрэв надад сайжирч мөн ялах итгэл найдвар байгаагүй бол би бэрхшээлд сөхрөн бууж өгөх нь амархан байх байсан биз ээ” гэж Агюнг хэллээ.

Итгэл найдвар бол авралын төлөвлөгөөний амин чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Аль нэг зарлигийг биелүүлээгүй тохиолдолд буруугаа уучлуулах итгэл нь биднийг наманчлал руу хөтөлдөг.

Бидний итгэл найдвар руу дайрах Сатаны довтолгоо

Бидний эсрэг Сатаны хэрэглэдэг хоёр шилдэг зэвсэг нь эргэлзээ, урам хугаралт юм. Тэрээр Цагаатгалыг болиулж, Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг нураах гээд бүтээгүй юм. Гэвч тэр, уучлагдаж болно гэсэн бидний итгэл найдварыг хулгайлах замаар бидний амьдрал дахь Цагаатгалын ариусгагч үр нөлөөг

үгүй хийхийг оролдсоор байна.

“Бэрхшээлд бууж өгөх нь биднийг Тэнгэрлэг Эцэгээс холдуулдаг учраас Сатан биднийг итгэж найдах зүйлгүй болгохыг хүсдэг” гэж Агюнг хэллээ.

Сатан бидний урам зоригийг мохооход амжилт олоо ч гэсэн, итгэл найдварыг дахин олж авах арга зам байдаг.

Итгэл найдварыг олохуй

Ирээдүйд итгэх итгэл найдвар хэрэгтэй болсон үед бид өнгөрсөн үеэ эргэн харж болно. Агюнг сургуулиасаа сурч мэдсэн нэгэн сургамжийг загвар болгон ашигладаг ажээ. “Хэрэв би шаргуу хичээллэвэл, шалгалтуудаа амжилттай өгч чадна гэдгийг туршлагаасаа харсан” гэж тэр ярилаа. “Энэ туршлагынхаа ачаар, хэрэв би шаргуу дадлага хийвэл агаарын теннист амжилт олж чадна гэдэг итгэл найдвартай болсон” гэж тэр хэллээ. “Энэ туршлага надад итгэл найдвар төрүүлсэн юм.”

Есүс Христэд итгэх найдвар бидэнд хэрэгтэй болсон үед бид үүнийг Цагаатгалын хүчний талаарх өөрийнхөө өнгөрсөн үеийн туршлага (Ром 5:4) болон бусдын туршлагаас, түүний дотор ариун ёслолын цуглаан, Ням гарагийн хичээл дээр сонссон үгс, *Лиахона*, эсвэл судруудаас (Иаков 4:4–6-г үзнэ үү) олж авч чадна.

Бид бошиглогчдын итгэл төрүүлэм үгсийг судлан, итгэл найдварын бэлгийн төлөө залбирч, өөрсдийн амьдрал дахь Аврагчийн хүч нөлөөг хүлээн зөвшөөрвөл Түүнд итгэх бидний итгэл болон Тэрбээр бидэнд ирээдүйд туслах болно гэсэн итгэл найдвар улам өсөн нэмэгдэх болно.¹



ИТГЭЛ НАЙДВАРЫН АМЛАЛТ

“Бурхан итгэлтэй байж, өнгөрсөн үед өгсөн амлалтуудаа биелүүлсэн учраас одоо болон ирээдүйд бидэнд өгөх амлалтуудаа биелүүлэх болно гэдэгт бид итгэлтэй байж болно.”

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф, “The Infinite Power of Hope,” *Лиахона*, 2008 оны 11-р сар, 23.

Хэзээ ч бүү бууж өг

Агюнг өөрийгөө хэзээ ч мэргэжлийн тамирчин болохгүй гэдгийг мэддэг ч, дасгал хийхээ үргэлжлүүлбэл сайжрах болно гэдэгтээ найддаг.

“Бэрхшээлд бууж өгөхгүй л байвал найдвар байна гэсэн үг” гэсэн үгс агуу хүчийг агуулдгийг би мэдсэн” гэж тэр хэллээ.

Есүс Христийн Цагаатгал амьдралд итгэл найдварын хязгааргүй эх ундарга болдог билээ. Бид алдаа гаргасан үедээ Цагаатгалын ачаар наманчилж чадна. Энэ нь, хэрэв наманчилж, дуулгавартай дагах зарчмыг чанд баримталбал, бид Цагаатгалын ачаар амьдралын сорилт бэрхшээлд алдаа эндэгдэл гаргахгүй байж чадна гэсэн үг юм.

Чухам иймээс Агюнг аавыг аням гараг бүрд Сүмд үргэлж урьдаг ажээ. Чухам иймээс тэр найз нар нь зөв зүйл хийхгүй байгаа үед зөв зүйлийн төлөө тууштай зогсохыг хичээдэг ажээ. Чухам иймээс тэр семинар, Мючел, Ням гарагийн цуглаанууд, номлогчийн бэлтгэлийн хичээл болон сүмийн барилгыг цэвэрлэхэд туслах зэрэгт цуглааны байр руу хол замыг туулан олон цаг дугуйгаар явдаг ажээ.

“Есүстэй адилхан байхыг хичээх нь амаргүй л дээ” гэж Агюнг хэллээ. Би заримдаа санаагаар унадаг ч, бууж өгдөггүй. Миний төлөө хийсэн Түүний золиослолын улмаас улам сайн хүн болох итгэл найдвар надад байдаг.”

Цагаатгалын улмаас итгэл найдвар байдаг бол итгэл найдварын улмаас Цагаатгал бидний амьдралыг өөрчилж чадна. ■

ЭШЛЭЛ

1. Диетер Ф.Угдорф, “The Infinite Power of Hope,” *Лиахона*, 2008 оны 11-р сар, 23.

Боловсрол

Өндөр мэдлэг Их Эзэний зорилгуудыг гүйцэлдүүлэхэд агуу нөлөө үзүүлэх боломжийг бидэнд олгодог билээ.

Иаков Нифайн хүмүүсийн сүнслэг сайн сайхан байдлын төлөө агуу хүсэл хийгээд санаа тавилтаар “байгаа мөн ирэх тэдгээр зүйлүүдийн талаар” (2 Нифай 6:4) тэдэнд заасан ажээ. Эдгээр хүмүүс түүний хүмүүс байсан бөгөөд тэр тэднийг хайрладаг байлаа. Тэр тэдэнд тэд чухам хэн болохыг хийгээд тэдэнд өгөгдсөн Их Эзэний амлалтуудын талаар заажээ. Тэрээр Аврагчийн тухай тэдэнд заахдаа: “Ай Бурханы маань ариун чанар хичнээн агуу их билээ! Учир нь *тэрээр бүх зүйлийг мэддэг*, мөн түүний мэдлэгээс гадуур нэгээхэн ч зүйл эс орших буюу” (2 Нифай 9:20; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Боловсролын үнэ цэнэ, ач холбогдлыг ойлгодог байх нь нэн чухал юм. Эцэг Абрахам олон зууны тэртээ дэлхийн нөгөө хэсэгт “эцгүүдийн адислалуудыг эрэлхийлж, “мөн зөв шударга ёсыг агуугаар дагагч байхыг хүсч, мөн агуу их мэдлэг эзэмшихийн тулд,” (Абрахам 1:2) хүсч байсан билээ.

Та бүхэн бол Бурханы хайртай, хөвгүүд охид¹ бөгөөд “бошиглогчдын хүүхдүүд; мөн та нар бол . . . [Абрахамтай] Эцэгийн хийсэн гэрээнийх болой та нар” (3 Нифай 20:25). “Та нарын ойлголтод шаардлагатай зүйлүүдээр” (С ба Г 88:78) зааварлагдсанаар

та нар Абрахамын адил “илүү агуу мэдлэгийг” эзэмших чадвартай болно.

Хүмүүний хүсвэл зохих мэдлэгт “Тэнгэр дэх мөн дэлхий дэх мөн дэлхийн доорх зүйлүүдийн тухай; байсаар ирсэн зүйлүүд, байгаа зүйлүүд, удахгүй тохиох зүйлүүд; гэрт байгаа зүйлүүд, хол байгаа зүйлүүд; дайнууд болон үндэстнүүдийн ээдрээтэй байдал, мөн уг



Ахлагч
Крейг А.Кардон
Далын



нутаг дээрх шүүлтүүд; мөн тэрчлэн улс орнуудын тухай хийгээд хаант улсуудын тухай мэдлэг буюу-” (С ба Г 88:79) орно гэдгийг Их Эзэн харуулжээ.

Яагаад? Мэдлэг эзэмших нь яагаад ийм чухал юм бэ? “Та нарыг бибээр дуудсан тэрхүү дуудлагыг, би та нарт итгэмжилсэн тэрхүү үүрэг даалгаврыг хичээнгүйлэн гүйцэтгүүлэхээр би та нарыг дахин илгээхэд та нар бүх зүйлд бэлтгэгдэж болохын тулд буюу” (С ба Г 88:80) хэмээн Их Эзэн тод томруунаар бидэнд ойлгуулсан билээ.

Улам нарийн, ээдрээ төвөгтэй болж байгаа энэ дэлхийд боловсрол амьдралын чухал шаардлага, шалгууруудын нэг болж байна. Сайн боловсролтой болох нь материалаг аж байдлын хувьд илүү сайн амьдрах боломжийг бидэнд олгохын хамт өндөр мэдлэг боловсрол нь Их Эзэний зорилгуудыг биелүүлэхэд илүү их нөлөө үзүүлэх боломжоор биднийг хангадаг. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолд: “Боловсрол бол Түүнтэй илүү адилхан болоход өөрт чинь туслах Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний чухал хэсэг мөн. Тэрээр та нарыг оюун ухаанаа боловсруулж, авъяас чадвараа хөгжүүлэн, үүрэг хариуцлагаа сайн биелүүлэх хүчтэй байж, амьдралыг дээдлэн хүндэлж байгаасай гэж хүсдэг” гэж тайлбарлажээ.²

Бошиглогч Иосеф Смит мөн үүнчлэн: “Мэдлэгт хүч чадал оршдог. Бурхан агуу мэдлэгтэй учраас бүх зүйлийг захирах хүчтэй байдаг” гэж сургасан юм.³

Албан ёсны боловсрол нь та нараас өргөн хүрээтэй сэдвүүдээр ур чадварт шамдан суралцах хэдэн жилийг шаардах бөгөөд та нар эдгээр ур чадваруудын заримыг нь огт мэдэхгүй эсвэл зарим нь тийм ч сонирхолтой биш байж болно. Гэсэн ч, та нар хичээл сурлагадаа махруу хичээнгүй бай. Учир нь энэ нь та нарын мэдлэгийг нэмэгдүүлж, бусад салбарт эрдэм мэдлэг эзэмших оюун ухааны чадварыг тань тэлэх болно. Энэ нь өргөн цар хүрээтэй тэдгээр үндсэн ур чадвар болон сэдвүүдийг танин мэдэж, тэдгээрийг сонирхох сонирхлыг тань нэмэгдүүлэх болно. Хэрэв танд ийм сонирхол бий болбол энэ нь боловсрол мэдлэгээ дээшлүүлэхэд тань тусалж, сонирхдог зүйлээ



улам гүнзгийрүүлэн судлах боломжийг танд олгох болно.

Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр зөвлөх Ерөнхийлөгч Айринг боловсрол эзэмших зорилго тавих нь ямар ач холбогдолтойг хүүдээ зөвлөхдөө: “Чи ямар нэг зүйлийн талаар бодохгүй, санаа тавихгүй байна гэдэг чинь харин ч бодож, санаж сэдэх юм их байна гэсэн үг” гэжээ.⁴ Кардон эгч бид хоёр хүүхдүүдээ “ажил руугаа яаран дуртай” явдаг тийм дуртай сонирхолтой ажил мэргэжлээ сонгон эзэмшихийг байнга зөвлөдөг билээ.

Иаков өөрийн хүмүүсийг “хүмүүний эмзэглэл, мунхаглалаас” сэрэмжлүүлсэн юм!” “Тэд аливааг сураад өөрсдийгөө ухаантай хэмээн санадаг, мөн тэд Бурханы зөвлөмжийг эс анхаардаг,” хэмээн тэрбээр тайлбарлажээ. Тэгээд тэр: “Гэвч хэрэв тэд Бурханы зөвлөмжийг анхааран сонсох аваас суралцсан байх нь сайн хэрэг” (2 Нифай 9:28–29) гэсэн эрхэм үнэнийг нэмж хэлсэн юм.

Их Эзэнийг анхааралтай сонсож, Түүнээс суралц. Тэрбээр Өөрийн зорилгуудыг хэрэгжүүлэх үйлсэд таныг адисалж, хөгжүүлэх болно. ■

ЭШЛЭЛ

1. “Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Лиакхона* 2010 оны 11-р сар, 129-ийг үзнэ үү.
2. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (товхимол, 2011), 9.
3. *Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 265.
4. Жеральд Н.Лунд, “Ахлагч Хенри Б. Айринг: Molded by ‘Defining Influences,’” *Лиакхона*, 1996 оны 4-р сар, 28-ыг үзнэ үү.



БАЙНГА ДАДЛАГА ХИЙ

Би бууж өгөхийг хүсч байлаа. Ингэж их хичээж байгаа маань үр дүнд хүрэх болов уу?

Виллис Женсен

“**Б**и төгөлдөр хуурын хичээл дахиж авмааргүй байна” гэж би ээждээ хэлэв. Би төгөлдөр хуурын хичээлийг хэдэн жил авсан бөгөөд энэ олон дасгал сургуулилтаас залхаж байлаа. Би болихыг хүсч байлаа. Тэгээд ч би тийм сайн тоглож чаддаггүй байсан. Миний сонсгол тийм сайн биш бөгөөд би сонсголын төхөөрөмж зүүдэг байсан тул өөрийгөө хөгжимчин болно гэж боддоггүй байв. Дууны аяыг дарж сурахад маш их дадлага хийх шаардлагатай.

Ээж маань намайг Сүмийн дуулалуудыг дарж суртлаа төгөлдөр хуурын хичээл авах ёстой гэж хэлсэн. Би хичнээн их гомдоллосон ч эцэг эх маань ихэд дэмжиж байсан тул би бууж өгөхөө болихоор шийдсэн.

Үүнээс олон жилийн дараа би номлогч болж Гватемал Улсын уулан дахь нэгэн цуглааны байранд би дүүргийн чуулганд сууж байлаа. Би хурлын цагаас өмнө ирээд төгөлдөр хуурын дэргэд суун тоглолоо. Тэндхийн ихэнх салбар тойргуудад тоглоход хэцүү цахилгаан даруулт хөгжим байдаг

тул жинхэнэ төгөлдөр хуур хараад би их баярласан. Миний тоглохыг сонссон хүмүүс намайг чуулган дээр тоглохыг хүссэн.

Хүүхэд байсан үе ба номлогч болсон үеийн маань хооронд ямар ялгаа гарсан бэ? Хөгжмөөр дамжуулан би Сүнсний хүч чадлыг мэдэрсэн.

Номлолд байх хугацаанд маань хөгжмийн чадвараа ашиглах олон боломж надад тохиосон. Бараг ариун ёслолын цуглаан бүрт надад төгөлдөр хуур тоглох эсвэл дуулах боломж олддог байсан. Би Гватемал Улсын итгэлтэй гишүүдийн дуулж байгааг үргэлж санан дурсах болно. Би тэдэнд тэдний мэдэхгүй дуулуудаас заадаг байсан. Би тэдэнд мөн төгөлдөр хуур дарахыг заадаг байв. Би хамтрагчтайгаа өөрсдийн зааж буй хүмүүст зориулан сүмийн дуулал дуулж өгдөг байлаа. Заримдаа бид буруу өнгөөр дуулсан ч Сүнс үргэлж хүмүүсийн зүрх сэтгэлд хүрдэг байсан.

Таны ур чадвар ямар ч байсан хамаагүй та хөгжмийн авьяасаа хөгжүүлж чадна гэдгийг би мэдэж авсан. Би хэзээ ч дэлхийд алдартай

төгөлдөр хуурч болохгүй. Гватемал Улсын гишүүдийн ихэнх нь мөн л Табернеклийн найрал дуунд орж дуулахгүй. Гэсэн хэдий ч бид Сүнсээр дамжуулан Ариун Сүнсийг мэдэрч, баясаж болно. Эцэг эх маань намайг дэмжин надад төгөлдөр хуур заалгасанд мөн би бууж өгөөгүйдээ маш их баяртай байна. ■

УР ЧАДВАР, АВЬЯАС БИЛГЭЭ ХӨГЖҮҮЛ

Түүнтэй илүү адил болоход тусалдаг Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд боловсрол чухал байр суурийг эзэлдэг. Тэрээр та нарыг оюун ухаанаа боловсруулж, авьяас чадвараа хөгжүүлж, үүрэг хариуцлага сайн биелүүлэх хүчтэй байж, амьдралыг дээдлэн хүндэлж байгаасай гэж хүсдэг. Та нарын олж авах боловсрол нь энэ амьдрал болон ирэх амьдралд чухал ач холбогдолтой.

Залуучуудын бат бөх байдлын төлөө (товхимол, 2011), 9.



АРИУН ГАЗРУУДАД ЗОГСОГТУН

“Сүнс байгаа ямар ч газар та нарын хувьд ариун газар байж чадна.”

(Элайн С.Далтон, “Таны амьдрал дахь ариун газрууд,” *Лиакхона*, 2013 оны 1-р сар, 51; мөн С ба Г 87:8-ыг үзнэ үү.)

КАЙЛИГЫН САЙН ТАЛЫГ ОЛЖ ХАРСАН МИНЬ

Каринн Стейси

Бид хоёр бие биеэ үзэж чадаггүй байв. Бид хоёр хэзээ нэгэн цагт найзууд болох болов уу?

Дөрөвдүгээр ангид байхдаа би ангийнхаа хамгийн тэргүүний сурагч байлаа. Кайлийг (нэрийг өөрчлөв) эс тооцвол манай ангийн юм бүхэн надад таалагддаг байлаа. Тэр бараг хүн бүхэнтэй, түүний дотор надтай түнжин муутай байлаа. Би түүнийг бусад хүүхдүүдийг үүдний танхимд түлхэж байхыг харсан. Намайг бүр хэд дахин түлхсэн гээч. Тэр яагаад намайг дээрэлхдэгийг ойлгодоггүй учраас би гэртээ уйлсаар ирдэг байсан.

Хэн ч түүнтэй найзалдаггүй байлаа. Хоолны үеэр тэр ганцаараа ширээн дээр суудаг бөгөөд хэн ч түүнтэй ойрхон суудаггүй байв. Намайг Кайлигийн тухай ээжид ярихад ээж маань: “Түүнд ердөө найз л хэрэгтэй байгаа юм байна даа” хэмээн хэлсэн нь миний амьдралыг өөрчилсөн юм.

Энэ үгийг сонсоод би цочирдож билээ. Намайг элдэв янзаар доромжлон дууддаг хүнд сайн хандах боломжтой гэж үү? Би хэдийгээр дурамжхан байсан ч Кайлид сайн

байж, түүнийг ойлгохыг хичээдэг болов. Кайлийг илүү сайн танин мэдсэн үедээ тэр үнэхээр сайн охин болохыг би мэдсэн юм. Удалгүй би түүний амьдрал миний төсөөлж байснаас хавьгүй муу болохыг мэдлээ. Гэр орны амьдрал нь тун хэцүү учраас тэр “гэр бүл” гэдэг үгийг яриандаа хэрэглэхээс зайлсхийдэг ажээ.

Нэг өдөр үдийн хоолны үеэр би найз нартайгаа хамт сууж байв. Кайли бусадтай эв түнжингүй байдаг учраас зарим охид ч түүнтэй мөн таарамжгүй байдаг байлаа. Тэд Кайлигээр доог тохуу хийж, түүнд сонсогдохоор чанга ярьж байлаа. Тэд “Бидэнтэй хамт хэзээ ч БҮҮ СУУ!” “Юун муухай үнэр вэ? Өө, Кайли байна ш дээ!” “Биднээс холхон байгаарай!” гэсэн үгсийг хэлж байлаа. Би тэдний үгийг чагнаад сууж байлаа.

Тэгтэл “Ямар нэг юм хий” гэсэн намуухан дуу хоолойг би зүрх сэтгэлдээ сонслоо. Намайг босоход олон хүүхдийн нүд над руу гайхан нэгэн зэрэг ширтэхийг би мэдэрлээ. “Больцгоо!” гэж би чангаар хэллээ. “Та нар хүний талаар яагаад ийм зүйлс хэлж байгаа юм бэ? Түүнтэй эелдгээр харьц!” Бүх хүүхдүүд чимээгүй болов. Би суухдаа Кайли рүү харав. Тэр эргэж харахдаа намайг талархсан харцаар харлаа.

Миний арванхоёр насны төрсөн өдөр ойртож байлаа. Би хэдэн найз нартайгаа хамт үдэшлэг хийхийг хүсч байлаа. Ээж надаас өөр хэнийг урих гэж байна? гэж асуухад

би зүрх сэтгэлдээ: “Кайлийг урь” гэсэн нөгөөх намуухан дуу хоолойг сонсов.

“Би Кайлийг уримаар байна” гэж ээждээ хэллээ.

“Нэрээн үү?”

гэхэд нь би толгой дохилоо. Төрсөн өдрийн үдэшлэгийн үеэр би найз нартайгаа түүний дотор Кайлитэй ихэд дотноссон тул хичээлийн жилийн сүүлчийн гурван сарын турш тав дахь өдөр бүрийг хамтдаа өнгөрүүлдэг болсон байлаа. Кайли тав дахь өдөр бүр ирдэг болсон бөгөөд бид хоёр дотны найзууд болсон.

Одоо би наймдугаар ангид орж өөр мужид шилжсэн ч дотны найз найрынхаа нэг Кайлитэй байнга харилцаатай байгаа. Заримдаа бусад найз нар маань Кайли бид хоёрыг яаж ийм дотны найзууд болсныг асуудаг.

“Дөрөвдүгээр ангид байхад тэр намайг дээрэлхдэг байсан болохоор бид хоёр бие биедээ дургүй байсан” гэж би хэллээ.

“Тийм байтлаа яагаад ийм дотны найзууд болсон юм бэ?”

“Би түүнээс сайн талыг нь олж харсан юм. Хүн бүхэнд ямар нэг сайн тал заавал байдаг. Түүний сайн талыг олж харсан юм.” ■





**Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын**

Ахлагч Роберт
Д.Хейлс

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд бол Есус Христийн онцгой гэрчүүд юм.

Би яаж ГЭРЧЛЭЛТЭЙ болж чадах вэ?



Гэрчлэлтэй болох нь судруудыг судалж



залбиран



сайн мэдээгээр тэвчээртэй, шаргуу амьдарч,



Сүнсийг урьж, хүлээснээр эхэлдэг.



Иосеф Смитийн амьдрал бол энэхүү үйл явцын яруу тод жишээ мөн.

Манай гэр бүлд зориулсан Бурханы Төлөвлөгөө

“Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөгөөр гэр бүлүүд үүрд хамт байж чадна” (Children’s Songbook, 188).

Марисса Виддисон

Сүмийн сэтгүүлүүд

Бодит түүхээс сэдэвлэв

Би аав, ээж хоёрыгоо аймаар их санаж, орон дээр нь сууж байтал утас дуугарав.

“Хөөе, Ливай. Юу болсныг таа даа? “Чиний эмэгтэй дүү Нора өнөөдөр мэндэллээ!” гэж аав хэллээ.

Аав баяртай байсан ч дуунд нь ямар нэг зүйлд санаа нь зовж байгаа нь мэдрэгдэв.

“Миний дүү том юм уу?” гэж би асуув.

Аав хормын төдийд дуугүй байснаа “900 граммаас бага зэрэг илүү”

гэв. Ингэж хэлэхэд аавын дуунд яах аргагүй санаа зовсон байдал илрэв. Нора Христийн Мэндэлсний Баярын үеэр төрөх ёстой байтал есдүгээр сард гарчихлаа. “Нора үнэхээр хуруун чинээхэн жижиг” гэж аав хэллээ. Ливай, түүний төлөө залбирч байгаарай. Манай гэр бүлийн хувьд юу хамгийн сайн болохыг Тэнгэрлэг Эцэг мэдэж байгаа гэдэгт бид итгэлтэй байхын төлөө залбираарай.”

Би утсаа тавьсны дараа гал тоогооны өрөөнд орж, шөл хийх гэж ээжийн бэлтгэсэн ууттай вандуйг өргөж үзлээ. Ууттай вандуйн жин нь бараг л Норагийн хүндийн жинтэй адил болохыг ууган дээрх бичиг харуулна. Өөдсийн чинээхэн бяцхан дүүгийн минь биеийн жин, хэмжээ нь ямар бол гэдгийг төсөөлөхийг хичээж би ууттай вандуйг гартаа өргөж үзлээ.

Би дэлхийн өмнөх амьдрал болон авралын төлөвлөгөөний тухай мэддэг зүйлээ санан, “Түүний сүнс дөнгөж саяхныг хүртэл Тэнгэрлэг Эцэгтэй хамт байсан ш дээ” гэж бодлоо. Нора амьдарч чадахгүй байлаа ч, бид гэр бүлээрээ лацдан холбуулсан учраас



түүнтэй дахин уулзах болно гэдгийг би мэдэж байлаа. Гэхдээ тэр бидэнтэй хамт дэлхий дээр амьдрах болно гэдэгт би бас итгэлтэй байлаа.

Аав, ээж хоёр дараагийн хэдэн сарын турш эмнэлэгт байлаа. Өвөө эмээ хоёр намайг болон дүү нарыг минь асрахын тулд манайд ирлээ. Тойргийн гишүүд манай гэр бүлийн төлөө мацаг барьж залбиран, Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар заримдаа бидэнд хоол авчирч өгдөг байв. Нора ямар байдалтай байгааг хүн бүр мэдэхийг хүснэ.

Нэг орой аав, ээж хоёр биднийг бүтдийг нь том өрөөнд цуглуулав. Аав бишопптой хамт Нораг адислахаар явах гэж байгааг бидэнд хэллээ. Аав костюмоо өмсөн, зангиагаа зүүгээд явлаа. Түүнийг явсны дараа ээж биднийг цуглуулж, залбирал хэлэх болов.

“Аавыг Норад санваарын адислал өгөхөд нь адисална уу” гэж ээж залбирав. Ээжийн дуу улам аяархан болж байлаа. Хэрэв энэ нь Таны хүсэл аваас түүнийг эрүүл болж гэртээ ирэхийг зөвшөөрнө үү.”

Биднийг залбирч байхад Ариун Сүнс өрөөг амар амгалан, хайраар дүүргэснийг би мэдэрч байлаа. Норад юу ч тохиолдлоо гэсэн энэ

нь Түүний төлөвлөгөөний хэсэг байх болно гэдгийг Тэнгэрлэг Эцэг надад хэлсэнтэй адил байлаа.

Тэр шөнө оройхон аав гэртээ ирж, эмнэлэг дээр тохиолдсон гайхамшгийн тухай бидэнд яриу. Норагийн өрөө ихэнхдээ чимээ шуугиантай байдаг байж. Тэнд гэрэл анивчин, дохио өгдөг олон машин, аппарат, тоног төхөөрөмж, өөдсийн чинээхэн нялх хүүхдүүдэд туслахын тулд яаруу сандруу орж, гарах олон эмч, сувлагч гээд үргэлж чимээ шуугиантай байдаг байжээ. Гэвч аав, бишоп хоёрыг тэнд очиход бүх зүйл өөр болсон гэнэ. Бүх

машинууд нам гүм болжээ. Сувлагчид нялх хүүхдүүдийн дэргэд сууж, ном сонин уншин тэднийг харж байлаа. Аав, бишоп хоёрыг Норад адислал өгөх үеэр ямар ч чимээ шуугиан саад болоогүй ажээ.

Нора дэлхий дээр өсөх үү эсвэл Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдрахаар удахгүй буцах уу гэдгийг би мэдэхгүй. Гэвч Тэнгэрлэг Эцэг бидний залбирлыг сонсож, хариулдгийг би мэднэ. Мөн манай гэр бүлийн гишүүн *бүрд* зориулсан төлөвлөгөө Түүнд бий гэдгийг санах үедээ би амар амгаланг мэдэрдэг. ■



Сүмийн түүхэн дэх онцгой ач холбогдолтой нэг газрыг судалцгаая!

ИОСЕФ СМИТИЙН АМЬДАРЧ БАЙСАН

2 БАЙШИН

Жан Пинбороу Сүмийн сэтгүүлүүд

Нью-Йоркийн Палмира бол Есүс Христ Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм 193 жилийн өмнө **сэргээгдсэн** газар юм. Лук, Рахел, Жюлия С. гурав Бошиглогч Иосеф Смитийн амьдарч байсан газрын тухай болон дэлхий дээр Сүмийг сэргээхэд тэрээр хэрхэн тусалсан тухай илүү их зүйлийг мэдэхийн тулд энэхүү онцгой газарт очиж үзсэн ажээ.

ДҮНЗЭН БАЙШИН

Энэ дүнзэн байшинг Иосефыг бага байхад барьсан бөгөөд 12-19 настай байх үедээ тэр энд амьдарч байжээ.

1. *Иосеф найман ах, эгч дүүстэй байжээ. Энэ жижигхэн байшинд 11 хүмүүс амьдарч байсан гэнэ!*

2. *Эднийхэн Библиэс уншихаар хоолныхоо ширээний ард байнга цугладаг байсан гэнэ. Иосеф 14-тэй байхдаа, Иаков 1:5-аас: “Та нарын хэн нэгэнд нь мэргэн ухаан дутвал Бурханаас гуйг” гэж уншжээ. Бурханаас асуух чухал асуулт түүнд байлаа.*



3.

1820 оны хаврын эхэн сарын нэг өдөр Иосеф дүнзэн байшингийнхаа ойролцоох ойн цоорхой руу очиж, аль сүмд элсэх тухайгаа асуун залбирчээ. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр түүн дээр хүрч ирэн тэр үед байсан сүмүүдийн алинд нь ч элсэхгүй байхыг түүнд хэлсэн ажээ. Дэлхий дээр Их Эзэний Сүмийг дахин бий болгоход Иосеф туслах болно гэдгийг Есүс түүнд хэлжээ.



4.

Тэдний зургаан хөвгүүн бүгдээрээ дээд давхрын өрөөнд унтдаг байв. Иосефыг 17-той байхад тэнгэр элч Моронай түүн дээр гурван удаа ирж, алтан ялтсууд болон тэдгээр ялтсуудаас тэр Мормоны Номыг орчуулж хэвлүүлэх болно гэдгийг түүнд хэлэв. Иосеф дөрвөн жилийн дараа ялтсуудыг хүлээн авчээ.



БАНЗАН БАЙШИН

Иосефыг 19-тэй байхад тэднийх шинэ байшинд оржээ. Тэр Кумора гүвээнээс алтан ялтсуудыг авах үедээ энэ байшинд амьдарч байв.

5. Зарим хүмүүс алтан ялтсуудыг хулгайлахаар завдаж байв. Иосеф ялтсуудыг пийшингийнхээ өмнө тоосгонууд доор нуудаг байв.



6.

Иосефын эмэгтэй дүү Софрония, Катерин хоёр унтлагын энэ жижигхэн өрөөнд унтдаг байв. Иосеф нэг шөнө ялтсуудыг даавуунд ороож, хоёр охины орны хооронд нуусан ажээ.



Есүс Христ ба Анхны Үзэгдэл

Иосеф Смит Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг харсан Анхны Үзэгдэл бол Есүс Христийн Сүм дэлхийд эргэж ирэхэд үндэс суурийг тавьсан юм.

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр бол тусдаа хоёр хүн гэдгийг Иосеф Смит Анхны Үзэгдлээс мэдсэн ажээ.

Тэнгэрлэг Эцэг Өөрийн Хүү Есүс Христийг танилцуулсан тухай судруудад гурван удаа тэмдэглэсний нэг нь энэ юм (Иосеф Смит–Түүх 1:17-г үзнэ үү). Бусад тохиолдлууд нь Аврагч нифайчууд дээр айлчлан очсон болон Тэрбээр баптисм хүртэх үед болсон ажээ (3 Нифай 11:7; Матай 3:17-г үзнэ үү).

Бидний хуудас



11 настай Каролина Есус Христ Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд өссөн бөгөөд Венесуэлийн Каракасын Ариун сүмд явахыг үргэлж хүсдэг байжээ. 2012 оны 3-р сард тэрээр анх удаа ариун сүмд оржээ. Ариун сүмд орсондоо тэр маш их баяртай байжээ.



Ээж маань найзтайгаа ариун сүмийн ёслолд оролцох зуур би аав болон ах Раянтайгаа ариун сүм дээр цагийг сайхан өнгөрөөсөн. Би ариун сүмийн хүлээлгийн өрөөнд байхдаа маш их хүндлэл бишрэлтэй байсан. Тэнгэрлэг Эцэгийнхээ гэрт очиж, Сүнсээр дамжуулан Түүний хайр энэрэл, нинжин сэтгэлийг мэдрэхдээ сэтгэл маш их догдолсон. Би Их Эзэний өргөөнд дуртай.

Хорхе М., нас 6, Коста Рика



Энэ бол Парагвайн Асунсионы Ариун сүмийн зураг. Бид удалгүй мөнхийн гэр бүл болон холбуулах гэж байгаадаа их баяртай байна. Надад сайхан гэр бүл өгсөнд би Тэнгэрлэг Эцэгтээ талархаж байна.

Анжело Н., нас 5, Парагвай



Манай гэр бүл бол маш сайхан гэр бүл юм. Сүм манайхаас зургаан цаг явж хүрэх газарт байдаг ч бид тэнд хүрч очиж чадна. Манай аав ням гараг бүр ариун



ёслолыг адисалдаг бол ээж Хүүхдийн Хэсэгт заадаг. Бид Бразилын Ресифе Ариун сүмд жилд нэг удаа явж байна. Би насанд хүрэхээрээ номлолд явна. Би судруудыг өдөр бүр судалж, өдөр бүр залбирдаг. Би сайн хөвгүүн байснаараа Тэнгэрлэг Эцэгээ баярлуулахыг хичээдэг. Би сайн мэдээнд маш их дуртай.

Кевин Л., нас 8, Бразил



Миний бяцхан дүү Омега бид хоёр ариун сүмийг харах дуртай. Манай тойргийнхон Мексикийн Монтерри Ариун сүм рүү явахаар шөнө дунд хөдөлж,

зургаан цаг явж билээ. Ариун сүм бол гэр бүлүүд мөнхөд холбуулж чадах газар гэдгийг би мэднэ. Бид удахгүй Такстла Гвитиррез рүү шилжинэ. Тэнд ариун сүмтэй учраас бид ариун сүмд байнга орох боломжтой болно. Бидэнд ариун сүм байдагт би баярладаг.

Хелем Н., нас 4, Мексик



Би Гватемалын Квиетзалтенанго Ариун сүмд орсон даруйдаа л амар амгаланг мэдэрсэн. Онцгойлон адислалтын үед би бүр ч их баяртай байсан. Онцгойлон адислалтын үеэр хэлсэн үгс миний зүрх сэтгэлийн гүнд нэвтрэн орж билээ.

Хуан Г., нас 11, Гватемал



Солин С., нас 6, Бразил



УНШИХАД

Мерилли Бурен

Бодит түүхээс сэдэвлэв

*“Бурхан бидэнд айдсын сүнсийг
бус, харин хүч, хайр ба биеэ
захирахын сүнсийг өгсөн”
(2 Тимот 1: 7).*

Хүүхдийн Хэсгийн бусад хүүхдүүд судруудаас ээлжээр уншиж байх үед Мэри сандлаа нааш цааш хөдөлгөн, тэдний уншихыг сонсож байлаа. Түүний унших ээлж битгий ирээсэй гэж тэр хүсч байлаа.

Мэригийн унших чадвар маш муу байв. Номын хуудсан дээрх үсгүүдийг харахад тэдгээр нь хөдөөд байрлалаа өөрчлөөд байгаа юм шиг санагддаг ажээ.

Тэр үгсийг удаан уншдаг бөгөөд заримдаа үгсийн дэс дараа нь алдагддаг байжээ. Заримдаа огт байхгүй үгийг уншдаг байв.

БЭЛЭН



Мэригийн ээлж дөхөх тусам тэр бүр их айна. Тэгсээр ээлж нь болоход Мэри бүр босч чадсангүй.

“Би угаалгын өрөө рүү очих хэрэгтэй байна” гэж гэнэт хэлээд сандлаасаа үсрэн босохдоо судраа шалан дээр унагалаа. Мэри үүдний өрөөгөөр дамжин угаалгын өрөө рүү гүйв. Үүдний өрөө хүнгүй байсанд тэр баяртай байлаа. Тэр буланд зогсоод уйлж байлаа.

Хэдэн минутын дараа угаалгын өрөөнөөс Смит эгч түүнийг нэрээр нь дуудахыг сонслоо. “Мэри, юу болоо вэ?”

Мэри юу гэж хариулахаа мэдсэнгүй. Тэр маш их ичсэн ажээ. Өөр нэг ч хүүхдэд ийм зовлон байсангүй. “Би уншиж чадахгүй ээ!” гэж тэр хашгираад толгойгоо зөрүүлсэн хоёр гарынхаа ард шургуулав.

“Уншиж чадахгүй гэв үү?” гэж Смит эгч асуугаад гайхан дуугүй болов. “Чамайг Хүүхдийн Хэсэгт үг хэлж байхыг би харсан. Чамайг уншиж чаддагийг би мэднэ шүү дээ.”

Мэри толгой дохив. “Би үгээ цээжилдэг. Би олон дахин сургуулисан. Гэвч хүмүүсийн өмнө унших дадлага хийгээгүй. Би чанга уншиж чаддаггүй. Чанга уншихаараа олон алдаа гаргадаг. Бусад хүүхдүүд намайг шоолохыг би хүсэхгүй байна.”

“Өө, Мэри, намайг уучлаарай.

Уншихад бэлэн болтол чинь би чамайг чанга уншуулахаар дуудахгүй” гэж Смит эгч хэллээ. “Бас манай ангиас хэний ч чамайг шоолохгүй гэдэгт би итгэлтэй байна. Тэд чинь чиний найзууд шүү дээ.”

“Сургууль дээр хүүхдүүд намайг шоолдог” гэж Мэри шивнэлээ.

Смит эгч Мэригийн нүлимсыг арчаад “Ангидаа ор доо. ангийнхан чинь чамайг шоолохгүй. Чи хараарай” гэв.

Тэр хоёр ангид хамт буцаж орлоо. Мэригийн хажууд суудаг найз Бетси нь Мэригийн судрын үрчийсэн хуудсуудыг тэнийлгэн толигор болгосон байв. Мэрийг суухад Бетси судрыг нь түүнд өглөө.

“Одоо уншихыг хүсч байгаа хүн байна уу?” гэж Смит эгч асуув.

“Одоо Мэригийн ээлж ш дээ” гэж ангийн нэг хөвгүүн хэлэв.

Мэри эргэлзсэн ч ангийхнаа тойруулж хараад тэдний нөхөрсөг инээмсэглэлийг олж харав. Смит эгч мөн толгой дохиж, инээмсэглэв. Мэри бага зэрэг сандарсан ч хэвийн байдалтай болж уншиж эхлэв.

Тэр удаан уншиж, ганц нэг алдаа гаргасан ч түүнийг түгдэрсэн үед Бетси зөв үгийг Мэригийн

чихэнд түргэн шивнэн хэлж байлаа. Мэри ангийнхаа бусад хүүхдүүд шиг сайн уншаагүй ч, хэн ч түүнийг шоолсонгүй. Дараа нь өөр хүүхдийн унших ээлж болж хичээл цааш үргэлжилжээ.

Хичээлийн дараа хүүхдүүдийг Хүүхдийн Хэсгийн өрөөнд орох үед Смит эгч Мэригийн чихэнд түүгээр бахархаж байна хэмээн шивнэн хэлжээ. Уншихад тохиолддог зовлонгоо цаашид нуух хэрэггүй болсондоо Мэри баяртай байлаа. “Дадлага л хийх хэрэгтэй юм байна” гэж тэр бодлоо. Ямар ч үед дэмжин туслах сайн найз нар түүнд сүмд байгааг мэдээд тэр инээмсэглэв. ■

Хүүхдийн Хэсгийн энэ сарын сэдвийн тухай илүү ихийг мэдэхийн тулд та нар энэ хичээл болон үйл ажиллагааг ашиглаж болно.

Тэнгэрлэг Эцэг надад хайртай, надад зориулсан ТӨЛӨВЛӨГӨӨ Түүнд бий

Исгэсэн зуурмагийг жигнүүрийн таваг дээр халбагаар хийхэд Натаниел эмээдээ туслах үеэр жигнэмгийн сайхан үнэр өрөөгөөр дүүрэн үнэртэж байлаа. Эмээ нь түүнийг хараад инээмсэглэв. “Хэн чамд хайртай билээ?” гэж эмээ нь асуув.

Эмээ нь түүний дуртай жигнэмгийг дандаа хийдгийг бас ач хүү

нь зураг зурах дуртай болохоор түүнд зориулж цаас үргэлж бэлэн байлгадаг тухай бодоод “Та шүү дээ” гэж тэр хариуллаа.

“Тийм ээ. Ээж, аав хоёроос чинь гадна би чамайг хамгийн сайн мэднэ шүү дээ. Гэвч чамайг надаас бүр өмнө нь сайн мэддэг нэг хүн байдаг” гэж эмээ нь ярилаа.

“Өөр хэн байдаг билээ?” гэж Натаниел асуув.

“Чамайг дэлхийд ирэхээс өмнө чамд хайртай байсан нэг хүн бий” гэж эмээ нь хэллээ.

“Аа, та Тэнгэрлэг Эцэгийг хэлж байна уу?”

“Тийм ээ,” гэж эмээ нь хэлээд түүнийг чанга тэврэхэд

Натаниел инээмсэглэв. Түүнийг бусад хүмүүс хайрладгийг мэдсэн нь түүнд маш сайхан байлаа.

Энэ жил хуваалцах цагаараа та нар бол Бурханы хүүхэд гэдэг гайхамшигтай үнэний тухай улам их зүйлийг мэдэх болно. Тэнгэрлэг Эцэг чамайг мэддэг бас чамд хайртай. Нэгэн цагт Түүнд эргэн очиж, Түүнтэй хамт амьдрахад чамд туслах төлөвлөгөө Түүнд бий. ■









Дуу ба судар

- “Би Бурханы хүүхэд”
(Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, х.38)
- Ром 8:16

Цасан ширхэгт дүрс


1. 20 x 20 см-ийн хэмжээтэй цаасыг дундуур нь нугал. Дараа нь хоёр удаа мөн дундуур нь нугал.
2. Загварыг ашиглан цасан ширхгээр хөвгүүн буюу охины дүрсийг хайчил. Шар хэсгийг хайчилж хая.
3. Цасан ширхэгт дүрсүүдийг буд. Өөрийнхөө талаар харуулахын тулд

4. Цасан ширхгийн голд "Тэнгэрлэг Эцэг надад хайртай" гэж бич. Энэ нь Тэнгэрлэг Эцэг өөрийн чинь тухай юм бүхнийг мэддэг бөгөөд Тэр өөрт чинь маш их хайртай гэдгийг өөрт чинь сануулахын тулд юм.



Гэр бүлээрээ ярилцах санаанууд

- Цасан ширхгүүд өөр өөр хэлбэр, хэмжээтэй байдаг шиг хүүхэд бүр өөр өөр зан төлөвтэй байдаг. Цасан ширхгүүд хийсний дараа гэр бүлийн гишүүн бүрд цасан ширхгийг тараахдаа тухайн хүний онцлог зан чанарын тухай ярьж, түүнд хайраа илэрхийлж болно. Тэгээд Тэнгэрлэг Эцэг түүнийг мэддэг, түүнд хайртай гэдгийг хүн бүрд хэл.
- Чи Бурханы хүүхэд гэдэг үзэл баримтлалын тухай ярилцахдаа гэр бүлийн гишүүн бүрийг толь руу харуулж болно. Тэнгэрлэг Эцэг тань чамд маш их хайртай. Чи дэлхийд ирэхээсээ өмнө тэнгэрт Түүнтэй хамт амьдарч байсан юм. Тийм учраас бид Түүнийг Тэнгэрлэг Эцэг гэж дууддаг. Тэр чамайг аз жаргалтай байж, нэгэн цагт Түүнд эргэж ирэхийг хүсдэг. Тэнгэрлэг Эцэг өөрт чинь хайртайг чи яаж мэддэг вэ?



Ариун сүмийн тухай Эвелиний гэрчлэл

Майк Барбоса, Марисса Виддисон нар

Бодит түүхээс сэдэвлэв




Эвелин Хүүхдийн Хэсэгт ирэх дуртай байлаа. Залбирал хэлэх болоход тэр үргэлж гараа өргөнө. Тэр бас багшдаа туслах дуртай байлаа.



Харин өнөөдөр Эвелин анх удаа үг хэлэх гэж байлаа. Түүнийг ангийн өмнө гарч очтол гэдэс нь эвгүйрхэх шиг болов. Дараа нь зүрх нь түргэн цохилж эхлэв. Түг, түг, түг. Түг, түг, түг.



Эвелин ангийн өмнө гараад “Сайн байцгаана уу? Миний нэр Эвелин. Манайхан саяхан бүгдээрээ ариун сүм явсан. Тиймээс бид үүрд хамтдаа байж чадна” гэв.



Эвелин өөрийнхөө өмссөн цагаан хувцасны тухай Хүүхдийн Хэсгийн хүүхдүүдэд ярилаа. Ариун сүм ч бас цагаан байлаа. Тэр аав, ээж хоёр, эгчтэйгээ үүрд хамт байхаар лацдан холбуулсан тухайгаа тэдэнд ярив.



“Тэнгэрлэг Эцэг надад хайртайг би мэднэ” гэж Эвелин хэллээ. “Тэрийнхэнтэйгээ үүрд байхын тулд ариун сүм явах боломжийг Тэнгэрлэг Эцэг бидэнд олгодог” гэж Эвелин яриад суудалдаа буцаж суув. Тэр баяртай байлаа. Дулаахан гэрэл бүх биеэр нь гүйх шиг түүнд санагджээ. Тэр ариун сүм явсандаа баяртай байлаа. ■

Ариун сүмийн тухай гэрчлэл

Эвелин ариун сүмд гэрийнхэнтэйгээ лацдан холбуулсан тухайгаа ярьжээ. Эвелин Хүүхдийн Хэсэгт үг хэлэхдээ ярьсан зарим зүйлийг түүний өрөөнөөс олно уу. Бас өөр нуусан зүйлсийг та нар олж чадах уу?



СҮМИЙН МЭДЭЭ

Сүмийн мэдээ болон үйл ажиллагаануудын тухай news.lds.org-аас үзнэ үү.

Хүчирхэг суралцагчид болон багш нар болоход нь залуучуудад хэрхэн туслах вэ?

Майкл Барбер

Сургалтын материал боловсруулагч, Санваарын хэлтэс

Залуучуудын сургалтын шинэ материал Ирээд, Намайг дага: Залуучуудад зориулсан суралцах удирдамж) нь сайн мэдээнд хөрвөхөд нь залуучуудад туслах үр ашигтай дөрвөн арга замыг эцэг эхчүүд, багш нар, удирдагчдад санал болгож байгаа болно.

Есүс Христийн бага насны тухай судрын түүхээс 12 настай Аврагч “сүмд багш нарын дунд суугаад тэднийг сонсож, мөн тэднээс асууж байсныг” бид мэддэг билээ.

“Түүний ухаан болон хариултууд нь түүнийг сонссон бүхний гайхлыг төрүүлж байв” (Иосеф Смитийн Орчуулга, Лук 2:46–47 [Лук 2:46, зүүлт тайлбар ө]).

Аврагч бага наснаасаа эхлэн сайн мэдээнээс суралцах болон заахад идэвхтэй оролцсон юм. Аврагч сүмд Өөрөөс нь илүү эрдэм боловсролтой, илүү туршлагажсан хүмүүст сайн мэдээний зарчмуудыг зааж байжээ. Гэвч Тэрбээр сайн мэдээнээс суралцаж, заах нь “Эцэгийнх нь ажлын” (Лук 2:49) хэсэг бөгөөд дэлхий дээр Түүний гүйцэтгэх гол үүрэг гэдгийг ойлгодог байсан юм.


Есүс Христ бүр бага байхдаа сайн мэдээнээс гарамгай суралцагч, гарамгай багш байсан нь эргэлзээгүй ч, сургаалыг ойлгох болон заах чадвар нь улам өсч байжээ. Тэрбээр “бүрэн байдлыг хүлээн авах хүртлээ ач ивээлээс

ач ивээлд үргэлжлүүлж байсныг” (С ба Г 93:13) судрууд бидэнд өгүүлдэг. Өнөөдөр залуучууд зөв зүйлийг мэдэхийн төлөө өөрсдийн амьдралаа зориулснаараа Аврагч болон Түүний сайн мэдээн

хэмээн Тэргүүн Зөвлөл тэмдэглэжээ.¹ Бид Аврагчийн үйлчлэлийг судалж, түүнийг дуурайснаар залуучуудыгаа амьдрах ухаанд суралцах, эрдэм мэдлэг эзэмших болон Есүс Христийн сайн мэдээг



ХРИСТ ЭММАНУЭЛИЙН ЗАМ ДЭЭР, УОЛТЕР РЕЙН © ИРИ



Сүнслэг байдлын бэлтгэл буюу суралцах, залбирал, мацаг барилт нь Сүнсийн нөлөөг мэдрэхэд багш, суралцагч хоёуланд нь тусалдаг.

дээнд жинхэнэ ёсоор хөрвөж, мэргэн ухааны хувьд “шат шатаар, дүрэм дүрмээр” (2 Нифай 28:30) өсөн хөгжиж чадна.

Залуучуудад зориулсан шинэ сургалтын материалын удирдамжинд, “Та бүхэн залуучуудыг сайн мэдээнд хөрвөхөд нь туслахын тулд Их Эзэнээр дуудагдсан юм”

заахад нь үр ашигтайгаар дэмжиж чадна. Бид Аврагчийн нэгэн адил өөрийгөө сүнслэг байдлын хувьд бэлтгэж, залуучуудын хэрэгцээнд хариулт өгч, үнэнийг нээн илрүүлэхэд тэднийг урамшуулан дэмжиж, итгэлийнхээ дагуу үйлдсэнээр хөрвөхөд нь тэдэнд тусалж чадна.

Сүнслэг байдлын хувьд бэлтгэ

Аврагч мөнх бус амьдрал дахь үйлчлэлээ эхлэхээс өмнө шаргуу суралцах, залбирах, мацаг барих замаар Өөрийгөө сүнслэг байдлын хувьд бэлтгэсэн юм. Тэр “Бурхантай хамт байхаар цөл рүү Сүнсээр хөтлөгдөж,” “дөчин өдөр, дөчин шөнө мацаг барьсан” билээ (Иосеф Смитийн Орчуулга, Матай 4:1–2 [Матай 4:1, зүүлт тайлбар б]). Аврагч мацаг барилтынхаа төгсгөлд Сатаны олон уруу таталттай тулгарсан юм. Өмнө нь судруудыг судалсан нь уруу таталт бүрийг судрын шүлгүүдээр хариулахад Есүст тусалсан юм (Матай 4:3–10-ыг үзнэ үү). Сүнслэг байдлын хувьд бэлтгэлтэй байсан нь бүх амьдралдаа тохиолдсон уруу таталтуудыг амжилттай даван туулах боломжийг төдийгүй бүх үйлчлэлийнхээ туршид сайн мэдээг өндөр үр өгөөжтэйгөөр заах боломжийг Түүнд олгосон юм.

Залуучуудад заах нь сургалтын материалыг заахаасаа өмнө яаруу гүйлгэн уншихаас илүү их бэлтгэлийг шаарддаг. Их Эзэн ийн зарлиг болгосон юм, “Миний үгийг тунхаглахыг бүү эрэлхийл, харин эхлээд миний үгийг олж авахыг эрэлхийл” (С ба Г 11:21). Бид үнэн сургаалыг мэдэхийн тулд судруудыг болон амьд бошиглогчдын үгсийг залбирч судалснаар сүнслэг байдлын хувьд бэлтгэгдэж чадна. Биднийг ийм байдалаар бэлтгэхэд сургаалын үнэнийг Ариун Сүнс баталж, бидний хуваалцдаг сургаалын амьд мөн чанарыг ойлгоход бидэнд өдөөлт өгөх болно.

Перугийн Лима Сурко гадасны Эстефани Мелеро хувиараа илчлэлт хүлээн авахын ач холбогдлыг залуу эмэгтэйчүүдэд заах үедээ тэрээр,

14 настайдаа гэрчлэлтэй болохыг эрэлхийлсэн өөрийн хувийн туршлагаа хуваалцахад сүнслэгээр өдөөгдсөн ажээ. Сайн мэдээ үнэн үү гэдгийг мэдэхийн тулд тэрээр чин сэтгэлийн оргилуун хүсэлтэйгээр залбирахад нэгэн дуу хоолой түүний зүрх сэтгэлд: “Энэ нь үнэн гэдгийг чи аль хэдийнээс мэднэ шүү дээ, Эстефани” хэмээн шивнэснийг тэр хэзээ ч мартдаггүй ажээ.

Бид заадаг сургаалаа судалж, түүгээр амьдарснаар бид зүгээр нэг

Хэрэгцээн дээр анхаарал төвлөрүүл

Аврагч баян залуу захирагчтай ярилцсан яриандаа зааж байгаа хүмүүсийнхээ хэрэгцээг ойлгодог байснаа харуулсан юм. Захирагч залуу: “Мөнх амийг өвлөхийн тулд би юу хийх ёстой вэ?” гэж асуусан юм. Аврагч зарлигуудыг сахихын ач холбогдлыг заасны дараа, залуу захирагч, “Би энэ бүгдийг [зарлигуудыг] хар багаасаа л сахисан” гэж хариулжээ. Есүс залуу захирагчийн



Залуучууд сайн мэдээгээр амьдардаг туршлагаа хуваалцсанаар бие биеэ хүчирхэгжүүлдэг.

багш нар биш харин үнэнийг гэрчлэгчид болно.

Тунгаан бодох асуултууд:
Аврагч заахын тулд Өөрийгөө хэрхэн бэлтгэснийг өөр ямар судрууд харуулдаг вэ? Заахын тулд өөрийгөө бэлтгэх таны хүч чармайлт заасан зүйлийн чинь үр өгөөжид хэрхэн нөлөөлдөг вэ?

зүрх сэтгэлд “нэг л зүйл” дутагдаж байгааг мэдээд сайхь залууд эзэмшиж байгаа бүхнээ худалдаж, ядууст тарааж өг. Тэгээд ирж, ирээд, Намайг дага гэжээ. (Лук 18:18–23-ыг үзнэ үү.) Бид илчлэлтийн төлөө залбирч, залуучуудын хүсэл сонирхол, итгэл найдварыг мэдсэнээр Аврагчийн адилаар

тэдэнд хэрхэн заах болон сайн мэдээгээр амьдрах үр өгөөжтэй арга замыг тэдэнд хэрхэн таниулахыг мэдэх болно.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Боид К.Пакер, манай “залуу хүмүүс дайсны нутаг дээр өсөн торниж байна” гэж хэлсэн билээ.² Эцэг эхчүүд, багш нар бид залуучуудад тулгарч байгаа сорилт бэрхшээлүүдийг ойлгодог байх ёстой. Колумбын Колорадо Гадасны залуучуудын Ням гарагийн хичээлийн багш Кевин Таутай, “Залуучуудад тулгарч байгаа сорилт

бэрхшээлүүдийг гарын авлагаас заах боломжгүй. Энэ бол багш нар бид залуучуудыг өдөр бүр Сатантай тэмцэх тэмцэлд бэлтгэх чадвартай байхын тулд хувийн илчлэлт хүлээн авах ёстой гэсэн үг юм. Багш та зөвхөн ням гарагт гарын авлага авчирч, хичээл зааснаар үүргээ гүйцэтгэлээ гэж бодох ёсгүй” хэмээн хэлжээ.

Сайн мэдээнээс суралцаж, түүгээр амьдрахад залуучуудад туслах нь эцэг эх, удирдагчид, зөвлөгчид болон багш нарын хамтын нэгдмэл хүч чармайлтыг

Сайн мэдээний үнэнүүдийг нээж илрүүлэхэд хүүхдүүдээ туслахад эцэг эхчүүд үндсэн үүргийг хүлээх бөгөөд залуу эрэгтэй, залуу эмэгтэй бүр илүү бүрэн хөрвөгдөхөд өөрсдөө үүрэг хариуцлага хүлээдэг. Залуучуудын удирдагчид, багш нар эдгээр хүч чармайлтуудыг дэмждэг билээ.



шаардана. Бид Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийлснээр залуучуудыг уруу татаал болон тэдэнд тулгардаг сорилт бэрхшээлүүдэд бэлтгэх сургаалыг үр ашигтайгаар зааж чадна.

Тунгаан бодох асуултууд:
Өнөөдрийн дэлхий таныг залуу байх үеийнхээс ямар ялгаатай байна вэ? Залуучуудад ямар сорилт бэрхшээл тулгарч байна гэж та үздэг вэ? Тэднийг сайн мэдээний сургаалуудыг ойлгосон үед нь тулгарч байгаа сорилт бэрхшээлүүдийг хэрхэн даван туулж чадна гэж та боддог вэ?

Сайн мэдээний үнэнүүдийг нээж илрүүлэхэд залуучуудыг урь

Аврагч Өөрийн шавь нарт үнэнийг нээж илрүүлэн, хувийн гэрчлэлтэй болоход нь тэднийг урамшуулан дэмжих арга барилуудыг заадаг байжээ. Тэр нифайчуудад заахдаа ингэж хэлсэн юм:

“Та нар сул дорой, иймээс энэ үед та нарт ярихаар Эцэгээр надад зарлиг болгогдсон бүх үгсийг минь та нар ойлгож чадахгүйг би ухамсарлаж байна.

“Тиймийн тул, та нар гэр гэртээ харьцгаа, мөн миний хэлсэн зүйлсийг эргэцүүлж, мөн, та нар ойлгож, мөн би та нарт дахин ирэх маргаашийн төлөө оюун санаагаа бэлтгэж болохын тулд миний нэрээр Эцэгээс асуу” (3 Нифай 17:2–3).

Христэй адилаар заах нь мэдээллийг зүгээр хуваалцахаас илүү чухал зүйл. Энэ нь сургаалыг өөрсдөө ойлгоход залуучуудыг удирдах явдал мөн. Бид сайн мэдээний тухай тэдэнд лекц уншихаар уруу татагдаж мэдэх ч хэрэв асуултуудын хариултыг өөрсдөө олж, хувийн гэрчлэлтэй болоход нь туслаан, өөр асуулуудтай тулгарсан үед хариултыг хэрхэн олохыг тэдэнд зааж сургавал бид илүү үр өгөөжтэй зааж чадна. *Ирээд,*

Намайг дага: Залуучуудад зориулсан суралцах удирдамж-д онцлон тэмдэглэснээр бид бас тэднийг сайн мэдээгээр амьдарч байгаа туршлагаасаа хуваалцаж, үнэн гэдгийг нь мэддэг зүйлсийнхээ талаар үе тэнгийнхэндээ гэрчлэхэд нь урьж болно.

Бүсийн Далын Ахлагч бөгөөд Айдахо дахь БЯИС-ийн ерөнхийлөгч Ким Б.Кларк, диконы нэг чуулгын зөвлөгч диконуудтай хамт хийсэн залбирлын тухай өөртэй нь ярилцсан түүхийг саяхан ярьжээ. Санаандгүй байтал, диконы чуулгын ерөнхийлөгч гараа өргөж, “Би чуулгаас нэг асуулт асууя. Та нараас хэчнээн хүн энэ долоо хоногт өглөө, орой бүр залбирах хүсэлтэй байна вэ?” гэж асуув. Энэ зорилтыг биелүүлж чадах эсэхдээ итгэлтэй биш байсан нэг залуу эрэгтэйгээс бусад чуулгын бүх гишүүд гараа өргөлөө. Зөвлөгч буцаж суудалдаа суугаад, чуулгын гишүүд нөгөөх итгэлтэй биш байсан үе тэнгийн гишүүндээ залбирлын тухай хэрхэн зааж, гэрчилж байгааг нь ажиглан, уг зорилтыг хүлээн авах итгэлийг түүнд төрүүлэхэд тусалж байгааг харж байлаа.

Тунгаан бодох асуултууд:
Багш нар ангийн гишүүдийг суралцах үйл явцад идэвхтэй үүрэг гүйцэтгэхийг ямар арга замаар урамшуулан дэмжихийг та харсан бэ? Та өөрийн ажилладаг залуучууддаа сайн мэдээг судлах дадлыг хөгжүүлэхэд хэрхэн тусалж чадах вэ? Ярилцлагаас гадна, сайн мэдээг судлахад залуучуудыг идэвхтэй оролцуулах өөр ямар арга замууд байна вэ?

Хөрвөлтийг урамшуулан дэмж

Хөрвөлт бол насан туршийн үйл явц бөгөөд сайн мэдээнээс өдөр бүр суралцах, түүгээр өдөр бүр амьдрах явдал мөн. Хөрвөлт

нь сайн мэдээний тухай зөвхөн мэдээд зогсохгүй, биднээс үйлдэл хийж өөрчлөгдөхийг шаарддаг.”³ Аврагч сайн самари хүний өрөвч нинжин сэтгэлийн тухай шавь нартаа заасны дараа тэдэнд, “Явж, үүний адил үйлдэгтүн” (Лук 10:37) гэжээ. Тэрбээр тэднийг зөвхөн үгийг сонсогчид байх төдийгүй, Түүний сургаалуудад итгэх итгэлээрээ үйлдэхийг нь урамшуулан дэмждэг байв.

Бид залуучуудыг сайн мэдээгээр амьдрахад шаргуу тэвчээртэй урамшуулан дэмжих ёстой. Учир нь хүн нэг удаа зааснаар хөрвөдөггүй. Бид тэднийг *Ирээд, Намайг дага* гэсэн урилгыг хэрэгжүүлэхэд нь урамшуулан дэмжсэнээр залуучууд үнэн сургаалыг ойлгож, сайн мэдээг судлах загварыг бий болгон, зөв шударга амьдарсан үед хөрвөлт хамгийн амжилттай болно.

Арапахое Колорадо гадасны Залуу Эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч Криста Уорник ийн ярьжээ: “Нас нэлээд ахисан үедээ ч миний сонсоогүй тийм олон сорилт өнөөдөр залуучуудад тулгарч байна. Би ихэвчлэн өөрөө бие дааж гэрчлэлээ хөгжүүлж, Залуу Эмэгтэйчүүдийн ангид сурсан зүйлсээ амьдралд хэрэгжүүлэх чадвартай болсон. Залуучуудад итгэлээ ашиглах боломж, нөхцөлийг бүрдүүлж өгөх нь бүр бага наснаасаа эхлэн тулгуур гэрчлэлтэй болж түүнийгээ хөгжүүлэхэд тэдэнд туслах болно.”

Хөрвөлтөд тулгардаг сорилт бол бид зөвхөн сайн мэдээнээс суралцах нь биш, харин сурч мэдсэн зүйлийнхээ ачаар өөрчлөгдөх явдал мөн. Залуучуудад зүрх сэтгэлийн “хүчит өөрчлөлт” (Алма 5:14) тэр дороо гардаггүй харин тэд байнга суралцах дадал хэвшлийг хөгжүүлж, үргэлж залбиран, зарлигуудыг сахисан үед алгуураар ирэх болно гэдгийг ойлгоход бид тэдэнд туслах хэрэгтэй. Тэд эдгээр

зүйлсийг хийснээр хүсэл сонирхол, зан харьцаа, ажил үйлсэд нь Тэнгэрлэг Эцэгийн хүсэл биеллээ олсныг мэдрэх болно.

Тунгаан бодох асуултууд:
Сайн мэдээнээс суралцаж, түүгээр амьдрах таны хүч чармайлтууд хөрвөлтөд чинь ямар үүрэг гүйцэтгэсэн бэ? Таныг эцэг эх, Сүмийн багш нар, удирдагчид чинь хэрхэн хүчирхэгжүүлсэн бэ?

Залуучуудаа дэмжих нь

Ирээд, Намайг дага гэсэн урилга нь залуучуудыг дэмжих хүч чармайлтын зөвхөн нэг хэсэг нь юм. Илүү бүрэн дүүрэн хөрвөхөд залуу хүн бүр өөрөө хариуцлага хүлээхээс гадна “хүүхдүүд нь Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү Есүс Христ хоёрыг мэдэхэд туслах үндсэн үүргийг эцэг эхчүүд хүлээдэг.”⁴ Бид залуучуудтай ажиллахдаа эцэг эхэд нь дэмжлэг үзүүлж, Аврагчийн үлгэр жишээг дагаснаар, сүнслэг байдлын хувьд бэлтгэлтэй байж, залуучуудын хэрэгцээнд анхаарал төвлөрүүлэн, сайн мэдээний үнэнүүдийг нээж илрүүлэхэд тэднийг урьж, итгэлээрээ үйлдэж, хөрвөгдөх боломжийг тэдэнд олгож чадна. Бид Есүс Христийн үлгэр жишээг дагахыг хичээснээр илүү сайн суралцагчид, улам сайн багш нар болж, ирээдүйн улс нийгмийн болон Сүмийн удирдагчдад хүчтэй суралцагчид, багш нар болоход нь тусалж чадна. ■

ЭШЛЭЛ

1. *Teaching the Gospel in the Savior's Way* (*Ирээд, Намайг дага: Залуучуудад зориулсан суралцах удирдамж*, 2012), 2.
2. Бонд К.Пакер, “Counsel to Youth,” *Лиахона* ба *Ensign*, 2011 оны 11-р сар, 16.
3. Даллин Х.Өүкс, “The Challenge to Welcome,” *Лиахона* 2001 оны 1-р сар, 40; *Ensign*, 2000 оны 11-р сар, 33.
4. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 20.1.

Залуучуудад зориулсан сургалтын шинэ материалын тухай
lds.org/youth/learn-д орж үзнэ үү.

Сүм Залуучуудад зориулсан сургалтын шинэ материалыг 2013 оноос хэрэглэж эхэлнэ.

9-р сарын Тэргүүн Зөвлөлийн захиас бичгээр залуучуудад зориулсан шинэ сургалтын материал болон *Ирээд, Намайг дага: Залуучуудад зориулсан суралцах удирдамжийг* Сүм даяарх багш нар, удирдагчид энэ сараас бүрэн хэрэгжүүлж эхлэх талаар зарласан билээ.

lds.org/youth/learn-өөс Залуу Эмэгтэйчүүд, Аароны санваартнууд болон Ням гарагийн хичээлийн багш нар, удирдагчид хичээлүүдийг 23 хэлээр олж үзэх боломжтой. Бүх хичээлийг хэвлэж авч болно. Интернетэд нэвтрэх боломжгүй хүмүүс *Ирээд, Намайг дага* сургалтын шинэ материалыг хэрхэн олж авах талаар орон нутгийн санваартны удирдагчидтай холбоо барих ёстой.

“Сургалтын шинэ материал нь сайн мэдээний үндсэн сургаалуудыг Аврагчийн арга барилаар заах зарчмуудаар авч үзсэн юм” хэмээн Тэргүүн Зөвлөлийн захидалд өгүүлжээ. Есүс Христийн сайн мэдээнд бүрэн дүүрэн хөрвөхөөр чармайж байгаа залуучуудад

сургалтын энэхүү шинэ материал адислал болно гэдэгт бид итгэлтэй байна.

Ирээд, Намайг дага сургалтын шинэ материалаар энэ жил сар бүр сургаалын нэг сэдвийг үзэх бөгөөд Ням гарагийн хичээл, Залуу Эмэгтэйчүүд, Аароны санваартны ангиуд сар бүр тухайн сарын сэдвийг судлах болно.

Хичээл бүр нь: багш нарын сүнслэг бэлтгэл, сэдвийг заах санаанууд, үйл ажиллагааны санаанууд, залуучуудад өгөх үйл ажиллагааны урилга гэсэн дөрвөн хэсэгтэй. Хичээлүүдийг суралцагчдынхаа хэрэгцээнд тохируулан сонгож, өөрчлөн заахын тулд сүнсний удирдамжийг эрж хайдаг байхыг багш нараас хүсч байна.

Цахим хуудас нь Сургалтын шинэ материалыг баяжуулан тайлбарлаж, суралцах үйл ажиллагаанд идэвхтэй оролцоход бэлтгэх болон *Сайн мэдээг Аврагчийн арга барилаар заах нь* шинэ удирдамжийг сургалтанд нэвтрүүлэх тухай үр өгөөжтэй санаануудыг агуулсан видеонуудыг мөн багтаасан болно. ■

РЭГЭЛ ЗУРГИЙГ Ж.ТОМАС



Африк орон даяар зохиогдсон Мормон Тусламжийн Гар төсөлд сүмийн гишүүд оролцон, үнэ цэнэтэй үйлчлэл үзүүлж, бусад сүмүүдтэй харилцаа тогтоон, Сүмийг олон нийтэд танилцуулж, энэрлийн гэрчлэлээ өсгөн нэмэгдүүлсэн байна.

Африк даяарх Жил тутмын үйлчлэлийн зургаа дахь өдөр

2012 оны 8-р сарын 18-ны бямба гарагт Африкийн зургаагаас долоон оронд мянга мянган Гэгээнтнүүд жил бүр зохиогддог Бүх Африкийн Мормон Тусламжийн Гар өдөрт зургаа дахь удаагаа оролцлоо.

“Тойрог, салбарууд бүгд онцгой үйлчилгээ үзүүлээ. Тэд түншүүдийг урьж, үлэмж хүнд ч, үнэхээр ашигтай төслийг сонгосон ажээ. Тэд туслахын тулд үлэмж санаа тавин олноороо хүрч ирэн, Сүмд жинхэнэ найз нөхөдтэй боллоо” гэж олон нийттэй харилцах номлогч ахлагч К.Терри Уорнер э-мэйлээр бичжээ.

Баруун Африкийн Бүсийн Олон нийттэй харилцах албаны захирал Ахлагч Адесина Ж.Олуканни үйлчлэлийн өдрийн тухай, “Энэ бол хөршүүддээ найрсаг хандаж, тэдний хэрэгцээг шийдвэрлэхэд туслах, авахаасаа илүү өгдөг байх тухай бошиглогчийн дуудлагад бидний хариулж болох хамгийн хялбар арга зам мөн. Энэ бол сайн мэдээг үлгэр жишээгээр заах хамгийн хялбар арга зам” хэмээн хэллээ.

Мормон.org одоо 20 хэлээр орчуулагдаад байна

Mormon.org одоо англи, армян, герман, индонези, испани, итали, латви, нидерланд, орос, польш, португаль, себуано, солонгос, тагалог, тай, украин, франц, хятад, швед, япон хэлээр орчуулагдаад байна.

Хувь хүмүүсийг өөрийн сайн мэдэх хэлээр Mormon.org хувийн файл нээж, түүнийгээ бусадтай хуваалцахыг уриалж байна.



Жинхэнэ ач ивээлийн үйлдэл

2012 оны 4-р сарын дугаарт нийтлэгдсэн Ахлагч Давид А.Беднарын “Цагаатгал ба мөнх бус амьдралын аян,” Кристен Николе Кардоны “Гайхамшигтай ач ивээл” (хуудас 10) өгүүллүүдийг уншаад миний сэтгэл үнэхээр их хөдөлсөн. Бидний мөнх бус амьдрал дахь болон мөнх амьдралын төлөөх зорилгод жинхэнэ ач ивээлийн гүйцэтгэх үүргийн тухай миний асуултууд төгс байдлаар хариулагдсан юм. Миний ойлголт мэдлэгийг их нэмэгдүүлсэн эдгээр өгүүллүүдийн төлөө би талархалтай байдаг бөгөөд би тэдгээрийг дахин дахин тунгаан боддог.

Эммануел Аду-Гиамфай, Гана

Залруулга

2012 оны 1-р сарын Тэргүүн Зөвлөлийн Захиас бичигт “Элбэг хангалуун амьдрах нь” өгүүлэлд бид Мэри Анн Радмачердын эшлэлийн тодотголыг орхигдуулсан байна. Уг эшлэл *Лиахонагийн энэ дугаарын 5-р хуудсан дээр байгаа*. Хатагтай Радмачерын анхны эшлэл нь “Зориг нь өдрийн төгсгөлд заримдаа “Маргааш дахин оролдоод үзье дээ” гэх намуухан дуу хоолой байдаг” гэсэн байжээ. Энэ эшлэл бас Хатагтай Радмачерын бусад бүтээлд, түүний дотор *Courage Doesn't Always Roar (2009)*-д байдаг. Бид анхааралгүй хандсанаа төлөө уучлал гуйж байна.

Энэ дугаарт гэр бүлийн үдэшт ашиглах өгүүлэл, үйл ажиллагаануудыг бичсэн байгаа. Зарим жишээг доор өгөв:



“Бурханы гайхалтай мэргэн ухаан,” хуудас 20: Дэлхийн мэргэн ухааныг Бурханы мэргэн ухаантай харьцуулж ярилц. Та 2 Нифай 9:28–29-ыг уншиж, дэлхийн мэргэн ухаан сайн мэдээний заадаг мэргэн ухаанаас өөр байдаг нөхцөл байдлуудын тухай бодохыг суралцагчдаас хүсч болно. Дээрх нөхцөл байдал бүрд аль мэргэн ухааныг дагахаа шийд.

“2013 оны Мючелийн сэдэв,” хуудас 50: 2013 оны Мючелийн сэдвийн тухай Элайн С.Далтон, Давид Л.Бек нарын өгүүллүүдийг унш. Гэр бүлийн гишүүн бүр гэр орноо аз жаргалтай газар болгоход туслах арга замын тухай тунгаан бодоход тэднийг урь. Та ариун сүмийн зургийг гэртээ тавьж, гэр бүлээрээ ариун сүмд явах зорилго тавьж болно.

“Байнга дадлага хий,” хуудас 56: Гэр бүлийнхээ авьяас чадварын шоу

зохион байгуулалтыг бод. Гэр бүлийн гишүүн бүр ур чадвар болон хийсэн зүйлээ үзүүлж бусадтай хуваалцахаар бэлтгэхийг зөвлө. “Байнга дадлага хий” өгүүллийг уншсаны дараа, авьяас чадвараа хөгжүүлж, бусадтай хуваалцах нь бидний эргэн тойрон дахь хүмүүсийг хэрхэн адисалж болох тухай ярилц.

“Ариун сүмийн тухай Эвелиний гэрчлэл,” хуудас 70: “Гэр бүлийн гэрчлэлийн” дүрслэл зураг гарга. Зургуудыг өрөөнд байрлуулж, өөрийн итгэдэг зүйлсийг дүрсэлсэн зургуудыг гэр бүлийн гишүүдээр сонгуул: жишээ нь өөрийн чинь гэр бүлийн зураг, ариун сүм, Ерөнхийлөгч Томас С.Монсонгийн болон баптисмын зураг, аравны нэгийн хуудас, даруухан хувцасласан залуучуудын зураг байж болно. Та яагаад эдгээр бүх зүйлд итгэдэг болохоо ярьснаар хичээлээ дуусгаж болно.

Харанхуйд заасан хичээл

Аравдугаар сарын нэг өдөр гэр бүлийн үдшийн үеэр байн байн сахилгагүйтдэг манай охин Жулия, “Бид гэр бүлийн үдшээ харанхуйд хийж огт үзээгүй ш дээ. Ингэж болох уу?” гэж асуув. Бид түүнд харанхуйд юуг, хэрхэн заах билээ хэмээн гайхан бодож билээ.

Гэрлийг унтраахад харанхуй биднийг нөмрөн авлаа. Тэгтэл манай нөхөр гар утсаа асааж, Христийн Гэрлийн тухай зааж эхлэв. Христийн Гэрэл биднийг хэрхэн харанхуйгаас гаргаж, гэр бүлээрээ Түүнд эргэж очиход биднийг хэрхэн удирддагийг харуулав. Гар утасны гэрэл төдийлөн хурц биш ч, уншиж байгаа зүйлээ харж болохоор байв.

Гар утасны гэрэл үе үе автоматаар унтарч байсан ч Аврагч Есүс Христгүйгээр бидний амьдрал ямархуу байх байсныг бид охиндоо харуулж чадсан юм. Сүнс хүчтэй мэдрэгдэж, охин маань маш их хүндэтгэлтэй болж билээ. Бүр одоо ч гэсэн тэрээр гэр бүлийн тэр үдшийг болон заагдсан захиасыг санасаар байдаг.

Валквириа Лима дос Сантос, Бразил

ТАВАН МИНУТЫН СУРГАМЖ

Кристофер Ж. Смит

Би их сургууль төгсөх жилийн эцсээр Уламжлалт малгай, нөмрөг өмссөн бүх шинэ оюутнууд оролцох төгсөлтийн ёслолын ажиллагаанд оролцож, өндөр албан тушаалтай хүнээс дипломоо гардаж авах ёстой байлаа. Дөрвөн жилийн шаргуу сурлага хөдөлмөрийн үр дүнгээ үзэх энэхүү агшныг би тэсч ядан хүлээж байлаа. Ёслолын өглөө би их сургуулиас нэг захидал хүлээн авсан ч задалж үзэх зав байсангүй.

Ёслолын ажиллагаа 1:30-д эхлэх ёстой байв. Харин би үүнээс өмнө амжиж цээж зураг авахуулах хэрэгтэй байв. Харамсалтай нь гэрэл зургийн газар олон хүнтэй дараалал бий болсон байлаа. Ёслол эхлэх цаг ойртох тусам чаг чаг цохилох цаг руугаа би ойрхон ойрхон харсаар зогсож байлаа. Нэлээд удаан хүлээх шаардлагатай болсон ч би зургаа авахуулахаар шийдэв. Тэгээд ёслол эхлэхээс 10 минутын өмнө зургаа аваад ёслол болох танхим руу харайлгав.

Гэтэл намайг танхим руу хүрч ирэхэд хаалгануудыг хааж, харуулууд хамгаалалтанд гарсан байлаа. Намайг оруулчихаач гэж гуйсан ч, харуулууд татгалзаж, намайг 15 минутын өмнө ирж суудлаа эзэлсэн байх ёстой гэв. Ийм журмын тухай би анх удаа сонссон болохоор эсэргүүцсэн ч, харуулууд намайг оруулсангүй. Би их сургуулийн диплом авах гэж дөрвөн жил шаргуу хөдөлмөрлөсөн ч, дипломоо ёслолын үйл ажиллагаанд дээр хүлээн авч чадсангүй. Ингээд би бусад хүмүүсийн хамт хүлээлгийн танхимд суухаас аргагүй болов.

Гэртээ эргэж ирээд өглөө хүлээж авсан нөгөөх захидлыг задалж уншвал, ёслолын үйл ажиллагаа эхлэхээс 15 минутын өмнө суудлаа эзлэхгүй бол танхимд оруулахгүй гэсэн тодорхой заавар байлаа. Тэгээд би өөрийгөө Аврагчийн сургаалт зүйрлэлд гардаг



Ердөө тавхан минут хожигдсоноос болоод би суудалгүй хоцров. Ийн хожигдсон ч би их сургуулийн төгсөлтийн ёслолдоо оролцохоор шийдсэн.

мунхаг онгон охидын нэгтэй адилтган бодов:

“[Мунхаг онгон охидыг] худалдаа хийхээр явсан хооронд хүргэн ирээд бэлэн болсон хүмүүс хүргэний хамт хуримын найранд оров. Тэгээд хаалгаа хаажээ.

“Дараа нь бусад охид ирж, Эзэн, Эзэн бидэнд онгойлгож өгөөч” гэхэд харин тэр хариуд нь “Үнэнээр би та нарт хэлье. Би та нарыг танихгүй” (Матай 25:10–12) гэв.

Чухал ёслолын ажиллагаанд оролцож чадаагүй нь миний гаргасан ялихгүй алдааны ноцтой үр дагавар мэт боловч энэ нь чухамдаа буруу сонголт ба муу үр дагавартай болохыг би ойлгосон билээ. Газарт байгаа савааны нэг үзүүрээс барьсан бол нөгөө үзүүрийг нь бас л хөдөлгөж таарна. Үүнтэй адил би зөвхөн үйлдлийг төдийгүй уг үйлдэлтэй холбоотой, нүдэнд үл харагдах үр дагаврыг бас сонгодог.

Үр дагаврыг нь харгалзахгүйгээр сонголт хийдэг байхыг Сатан биднээс хүсдэг. Тэр биднийг махан биеийн дур хүсэл буюу “маханбодийн тааллыг” (2 Нифай 2:29) бүхний түрүүнд тавьж, сэтгэл ханамжийг тэр дороо олоход олонтоо уруу татдаг.

Үүний эсрэгээр Тэнгэр дэх бидний Эцэг аз жаргал болон мөнхийн адислалууд дээр анхаарал төвлөрүүлэхийг биднээс хүсэн хүлээдэг. Тэрбээр биднийг шийдвэр гаргахдаа үр дагаврыг нь хүсэл эрмэлзэл буюу зорилгынхоо хэсэг болгодог байхыг биднээс хүсэн хүлээдэг: “Мөн тэд бүх хүмүүний агуу их Зуучаар дамжуулан, эрх чөлөө болон мөнх амьдралыг эсвэл боолчлол болон үхлийг сонгох эрхтэй;” (2 Нифай 2:27).


Би дипломоо албан ёсоор гардан авч чадаагүй нь харамсалтай ч, энэ явдал Хүргэн Хүүг хүрч ирэхэд түүгээр баяртайгаар хүлээн авагдахад саад болох сонголтыг хэзээ ч хийхгүй байх мөнхийн хүслийг надад заасан болохоор би үүнд нь талархалтай байдаг билээ. “Би та нарыг танихгүй” гэж Түүнийг хэлэхэд хаалганы гадна үлдэхгүй байж, харин Тэрээр “Эзнийхээ баяр баясгаланд ор” (Матай 25:21) гэж хэлэхийг сонсох боломжийг надад олгох сонголтууд хийхийг би ямагт хичээх болно. ■



ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ Р. ТВАРРЕТ

ИОСЕФ СМИТ

Иосеф Смит аль сүм үнэн болохыг мэдэхийн тулд **залбирахдаа** 14-тэй байлаа. Тэнгэрлэг Эцэг Есүс Христ хоёр түүн дээр хүрч ирэхэд дэлхий дээрх сүмүүдээс алинд нь ч үнэн бүрнээрээ байхгүйг тэр мэдсэн юм. Иосеф Смит Есүс Христийн үнэн сайн мэдээг сэргээхэд тусалсанаараа хожмын үеийн анхны бошиглогч болсон билээ. Тэрбээр ажлынхаа нэг хэсэг болгон Мормоны Номыг **алтан ялтсуудаас** орчуулж, энэ эрин үеийн анхны ариун сүм, **Көртландын Ариун сүмийг** барихад Гэгээнтнүүдийг удирджээ.



Өр сүмийн нэг үйлчлэгч
Ерөнхийлөгч Лорензо Снөү-
тэй уулзсаны дараа ингээж
бичсэн байдаг: “Түүний нүүрэнд амар
амгалангийн хүч гэрэлтэн дэргэд нь
байхад амар амгалан мэдрэгдэнэ.
Түүний дөлгөөхөн харцанд ‘нам гүм-
хэн залбирал’ төдийгүй, сүнсний хүч
чадал илхэн харагдана. . . Би үнэ-
хээр ‘ариун газар дээр зогсож байна
уу даа’ гэсэн хачирхмаар мэдрэмж
надад төрж билээ.” “Даршилсан
өргөст хэмх, манжин ба гэрчлэл: Ло-
рензо Снөүгийн амьдрал ба сургаалын
сүнслэг нөлөө,” х.12-ыг үзнэ үү.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

